



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН ХӨТӨЛБӨР

Чинос

Баяндалайн БОЛОР-ЭРДЭНЭ

**ИРГЭД ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ
ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ
МАРГААНЫ ШАЛТГААН, ШИЙДВЭРЛЭХ АРГА
ЗАМ**



Мэргэжлийн индекс
042103

Бизнесийн эрх зүйн
Мастерын зэрэг горилсон судалгааны ажил

Удирдсан
Ю.Хорлоо /Ph.D/

Улаанбаатар. 2026



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН ХӨТӨЛБӨР

Чинос
Баяндалайн БОЛОР-ЭРДЭНЭ

ИРГЭД ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ
ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ
МАРГААНЫ ШАЛТГААН, ШИЙДВЭРЛЭХ АРГА
ЗАМ



Мэргэжлийн индекс
042103

Бизнесийн эрх зүйн
Мастерын зэрэг горилсон судалгааны ажил

Удирдагч: Ю.Хорлоо /Ph.D/

Улаанбаатар. 2026

ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭХ ХУУДАС	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	v
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	vii
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	viii
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	ix
НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР.....	x
УДИРТГАЛ	1
Судалгааны ажлын үндэслэл	1
Судлагдсан байдал.....	2
Судалгааны ажлын зорилго, зорилт.....	4
Судалгааны арга зүй.....	5
Судалгааны ажлын бүтэц, зохион байгуулалт.....	6
БҮЛЭГ 1. ОНОЛЫН ТОЙМ.....	7
1.1 Гэрээний эрх зүйн онол, онцлог шинж.....	7
1.1.1 Гэрээний ойлголт, төрөл үндсэн шинжүүд.....	7
1.1.2 Зээл, зээлийн гэрээний ойлголт, онцлог	8
1.1.3 Хувийн эрх зүйн гэрээний үндсэн шинж, суурь зарчмууд	10
1.1.4 Гэрээний үүргийн гүйцэтгэлийн онол.....	12
1.2 Зээлийн гэрээний харилцааны итгэлцэл, зан төлөв ба хэрэгжилтийн онол.....	14
1.2.1 Итгэлцлийн онол (Trust Theory)	15
1.2.2 Зан төлөвт суурилсан эрх зүй, эдийн засгийн онол (Behavioral Law and Economics)	16
1.2.3 Албан ёсны ба албан бус хэрэгжилтийн онол (Formal vs Informal Enforcement Theory)	17
БҮЛЭГ 2. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	20
2.1 Монгол улс дахь зээлийн гэрээний эрх зүйн зохицуулалт	20
2.1.1 Зээлийн гэрээний эрх зүйн үндсэн зохицуулалт	20
2.1.2 Зээлийн гэрээтэй холбоотой гол хууль тогтоомж.....	20
2.1.3 Иргэд хоорондын зээлийн гэрээ, үүргийн гүйцэтгэлийн онцлог	23
2.2 Иргэд хоорондын зээлийн гэрээний маргааны өнөөгийн байдал	26

2.3 Монгол улсын нийгмийн итгэлцлийн өнөөгийн байдал.....	30
2.4 Гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт	31
Бүлгийн дүгнэлт.....	35
БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ.....	36
3.1 Судалгааны хүрээ, арга зүй.....	36
3.2 Мэдээлэл цуглуулах болон шинжилгээ хийх.....	37
БҮЛЭГ 4. ЭМПИРИК СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ БА ҮР ДҮН	40
4.1 Өгөгдлийн шинжилгээ	40
4.1.1 Найдвартай байдлын шинжилгээ / Reliability Analysis /	40
4.1.2 Тодорхойлогч статистикийн шинжилгээ	41
4.1.3 Хамаарлын шинжилгээ	44
4.1.4 Корреляцийн шинжилгээ.....	57
4.1.5 Логистик регрессийн шинжилгээ /Logistic Regress/	58
4.2 Шинжилгээний үр дүн	72
4.3 Шүүн хэлэлцэхүй.....	76
Бүлгийн дүгнэлт.....	78
ДҮГНЭЛТ.....	79
САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	81
НОМ ЗҮЙ.....	ix
ХАВСРАЛТ.....	xii

МЭДЭГДЭХ ХУУДАС

Энэ дипломын төслийг өөрийн оюуны бүтээл болохыг баталгаажуулж, зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй болохыг баталж байна. Энэхүү дипломын төслийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг би дангаар эзэмшинэ.

Санхүү эдийн засгийн их сургууль (СЭЗИС) энэхүү бүтээлийг сургалт, судалгаа, ашгийн бус зорилгоор, зохиогчийн эрхийн зөрчлөөс сэргийлэх үүднээс олон улсын creative commons attribution-noncommercial-noderivs (CC BY-NC-ND) лицензийн дагуу ашиглах эрхтэй.

Магистрантын нэр:

Б.Болор-Эрдэнэ

Гарын үсэг:

Огноо: 2026.06

ТАЛАРХАЛ

Тус мастерын судалгааны ажлыг гүйцэтгэхэд үнэт цаг, зөвлөмж өгсөн судалгааны ажлын удирдагч багш Ю.Хорлоо (Ph.D) болон Ж.Даваасүрэн (LL.M) нартаа гүнээ талархахын зэрэгцээ, мэргэжлийн багш, сургалтын алба, номын сангийн хамт олонд талархал хүргүүлж байна.

Сурах үйлсийг маань дэмжсэн хайрт гэр бүл, ангийн болон ажлын хамт олон, найз нөхдөд гүн талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Нийгмийн өдөр тутмын амьдралд тогтсон хэв маягийн дагуу байнгын шинжтэйгээс гадна талуудын амлалт, итгэлцэлд тулгуурладаг харилцааны нэг хэлбэр нь иргэд хоорондын зээлийн харилцаа байдаг. Иргэд хоорондын зээлийн харилцаа нь гэрээний чөлөөт байдал буюу гэрээний эрх чөлөөний болон үүргээ үнэнч шударгаар биелүүлэх, харилцан итгэлцлийг хүндэтгэх зарчмуудад суурилан ихэвчлэн танилын хүрээнд үүсдэг онцлогтой байдаг. Гэвч Монгол улсын шүүн таслах ажиллагааны сүүлийн 5 жилийн тайлангаас үзэхэд иргэд хоорондын зээлийн маргаан 12.5 дахин өссөн, 2025 оны байдлаар нийт иргэний хэрэгт 10.2 хувийг дангаар эзэлж байна. Энэхүү маргааны өсөлт нь иргэдийн дунд үнэнч шударга байх зарчим (good faith) алдагдаж байгаатай холбоотой бөгөөд маргааны шалтгааныг зан төлөвийн хандлага, нөлөөлөлтэй уялдуулан, эмпирик судалгааны аргаар судлахыг зорьсон болно. Судалгаагаар нийт шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн 138 кейст хийсэн эмпирик шинжилгээний үр дүнгээр маргаан үүссэн шалтгааны 18.1 хувь нь зээлдэгчийн санхүүгийн чадваргүй байдалтай холбоотой, үлдсэн хувь нь зээлдэгчийн зан төлөв, хандлага, гэрээний тодорхойгүй байдал болон баримтжуулалт сул зэрэг хүчин зүйлстэй холбоотой байна. Иймээс иргэд хоорондын зээлийн маргааныг бууруулахад зээлдэгчийн санхүүгийн сахилга бат, үүргийн гүйцэтгэлийг дэмжих чиглэлээр Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох, гэрээний тодорхой байдлыг хангах, бичгээр баримтжуулах болон гуравдагч этгээдийн оролцоог гэрээнд тодорхой тусгах шаардлагыг нэмэгдүүлэх, бага дүнтэй зээлийн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг урьдчилсан заавал шат болгон хэрэгжүүлэх, хувийн эвлэрүүлэн зуучлах төвийн шийдвэрийг биелүүлэх эрх зүйн хэрэгжилтийг боловсронгуй болгох, иргэдийн эрх зүйн мэдлэг, гэрээний соёл болон зан төлөвийн эрсдэлийг ойлгох санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх нь үр дүнтэй гэж дүгнэж байна.

Түлхүүр үг: иргэд хоорондын зээлийн маргаан, зан төлөвийн хүчин зүйлс, итгэлцэлд суурилсан харилцаа, үнэнч шударга байх зарчим, гуравдагч этгээдийн оролцоо.

ABSTRACT

Interpersonal loan relationships constitute a form of social interaction that is both routine and recurrent in everyday life, typically grounded in mutual promises and trust between the parties. Such relationships are generally based on the principles of freedom of contract and good faith, and they commonly arise within informal networks of acquaintances. However, according to judicial statistics from Mongolia over the past five years, disputes arising from interpersonal loan relationships have increased by 12.5 times and, as of 2025, account for 10.2% of all civil cases. This significant rise in disputes indicates a weakening of the principle of good faith among individuals and underscores the necessity of examining the causes of such disputes in connection with behavioral attitudes and influences through empirical research methods.

The study conducted an empirical analysis of 138 court cases that had been finally adjudicated. The findings reveal that only 18.1% of the disputes were related to the borrower's financial incapacity, whereas the remaining disputes were associated with factors such as borrowers' behavioral attitudes, ambiguity in contractual terms, and insufficient documentation.

Accordingly, the study concludes that reducing disputes arising from interpersonal loan relationships requires improving the relevant provisions of the Civil Code to strengthen borrowers' financial discipline and promote the proper performance of obligations; ensuring greater contractual clarity; reinforcing written documentation requirements and the explicit inclusion of third-party involvement in agreements; introducing mandatory pre-trial mediation procedures for small-value loan disputes; enhancing the enforceability of decisions issued by private mediation centers; and improving citizens' legal awareness, contractual culture, and financial literacy concerning behavioral risks.

Abstract: *Interpersonal loan disputes, behavioral factors, trust-based relationships, good faith principle, third-party involvement.*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Сэдвийн судлагдсан байдал.....	2
Хүснэгт 2. Гэрээний түүхэн хөгжил	7
Хүснэгт 3. Иргэний хэрэг, түүнд эзлэх зээлийн хэрэг маргааны тоо, өсөлт	26
Хүснэгт 4. ИХ-ийн шүүхээр шийдвэрлэсэн зээлийн маргааны шийдвэр	29
Хүснэгт 5. Хувьсагчдын ангилал	38
Хүснэгт 6. Судалгааны найдвартай байдал (Reliability Statistics).....	40
Хүснэгт 7. Тодорхойлогч статистикийн шинжилгээ (Descriptive Statistic)	41
Хүснэгт 8. Давтамжийн шинжилгээ (Frequencies Statistic)	42
Хүснэгт 9. ТТ хувьсагчдын тархалт (Frequencies Statistic).....	43
Хүснэгт 10. BLE хувьсагчдын тархалт (Frequencies Statistic).....	43
Хүснэгт 11. FIE хувьсагчдын тархалт (Frequencies Statistic).....	44
Хүснэгт 12. Байршил ба шалтгааны хамаарал /Chi-Square test/	45
Хүснэгт 13. Зээлийн хэмжээ ба шалтгааны хамаарал /Chi-Square /	46
Хүснэгт 14. Гэрээ * шалтгааны хамаарал /Chi-Square/	47
Хүснэгт 15. Барьцаа * шалтгааны хамаарал /Chi-Square/	48
Хүснэгт 16. ТТ1 * шалтгааны хамаарал /Chi-Square/.....	49
Хүснэгт 17. ТТ2 * шалтгааны хамаарал /Chi-Square/.....	49
Хүснэгт 18. ТТ3 * шалтгааны хамаарал /Chi-Square/.....	50
Хүснэгт 19. BLE1 * шалтгааны хамаарал /Chi-Square/	51
Хүснэгт 20. BLE2 * шалтгааны хамаарал /Chi-Square/	52
Хүснэгт 21. BLE3 * шалтгааны хамаарал /Chi-Square/	53
Хүснэгт 22. BLE4 * шалтгааны хамаарал /Chi-Square/	53
Хүснэгт 23. FIE1 * шалтгааны хамаарал /Chi-Square/.....	54
Хүснэгт 24. FIE2 * шалтгааны хамаарал /Chi-Square/.....	55
Хүснэгт 25. FIE3 * шалтгааны хамаарал /Chi-Square/.....	56
Хүснэгт 26. Корреляцийн шинжилгээний үр дүн (Correlations)	57
Хүснэгт 27. Суурь загварын нөхцөл /Classification Table ^{a,b} /	59
Хүснэгт 28. Загварын статистик ач холбогдол /Variables in the Equation/	59
Хүснэгт 29. Загварын статистик ач холбогдол /Omnibus Tests of Model Coefficients/	59
Хүснэгт 30. Загварын чадвар /Model Summary/.....	60
Хүснэгт 31. Нарийвчилсан ангилал /Classification Table ^{a,b} /.....	60

Хүснэгт 32. Хувьсагчдын нөлөөлөл /Variables in the Equation/	61
Хүснэгт 33. Суурь ангилал /Classification Table ^{a,b} /.....	62
Хүснэгт 34. Суурь загварын тогтмол /Variables in the Equation/.....	62
Хүснэгт 35. Суурь загварын статистик ач холбогдол /Omnibus Tests of Model Coefficients/	62
Хүснэгт 36. Загварын тайлбарлах чадвар /Model Summary/	63
Хүснэгт 37. Бие даасан хувьсагчдын нөлөө /Reason 2/	63
Хүснэгт 38. Суурь ангилал /Classification table/	64
Хүснэгт 39. Суурь загварын тогтмол /Variables in the Equation/.....	65
Хүснэгт 40. Суурь загварын статистик ач холбогдол /Omnibus Tests of Model Coefficients/	65
Хүснэгт 41. Суурь загварын тайлбарлах чадвар /Model summary/	65
Хүснэгт 42. Нарийвчилсан ангилал /Classification table/	66
Хүснэгт 43. Хувьсагчдын нөлөөлөл /Variables in the Equation/	66
Хүснэгт 44. Суурь ангилал /Classification table/	67
Хүснэгт 45. Суурь загварын тогтмол /Variables in the EquationReason 4/.....	68
Хүснэгт 46. Суурь загварын статистик ач холбогдол /Omnibus Tests of Model Coefficients/	68
Хүснэгт 47. Суурь загварын тайлбарлах чадвар /Model Summary/	68
Хүснэгт 48. Суурь ангилал /Classification Table ^{a,b} /.....	69
Хүснэгт 49. Суурь загварын тогтмол /Variables in the Equation/.....	69
Хүснэгт 50. Суурь загварын статистик ач холбогдол /Omnibus Tests of Model Coefficients/	70
Хүснэгт 51. Суурь загварын тайлбарлах чадвар /Model Summary/	70
Хүснэгт 52. Нарийвчилсан ангилал /Classification table/	70
Хүснэгт 53. Хувьсагчдын нөлөөлөл /Variables in the Equation/	71
Хүснэгт 54. Гол хүчин зүйлсийн давхцал ба нөлөөлөл (n=138)	72
Хүснэгт 55. Таамаглалын үр дүн /эмпирик шинжилгээний үр дүнгээр/.....	74

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.Зээлийн гэрээний бүтэц	8
Зураг 2. Зээлийн гэрээний оролцогч талууд	9
Зураг 3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны динамик 2021-2025 он.....	27
Зураг 4. Маргааны төрөл, шүүхийн ачаалал 2021-2025 он.....	28
Зураг 5. Итгэлцлийн түвшин 2022 он	30
Зураг 6. Нийгмийн аль бүлэгт хамгийн их итгэдэг вэ?.....	31
Зураг 7. Байршлын хамаарал	46
Зураг 8. Зээлийн хэмжээний хамаарал	46
Зураг 9. Гэрээний хамаарал	47
Зураг 10. Барьцааны хамаарал.....	48
Зураг 11. ТТ1-ын хамаарал	49
Зураг 12. ТТ2-ын хамаарал	50
Зураг 13. ТТ3-ын хамаарал	51
Зураг 14. BLE 1-ын хамаарал	51
Зураг 15. BLE 2-ын хамаарал	52
Зураг 16. BLE 3-ын хамаарал	53
Зураг 17. BLE 3-ын хамаарал	54
Зураг 18. FIE1-ын хамаарал.....	55
Зураг 19. FIE2-ын хамаарал.....	55
Зураг 20. FIE3-ын хамаарал.....	56
Зураг 21. Маргааны үндсэн шалтгааны бүтэц (n=138)	72

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Шүүхэд хариуцагчийн гаргасан маргааны агуулга.....	xii
Хавсралт 2. SPSS шинжилгээний үр дүнгүүд.....	xxiv

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол

Тайлбар

ББСҮАтХ

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль

БЭБЭМХМХШЗҮАтХ

Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль

ЗМС

Зээлийн мэдээллийн сан

ЗМтХ

Зээлийн мэдээллийн тухай хууль

ИХ

Иргэний хууль

ИХАШШ

Иргэний хэргийн анхан шатны шүүх

ИХШХШтХ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

МЗҮАтХ

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хууль

ОХУ

Оросын Холбооны Улс

СЗХ

Санхүүгийн зохицуулах хороо

УДШ

Улсын дээд шүүх

ХЗХтХ

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль

ХЗДХЯ

Хууль зүйн, дотоод хэргийн яам

ШЕЗ

Шүүхийн ерөнхий зөвлөл

ЭЗтХ

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Нэршил

Зээлдэгч

Тайлбар

Эд хөрөнгө өмчлөлдөө шилжүүлэн авч зохих хугацааны дараа ижил төрөл, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө, мөнгийг буцаан өгөх үүрэг бүхий этгээд

Зээлдүүлэгч

Зээлдэгчийн өмчлөлд мөнгө, бусад эд хөрөнгө шилжүүлэн, тодорхой хугацааны дараа ижил төрөл, тоо чанарын эд хөрөнгө шаардах эрх бүхий этгээд

Зээлийн хүү

Мөнгөн зээлийн гэрээгээр талууд тохиролцон тодорхой хувь, хэмжээгээр тогтоосон хариу төлбөр буюу мөнгөн дүн

Зээлийн барьцаа

Зээлдэгч зээлийн гэрээнд заасан хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэл хангуулахаар зээлдэгчээс барьцаалсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх

Эвлэрлийн гэрээ

Талууд эвлэрсэн тохиолдолд нэхэмжлэлийн нийт шаардлага буюу тодорхой хэсгийн талаар харилцан тохиролцож, шүүхийн өмнө байгуулсан тохиролцоо

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

Талуудын хооронд үүссэн маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэхэд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу дэмжлэг үзүүлэх зорилго бүхий эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа

Эрсдэл

Иргэний эрх зүйд хүний хүсэл зоригоос үл шалтгаалан байгалийн ба гэнэтийн аюул осол тохиолдох үед учрах хохирол

Субъектив эрсдэл

Өгөгдсөн үйл баримтын дүнд сэтгэл санаа зовинох, эргэлзээ төрөх, хувь хүний сэтгэл санаа, оюун ухаантай холбогдож гарах эрсдэл

Эрх зүйн хийдэл

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд хамаарагдах харилцааг журамлахад зайлшгүй шаардлагатай хэм хэмжээ байхгүй байх

Descriptive

Тодорхойлогч статистикийн шинжилгээ

Frequency

Давтамжийн шинжилгээ

Crosstabs & Chi-Square

Хос хувьсагчийн хамаарлын шинжилгээ (хувьсагчдын хоорондын хамаарал статистикийн ач холбогдолтой эсэх)

Корреляцийн шинжилгээ (Correlation Analysis)

Хувьсагчдын хоорондын хамаарлын чиглэл, хүчийг тодорхойлох

Регрессийн шинжилгээ (Binary Logistic Regression) шинжилгээ

Тодорхой маргааны төрөл үүсэх магадлалд аль хувьсагчид хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох

УДИРТГАЛ

Судалгааны ажлын үндэслэл

Нийгмийн өдөр тутмын харилцаа хэвийн, тогтвортой өрнөхөд хүмүүсийн харилцан тохирсон амлалт, үүргээ биелүүлэх хандлага чухал үүрэгтэй байдаг. Монгол ахуй, уламжлалт соёлын хүрээнд ам өгөх, андгай тангараг өргөх, тохиролцоогоо сахих зэрэг нь зөвхөн ёс суртахууны ойлголт бус, харилцан итгэлцэлд суурилсан албан бус гэрээний баталгаа болж ирсэн уламжлалтай. Энэ нь нийгмийн харилцаанд нэр төр, хариуцлага, үнэнч шударга байх зарчмыг төлөвшүүлэх үндэс болж байжээ.

Орчин үеийн нийгэмд иргэд хоорондын мөнгөн зээлийн харилцаа нь өдөр тутмын амьдралд өргөн түгээмэл тохиолддог бөгөөд ихэвчлэн гэр бүлийн хүрээлэл, найз нөхөд, танилын холбоо, харилцан итгэлцэл, амлалт, тохиролцоонд тулгуурлан үүсдэг онцлогтой. Ийм харилцаанд талуудын “итгэлцэл” нь гэрээ байгуулах үндсэн нөхцөл болж, ихэнх тохиолдолд албан ёсны баримтжуулалт, баталгаа сул байдаг. Гэвч сүүлийн жилүүдэд зээлийн үүргийн гүйцэтгэлээс зайлсхийх, амалсан амлалтаа биелүүлэхгүй байх, гэрээний нөхцөлийг маргах зэрэг зан үйл нэмэгдэж, иргэд хоорондын зээлийн маргаан шүүхийн практикт тогтвортой өсөх хандлагатай байна.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн статистик мэдээллээс үзэхэд иргэд хоорондын зээлийн гэрээтэй холбоотой маргаан сүүлийн таван жилийн хугацаанд 12.5 дахин өссөн бөгөөд 2025 оны байдлаар нийт иргэний хэргийн 10.2 хувийг дангаар эзэлж байна. Мөн Шүүн таслах ажиллагааны 2025 оны эхний хагас жилийн статистикт зээлийн гэрээний маргаан 6,844 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2,283 хэргээр буюу 50.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү өсөлт нь зөвхөн шүүхийн ачааллыг нэмэгдүүлэхээс гадна иргэдийн хоорондын итгэлцэлд суурилсан харилцаа албан ёсны эрх зүйн маргаан болон хувирч байгааг илтгэж байна.

Монгол Улсад иргэд хоорондын зээлийн гэрээний эрх зүйн үндсэн зохицуулалт нь Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль зэрэг эрх зүйн эх сурвалжаар зохицуулагдаж байна. Гэвч энэхүү маргааныг зөвхөн хууль хэрэглээний хүрээнд авч үзэх нь хангалтгүй бөгөөд иргэдийн гэрээ байгуулах соёл, нотлох баримт бүрдүүлэх дадал, зан төлөвийн хандлага, итгэлцэлд хэт тулгуурласан албан бус харилцааны онцлогтой уялдуулан судлах шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл, иргэд хоорондын зээлийн маргаан нь зөвхөн гэрээний үүрэг биелүүлээгүйтэй холбоотой эрх зүйн асуудал бус, харин талуудын зан төлөв, good faith буюу үнэнч шударга байх зарчим, итгэлцлийн түвшин, албан бус тохиролцооны хэрэгжилттэй холбоотой нийгэм-эрх зүйн нийлмэл үзэгдэл гэж үзэх боломжтой юм. Энэхүү судалгаанд “Trust Theory”, “Behavioral Law and Economics”, “Formal vs Informal Enforcement Theory” зэрэг онолын хандлагуудыг харилцан уялдуулан ашиглаж, маргаан үүсэх шалтгааныг зөвхөн эрх зүйн талаас бус зан төлөв, итгэлцэл, хэрэгжилтийн орчны хүрээнд шинжлэхийг зорьсон болно.

Иймд энэхүү судалгаагаар Монгол Улс дахь иргэд хоорондын зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой маргаан үүсэхэд нөлөөлж буй нийтлэг шалтгааныг онол, эрх зүй, шүүхийн практик болон эмпирик өгөгдөлд тулгуурлан тодорхойлж, уг маргааныг бууруулах, үр нөлөөтэй шийдвэрлэх боломжит арга замыг санал боловсруулах шаардлага, хэрэгцээ байгаагаар энэхүү судалгааны үндэслэл тодорхойлогдож байна.

Судлагдсан байдал

Зээлийн гэрээний эрх зүйн зохицуулалтын талаар судалсан судалгааны ихэнх нь банк, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн харилцаанд төвлөрсөн байна. Иргэд хоорондын зээлийн гэрээ, маргааны хувьд ихэвчлэн гэрээний хүчин төгөлдөр байдал, хүү, алданги, гэрээ цуцлах, үүргийн гүйцэтгэлийн дараалал, шүүхийн практик, хууль хэрэглээний алдаа зэрэг талаас судалсан байна. Харин иргэд хоорондын зээлийн онцлог, эрх зүйн зохицуулалт, зан төлөв, итгэлцлийн харилцааны уялдаа, маргааны шалтгааныг тодорхойлж бууруулснаар гарах ач холбогдолын талаар бие даасан судалгаа харахан хийгдээгүй байна.

Хүснэгт 1. Сэдвийн судлагдсан байдал

Судлаачийн нэр	Огноо	Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгаа	Судалсан агуулга
Улсын дээд шүүх	2016 он	Гэрээний зарим эрх зүйн маргааны хууль хэрэглээ болон гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахад анхаарах асуудлууд	Гэрээний эрх зүйн маргаанд нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг зөв тодорхойлох, гэрээнээс татгалзах ба гэрээг цуцлах зохицуулалтыг зөв хэрэглэх, Иргэний хуулийн ерөнхий ба тусгай ангийн уялдааг анхаарах асуудлыг системтэй тайлбарласан.
Улсын дээд шүүх	2020 он	Зээлийн харилцаанаас үүссэн маргааны шийдвэрлэсэн гүүхийн практик, анхаарах зарим асуудал	Хяналтын шатны иргэний шүүх хуралдааны тогтоолыг судалж, Иргэний хуулийн 281-283 дугаар зүйлийн заалтыг хууль хэрэглээний болон бусад алдааг тоймлон зөвлөмж гаргасан.
ХЗҮХ	2018 он	Мөнгөн зээлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын	Банк, банк бус санхүүгийн байгууллага болон иргэд хоорондын зээлтэй холбогдох хууль, Иргэний хуулийн

		талаарх харьцуулсан судалгаа	зохицуулалтыг тайлбарласан. Мөнгөн зээлийн үйл ажиллагааны талаарх БНСУ, Сингапур, Япон улсын эрх зүйн зохицуулалтыг судлахдаа санхүүгийн зах зээл, банк, банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, шаардлага, туршлагын талаар түлхүү дурдагдсан.
Б.Соёл-Эрдэнэ	2019 он	Монгол улсын Иргэний хууль дахь зээлийн гэрээний бодит шинжийн зохицуулалтын асуудал	Монгол Улсын Иргэний хуулийн 282.4 дүгээр зүйлд заасан заалтыг үндэслэн "хэрэглэгчийн" зээлийн гэрээг бодит шинж чанартай гэрээ гэж үздэг байдлыг бодит гэрээ гэж үзэж болох эсэхэд Япон Улсын Иргэний хуулийн холбогдох зохицуулалт, онол, хоёр орны шүүхийн шийдвэрийг харьцуулах замаар хариулт өгөхийг зорьсон. Уг өгүүлэл нь практик үүсэж буй маргааны нэг шалтгааныг тайлбарлах онолын үндэс болох боломжтой. Харин зээлийн гэрээний маргааны зан төлөв, итгэлцэлтэй уялдуулан судалсан хэсэг хязгаарлагдмал байна.
Mandukhai.G and others. Department of research and Development, Optimal NMax LLC.	2021 он	Effect of psychological factors on credit risk: A case study of the microlending service in Mongolia. Behavioral Sciences	Эдийн засаг, сэтгэл зүйн үзүүлэлтүүдийн регрессийн шинжилгээгээр хувь хүний дотоод хүчин зүйлс зээлийн төлбөрийн төлбөрийг таамаглахад материаллаг хүчин зүйлсээс илүү үр дүнтэй буюу хувь хүний зан үйл, дотоод хүчин зүйлс зээлийн эрсдэлд нөлөөлөх боломжтойг харуулсан. Монголчуудын зан

			байдал, онцлог, амьдралын хэв маяг, өр үүсгэх зан үйл, сэтгэл зүйн хүчин зүйлсийг илүү сайн ойлгоход чиглэсэн. Банк, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн эрсдэлийн үнэлгээнд онолын таамаглалыг батлах туршилтын судалгаа хийхэд зориулсан.
--	--	--	--

Эх сурвалж : Судлаачдын тодорхойлсноор

Судалгааны шинэлэг байдал - Энэхүү судалгааны ажлын гол онцлог нь иргэд хоорондын зээлийн гэрээний маргааныг зөвхөн Иргэний хуулийн зохицуулалтын хүрээнд бус, итгэлцэл, зан төлөв, албан бус хэм хэмжээ, нотлох баримтын бүрдүүлэлт, шүүхийн практик зэрэг хүчин зүйлсийн огтлолцолд авч үзнэ. Өөрөөр хэлбэл, гэрээний эрх зүйн уламжлалт шинжилгээг итгэлцэл, зан төлөвт суурилсан эрх зүйн онол, албан ба албан бус хэрэгжилтийн онолтой холбож, кейс шинжилгээний аргаар эмпирик баталгаажуулалт хийхийг зорьж буй нь тус судалгааны онцлог юм. Ийм хандлага нь иргэд хоорондын зээлийн маргааныг илүү бодитой, амьдралд ойр, олон хүчин зүйлт үзэгдэл болгон тайлбарлах боломжтой юм.

Судалгааны онолын ач холбогдол - Гэрээний эрх зүй, үүргийн эрх зүй, итгэлцлийн онол, зан төлөвт суурилсан эрх зүйн шинжилгээний уялдаа холбоог иргэд хоорондын зээлийн харилцааны жишээн дээр тодруулах ач холбогдолтой.

Судалгааны практик ач холбогдол - Иргэд хоорондын зээлийн гэрээ байгуулах соёлыг сайжруулах, нотлох баримт бүрдүүлэх дадлыг хэвшүүлэх, эвлэрүүлэн зуучлалын боломжийг өргөжүүлэх, шүүхийн практикт анхаарах асуудлыг тодорхойлоход чиглэсэн санал боловсруулах суурь болно. Түүнчлэн иргэдийн эрх зүйн боловсролыг сайжруулах, урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулах, бодлого боловсруулах түвшинд ашиглах боломжтой.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Судалгааны зорилго – Иргэд хоорондын зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой маргааны шалтгааныг эрх зүйн зохицуулалт, нийгмийн зан төлөвийн нөлөөг судалж, маргааныг бууруулах боломжит арга замыг тодорхойлох, сайжруулах санал зөвлөмжийг боловсруулах зорилготой. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

1. Иргэд хоорондын зээлийн гэрээний эрх зүйн зохицуулалт, шүүхийн практикаас маргааны нийтлэг шинж чанарыг судлах;
2. Иргэд хоорондын зээлийн гэрээний эрх зүйн зохицуулалтын онцлогийг тодорхойлох, эрх зүйн хэрэглээний практикийг судлах;
3. Маргааныг бууруулах боломжит арга замыг тодорхойлох, сайжруулах санал, зөвлөмжийг боловсруулах.

Судалгааны объект - Монгол улс дахь иргэд хоорондын зээлийн гэрээний харилцаа.

Судалгааны хамрах хүрээ - Монгол улсын иргэний зээлийн гэрээний эрх зүйн зохицуулалт, шүүхийн шийдвэрийн түүвэр, гадаадын зарим улсын Иргэний хуулийн иргэд хоорондын зээлийн зохицуулалтын товч харьцуулалт байна.

Судалгааны арга зүй

Сэдвийн хүрээнд дараах арга зүйг ашиглана. Үүнд:

Системчлэн судлах: Эрх зүйн болон итгэлцэл, зан төлөвт суурилсан эрх зүйн онол, албан ба албан бус хэрэгжилтийн онолын судлагдахууныг задлан шинжилж, холбон уялдуулах замаар нэгдсэн тогтолцоо, дараалалд оруулж цэгцтэй судлахад чиглэсэн.

Эрх зүйн догматик арга: Монгол улсын иргэний хуулийн 281-285 дугаар зүйлийн иргэд хоорондын зээлийн гэрээтэй холбоотой зохицуулалтыг тайлбарлахад ашиглав.


Эрх зүйн прагматик арга: Зээлдэгч зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэл хангахгүй байгаа бодит шалтгаан, нөхцөл, зан төлөвийн хүчин зүйлсийг шүүхийн шийдвэрт тулгуурлан судлаж, эрх зүйн зохицуулалтын хэрэгцээг илрүүлэхэд ашиглав.

Кейс судалгааны арга: 2021-2025 оны хооронд Хяналтын шатны шүүхээр хэлэлцэн шийдвэрлэсэн, Иргэний хуулийн 281 дүгээр зүйлд заасан иргэн хоорондын зээлийн гэрээний үндсэн шинжийг хангасан маргаантай холбоотой 138 шүүхийн шийдвэрийг судалгааны объект болгон судлав. Зээлдэгчийн зээлийн үүргийн гүйцэтгэл хангахгүй байгаа тайлбар, зээлийн гэрээний хэлбэр зэрэг шалгуураар ангилан шинжилж, зээлдэгч үүргээ гүйцэтгэхгүй байгаа нийтлэг шалтгааныг тодорхойлоход ашиглав.

Тоон шинжилгээний арга: Кейс судалгааны өгөгдөлийг хувьсагч болгон бүлэглэж, зээлийн үүргийн гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарлыг тодорхойлох зорилгоор ашиглав.

Харьцуулан судлах арга: Япон болон ОХУ-ын Иргэний хуулийн хүрээнд иргэд хоорондын зээлийн гэрээний эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлана.

Судалгааны ажлын бүтэц, зохион байгуулалт



БҮЛЭГ 1. ОНОЛЫН ТОЙМ

1.1 Гэрээний эрх зүйн онол, онцлог шинж

1.1.1 Гэрээний ойлголт, төрөл үндсэн шинжүүд

Гэрээ гэдэг нь иргэний эрх, үүргийг бий болгох, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэгдсэн, хоёр ба түүнээс дээш тооны этгээдүүдийн хооронд хийгдсэн тохиролцооны дагуу хуулийн хүрээнд хийгдсэн баримт бичиг юм. Гэрээний тухай ойлголтыг түүхэн хөгжлийн хувьд Хүснэгт 2-т харуулсанаар авч үздэг байна.

Хүснэгт 2. Гэрээний түүхэн хөгжил

№	Хугацаа	Агуулга
1	МЭӨ	МЭӨ гэрээ байгуулж байсан гэдэг нь анторпологчдын маргаантай сэдэв. Энэтхэгийн их сургуулийн багш нарын тэмдэглэснээр энэ үед бэлэг солилцох, зээл, өглөг зэрэг худалдааны агуулгатай хэлцэлийг түгээмэл хийж байсан гэж үзсэн. МЭӨ үед "Солилцооны онол" үүссэн гэж үздэг.
2	Дундад зууны үе	Дундад зууны үед ихэнх үүрэг нийгэм дэх хувь хүмүүсийн байр сууриар тодорхойлогдож байсан. Газрын эзэд тодорхой нөхцөлтэйгөөр ургацаа зээлэх болж, үүнээс үүдэн өөрсдийгөө хамгаалах хэрэгтэй болсон. Шүүх өмчийнхөө ашиг сонирхолыг хамгаалахад гэрээ хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Солилцооны онол эрхийн онол /title/ үүссэн.
3	Феодалын нийгмийн үе	Энэ үед шинэ онол болох /will/ хүсэл зоригийн онол үүссэн ба уг онолын дагуу шүүх талуудыг хоорондоо тохирон гэрээний агуулгаа зарласан байхыг шаардсан.
4	XX-р зуун	Нийгмийн хөгжилтэй уялдан гэрээний харилцаа хууль тогтоомжоор зохицуулагдаж эхэлсэн. Гэрээний эрх чөлөөний онол /freedom of contract/ хүчтэй хөгжсөн байна.

Эх сурвалж: (Монголбанк, Санхүүгийн боловсрол гарын авлага, 2002)

Гэрээний үндсэн шинжүүд:

- ❖ Субъектүүд нь тодорхой зорилготойгоор сайн дураар уг харилцаанд ордог;
- ❖ Субъектүүдийн хүсэл зоригийн үр дүнд хууль зүйн харилцаа, холбоо тогтдог;
- ❖ Зайлшгүй хийвэл зохих үйлдлийн дараалал, журмын шаардлагыг тодорхойлдог;
- ❖ Гэрээнд оролцогчид нь харилцан тэнцвэрт шинжтэй байдаг;
- ❖ Өөрсдийн зан үйлийг өөрсдөө журамлан тогтоодог;
- ❖ Гэрээгээр тодорхойлсон эрх, үүргээ талууд биелүүлэхгүй бол төрийн албадлагын арга хэрэгслийн тусламжтайгаар ханган биелүүлдэг;

Гэрээний тавигдах шаардлага:

- ❖ Хоёр ба түүнээс дээш этгээд оролцох;
- ❖ Гэрээний объект хуульд нийцсэн байх;
- ❖ Гэрээний талууд эрх зүйн чадамжтай байх;
- ❖ Талууд харилцан тохиролцсон байх;

- ❖ Хуульд нийцсэн хэлбэрээр байгуулагдсан байх;

Гэрээний төрөл:

- ❖ Бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэх гэрээ;
- ❖ Бусдын эзэмшил, ашиглалтад хөрөнгө шилжүүлэх гэрээ;
- ❖ Ажил гүйцэтгэх гэрээ;
- ❖ Мөнгө төлөхтэй холбоотой гэрээ;
- ❖ Туслалцаа үзүүлэх гэрээ;
- ❖ Бусад.

1.1.2 Зээл, зээлийн гэрээний ойлголт, онцлог

Зээл нь банк, санхүүгийн байгууллага, хувь хүнээс тодорхой хэрэгцээндээ мөнгөн хөрөнгийг тодорхой хугацаатай, хүүтэй, эргүүлж төлөх нөхцөлтэйгээр авч буй харилцаа бөгөөд манай улсад Халх журам хууль (З.Сүхбаатар, Б.Батбаяр, П.Оюундэлгэр. Монгол улсын иргэний хууль тогтоомж, түүхэн эмхэтгэл, 2012), 1952 оны Иргэний хууль зэргээр зохицуулж байсан байна. Түүхэн хөгжлийнхөө эхэн үед зөвхөн иргэд хоорондын нэг удаагийн шинжтэй зээлийн харилцаа үүсдэг байсан бол яваандаа банк гэх мэт мэргэжлийн санхүүгийн байгууллагууд үүсч тогтмол зээлийн үйл ажиллагаа явуулж ашиг, орлого олох болжээ. Зээл нь эхэн үедээ оролцогч талуудын хооронд итгэлцлийн шинж чанартай байсан бол яваандаа хуулийн зохицуулалт хийгдэж эхэлсэн бөгөөд шаардах эрх буюу хууль эрх зүйн орчны баталгаатай болсоноор зээлийн гэрээ гэх ойлголтыг нийтэд түгээмэл болгожээ.

Зээлийн гэрээ нь “Бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэх гэрээ”-ний төрөлд хамаарах ба зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө буюу бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлсэн авсан эд хөрөнгөтэй ижил хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх үүргийг хүлээдэг бөгөөд энэхүү гэрээ нь Монгол улсын Иргэний хуулиар зохицуулагдана. (Зураг 1-ийг үзнэ үү)

Зураг 1.Зээлийн гэрээний бүтэц



Эх сурвалж: (Монголбанк, Санхүүгийн боловсрол гарын авлага, 2002)

Энэхүү гэрээ нь сүүлийн жилүүдэд манай улсын иргэний эрх зүйн салбарт ХХАГ-ний дараа орох хамгийн өргөн тархсан үзэгдэл болоод байна. Найз нөхөд, танилын хүрээнд богино хугацаатай, хүүгүй зээл олгох тохиолдол маш бага хувийг эзлэх бол санхүүгийн эргэлтэд хамаарах зээл давамгайлж байна (Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн

тусгай анги, 2021).

Зээлийн гэрээг зээлдүүлэгч болон зээлдэгч нар нь амаар болон бичгийн хэлбэрээр аль алианаар нь байгуулж болох ба амаар байгуулах нь маргаан үүссэн тохиолдолд талуудын харилцааг баталгаажуулахад сул талтай байдаг. Харин бичгээр байгуулах нь маргаан үүссэн тохиолдолд гэрээнд зээлийн хэмжээ, нөхцөл, эргэн төлөх хугацаа, хүү, алданги зэрэг нь тодорхой бөгөөд хуулийн хүрээнд баталгаажсан байдгаараа давуу талтай байж талуудын харилцааг илүү тодорхой, хариуцлагатай болгодог байна. Зээлийн гэрээг хугацаатай болон хугацаагүй байгуулах боломжтой бөгөөд зээлийн гэрээнд заагдсан хугацаа нь зээлдэгчийн буцаан төлөх үүргийг тодорхойлдог. Хэрэв хугацаа заагаагүй бол зээлдүүлэгчийн шаардсанаас хойш нэг сарын дотор зээлдэгч зээлээ буцаан төлөх үүрэгтэй байдаг.

Зээлийн гэрээний онцлог:

- ❖ Мөнгө, эд хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэн өгснөөр эсхүл хуульд заасан хэлбэрээр хийсэн гэрээг байгуулагдсанд тооцно;
- ❖ Зээлийн гэрээнд талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож болох ба ИХ-д зааснаар заавал бичгээр байгуулна;
- ❖ Гэрээг тодорхой хугацаатай байгуулсан бол зөвхөн зээлдэгчийн эд хөрөнгийн байдал доройтож, буцаан төлөх чадваргүй болсон тохиолдолд, мөн зээлдүүлэгч зөвшөөрсөн нөхцөлд зээлийн хүүгийн хамт хугацаанаас нь өмнө төлөх, эсвэл шаардах эрхтэй;
- ❖ Зээлийн гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө зээл авах гэж байгаа этгээд буцаан төлөх чадваргүй болох нөхцөл байдал бий болохоор байвал зээл олгохоос татгалзах эрхтэй;

Зээлийн гэрээний оролцогч талуудын хувьд Монгол улсын хувьд дараах эрхзүйн баримт бичгүүдээр нарийвчлан зааж өгсөн байдаг. Тухайлбал:

- ❖ Иргэний хууль;
- ❖ Банкны тухай хууль;
- ❖ Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль;
- ❖ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль;
- ❖ Монголбанкны холбогдох журмууд;
- ❖ Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмууд;
- ❖ Банкны үйл ажиллагааны холбогдох журмууд гэх мэт.

Зураг 2. Зээлийн гэрээний оролцогч талууд



1.1.3 Хувийн эрх зүйн гэрээний үндсэн шинж, суурь зарчмууд

Эртний Ромын эрх зүйд гэрээг тодорхой хэлбэрээр байгуулах, талуудын хүсэл зориг, тохиролцоо нь гэрээний бүрдүүлбэр хэсэг болж эртний уламжлалаар гэрээг тодорхой хэлбэр, ёслол, гэрчлэх аргаар илэрхийлэн баталгаажуулж байжээ (Т.Мэндсайхан, Гэрээний эрх зүй, 2021).

Гэрээний талууд: Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр болно. Иргэн ба иргэн, иргэн ба аж ахуй эрхлэгч гэх мэт гэрээний талуудаас хамаарч хоорондоо гэрээ байгуулах тохиолдлуудыг ялгаатай авч үзээд эрх зүйн зохицуулалтыг өөр өөрөөр тогтоох явдал бий.

Гэрээний агуулга ба тохиролцоо: Талуудын тодорхой зорилго, хэрэгцээ, хүсэл зориг гол үндэс болно. Хүсэл зоригоо харилцан илэрхийлж, зөвшилцөж нэгдмэл ойлголтод хүрснийг тохиролцоо гэнэ. Тохиролцоо нь хөрөнгө шилжүүлэх талуудын үүрэг бүхий амлалтын агуулгатай байдаг. Гэхдээ аман тохиролцооны үед гэрээний нэг тал өөрийн дотоод санаа, бодол, төсөөллөө буруу, зөрүүтэй илэрхийлэх, түүний гадна талд илэрхийлсэн байдлаар нөгөө тал ойлгож, хүлээн авснаас шалтгаалан үл ойлголцол үүсэх магадлалтай. Гэрээний агуулгын талаар нэгдмэл ойлголт, тохиролцоонд хүрсэн байх нь гэрээний хүчин төгөлдөр байдлаас гадна үүргийн биелэлт хангагдах чухал нөхцөл болно. Мөн хууль, зан суртахуунд нийцсэн үед тухайн гэрээг албадан хэрэгжүүлэх боломж бүрддэг байна.

Гэрээ байгуулах үндэслэл: Эртний Ромын эрх зүйд гэрээ байгуулах “үндэслэл” (causa) гэх ойлголтыг “тохиролцоо”-оос ялгаатай авч үздэг байжээ. Гэрээ эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл болохын хувьд “тохиролцоо” (convention, consensus), “үндэслэл”(causa) буюу гэрээ байгуулсанд тооцох тодорхой үйл баримт, нөхцөл байдал үүссэн шинж агуулах ёстой. Тохиролцоо бүхэн гэрээ болохгүй, тохиролцоо болон үндэслэл байж нэхэмжлэхээр хамгаалагдах “гэрээ” үүснэ. Харин үндэслэлд гэрээ байгуулсанд тооцох тодорхой үйл баримт, хэлбэрийн шинжийг хамруулж, гэрээний аль нэг талын зорилго, хэрэгцээ шаардлагыг хангах, гэрээг хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулах үйлдэл, материаллаг үйлдлийг ойлгож байв.

Гэрээний хэлбэр: Гэрээний гол нөхцлийг тохиролцсон, аман эсхүл бичмэл (oral and writing formality) зарим тохиолдолд тодорхой үйлдлээр хэлбэрийн шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулагдсан гэж үздэг. Хэдийгээр гэрээний талууд сайн дурын үндсэн дээр гэрээний агуулга, нөхцлийг тохирч, гэрээгээр хүлээсэн үүргийг гүйцэтгэх боловч уг харилцаанд баримтлах зарчмаас хууль ба гэрээний харилцан хамаарал, хэрэглэгдэх эрэмбэ, эрх зүйн зохицуулалтын хүрээ, арга, тогтолцоо шууд хамаарна (Т.Мэндсайхан, Гэрээний эрх зүй, 7 дугаар тал, 2021).

Монгол улсад эртний хууль, цаазад гэрээний зохицуулалт ховор, худалдаа арилжаанд заншлын хэмжээ давамгайлсан буюу хууль зүйн бус арга хэрэгсэл болох нутгийн зан заншил, ажил хэргийн тогтсон жишиг, ёс суртахуунаар зохицуулж, харин гэрээний амлалт, тохиролцоогоо хүндэтгэн биелүүлэхийг эрхэмлэж ирсэн нь түүхэн эх сурвалжуудад тэмдэглэгджээ.

Чөлөөт байдал буюу гэрээний эрх чөлөөний зарчим: Эртний Ромоос үүсэлтэй, хүний эрх, эрх чөлөөтэй салшгүй холбоотой ойлголт бөгөөд олон улсын эрх зүй, улс орны үндсэн хуулиар баталгаажсан байдаг. Гэрээг сайн дурын үндсэн дээр чөлөөтэй байгуулах буюу гэрээ байгуулах албадлагад орохгүй, хэнтэй гэрээ байгуулах, хэнтэй гэрээ байгуулахаас татгалзах сонголтыг гэрээний аль ч тал сонгох эрхийг гэрээний эрх чөлөөний зарчмын үндсэн ойлголт болдог.

Гэрээний агуулга нөхцлийг чөлөөтэй тодорхойлох буюу талууд харилцан тохиролцох үндсэн дээр гэрээний гол нөхцлийг тогтоох, тохиролцсон нөхцлийг аль нэг тал дангаар өөрчлөхгүй, өөртөө давуу байдал үүсгэхгүй, тулган шаардахгүй байх юм. Монгол улсын ИХ-ийн 189 дүгээр зүйлд гэрээний чөлөөт байдлын зарчмыг дээрх хоёр агуулгаар гэрээ байгуулах эрх чөлөө ба гэрээний агуулгыг тогтоох эрх чөлөө гэж хувааж тодорхойлжээ.

Үүргээ үнэнч шударгаар биелүүлэх, харилцан итгэлцлийг хүндэтгэх зарчим (good faith and fair dealing): Англи саксоны эрх зүйн нийтлэг эрх зүйн (common law) ба шударга ёсны эрх зүй (Equity)-н (good faith and fair dealing) буюу гэрээний талууд үүргээ үнэнч шударгаар биелүүлэх, харилцан итгэлцлийг хүндэтгэлтэй хандаж гэрээг хэрэгжүүлэх, нөгөө талын эрхийг хөндөхгүй байх ерөнхий хүлээлтийг энэ зарчим олгодог. Тодруулбал энэхүү үнэнч шударга байх (good faith) зарчим нь гэрээний талууд итгэлцэлд тулгуурлан эрх, үүргээ хэрэгжүүлэх ёстой гэсэн эрх зүйн суурь шаардлага юм. Талууд гэрээ байгуулахаас гэрээний гүйцэтгэл биелэгдэж, дуусгавар болох үе шатуудад үйлчилдэг бөгөөд талуудын зан төлөвийг зохицуулах, гэрээний тодорхойгүй байдлыг нөхөхөд чухал үүрэгтэй.

Олон улсын эрх зүйд уг зарчмыг хүлээн зөвшөөрч дагаж мөрдөхөөр заасан байдаг. Тухайлбал UNIDROIT-ын Олон улсын арилжааны гэрээний зарчимд гэрээний талууд үүргээ үнэнч шударгаар биелүүлэх, харилцан итгэлцлийг хүндэтгэх (good faith and fair dealing) зарчмыг дагаж мөрдөнө гэж заасан. (Unidroit, Art.1.7, 2016) Мөн Олон улсын худалдааны гэрээний тухай Венийн конвенцид гэрээ тайлбарлахад үнэнч шударга байх (good faith) зарчмыг харгалзан үзэхийг шаарддаг. ((CISG)., United Nations Convention on Contracts for the International Sale of Goods, United Nations.)

Герман улсын Иргэний кодексийн 242 дугаар зүйлд Үүрэг гүйцэтгэгч нь тухайн эрх зүйн харилцаан дахь заншлыг харгалзан үнэнч байх, харилцан итгэлцлийн зарчимд нийцүүлэн үүргээ гүйцэтгэнэ гэж заасныг эрх зүйн ном зохиолд эрх зүйн суурь зарчим гэж үнэлэн өргөн хүрээнд тайлбарлан хэрэглэж байна (Т.Мэндсайхан, Гэрээний эрх зүй, 2001).

Үнэнч шударга байх (good faith) зарчим нь онолын хувьд гэрээний итгэлцэлд дараах үндсэн үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

- ❖ Гэрээний талуудын зан төлөвийг ёс зүйн хэм хэмжээгээр зохицуулах;
- ❖ Гэрээний тодорхойгүй зохицуулалтыг нөхөх;
- ❖ Шүүхийн тайлбар, үнэлгээний суурь шалгуур болох;
- ❖ Талуудын эрхийн хэтрүүлэн ашиглалтаас сэргийлэх.

Уг зарчим нь Монгол Улсын ИХ-д “үнэнч шударгаар” хэрэгжүүлэх гэсэн нэр томъёогоор орсон ба хуулийн 13.1-т *“Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч хууль буюу гэрээнд заасан эрх, үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлнэ.”* гэж заасан байдаг (Э.Мандалмаа Good faith in Mongolia (Монгол улс дахь үнэнч шударгын зарчим), 2015). Мөн үүргийн гүйцэтгэл буюу хуулийн 206.1-т *“Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ.”* гэсэн нь шударгаар харилцах зарчмыг агуулдаг.

Гэрээний үүргийг заавал биелүүлэх зарчим (pacta sunt servanda): Нэгэнт хүчин төгөлдөр байгуулсан гэрээний үүргээ зайлшгүй биелүүлэх ёстой, энэ нь амалсан амлалт, гэрээнд үнэнч байх үйлдэл мөн. Уг зарчим гэрээ хүчин төгөлдөр, тодорхой, үйл баримт нотлогдохуйц, хуульд нийцсэн нөхцөлд хэрэгжих боломжтой. (Т.Мэндсайхан, Гэрээний эрх зүй, 2001) Энэхүү зарчмын онолын ач холбогдол нь:

- ❖ Гэрээний харилцаанд эрх зүйн тодорхой байдал бий болгох;
- ❖ Эдийн засгийн харилцааны тогтвортой байдлыг хангах;
- ❖ Гэрээний сахилга, талуудын хариуцлагыг баталгаажуулах;
- ❖ Шүүхийн шийдвэр гаргалтын үндсэн суурь болох.

Уг зарчим Монгол Улсын ИХ-ийн 1.2-т Иргэний хууль тогтоомж нь “гэрээний эрх чөлөө”-ний зарчимд үндэслэдэг ба талууд хүсэл зоригоо илэрхийлэн тохиролцсон бол түүнийгээ хэрэгжүүлэх үүргийг агуулдаг байна. Мөн 186.1-т *“... үүрэг гүйцэтгэгч нь ямар нэгэн үйлдэл хийх, эсхүл тодорхой үйлдэл хийхээс татгалзах үүргийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх бөгөөд үүрэг гүйцэтгүүлэгч нь түүнээс уг үүргээ гүйцэтгэхийг шаардах эрхтэй.”* гэсэн зохицуулалт нь уг зарчмын үндсэн санаа байна.

Гэрээний эрх зүйд суурь зарчим болох гэрээний талуудын чөлөөт байдал буюу гэрээний эрх чөлөөний зарчим нь гэрээний төдийгүй хувийн эрх зүйн үндсэн таних тэмдэг нь болдог бол үүргээ үнэнч шударгаар биелүүлэх, харилцан итгэлцлийг хүндэтгэх зарчим нь нийгмийн өдөр тутмын, урт хугацааны харилцааг илүү энгийн, найдвартай болгодог нэр төрийн баталгаа болдог байна (Т.Мэндсайхан, Гэрээний эрх зүй, 2001). Good Faith болон Pacta Sunt Servanda зарчмууд нь гэрээний эрх зүйн хоёр өөр боловч харилцан нөхөх шинжтэй үндсэн тулгуур юм. Pacta Sunt Servanda нь гэрээний заавал биелэгдэх хууль зүйн үүргийг тодорхойлдог бол Good Faith нь уг үүргийг үнэнч шударга байдлаар хэрэгжүүлэх ёс зүйн болон зан төлөвийн суурийг бүрдүүлдэг.

Иймээс дээрх гэрээний суурь зарчмууд нь зээлийн гэрээний харилцааны хэрэгжилтийн эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаа бөгөөд дараагийн хэсэгт эдгээр зарчмууд бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжиж буйг зан төлөв болон итгэлцлийн онолын хүрээнд авч үзнэ.

1.1.4 Гэрээний үүргийн гүйцэтгэлийн онол

Гэрээний талууд тухайн гэрээ болон хуулиар тогтоосон нөхцлийн дагуу тодорхой үүрэг хүлээх ба үүрэг гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ заавал гүйцэтгэх үүрэгтэй, үүрэг гүйцэтгүүлэгч нь үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй байна. (Монгол улсын Иргэний хуулийн тайлбар, 560 дугаар тал, 2018 он).

Гэрээгээр хүлээсэн үүргээ үнэнч шударгаар заавал биелүүлэх нь гэрээний эрх зүйн суурь зарчим юм. Энэхүү “үүргээ үнэнч шударгаар биелүүлэх, харилцан итгэлцлийг

хүндэтгэх зарчим” (good faith and fair dealing) болон “гэрээний үүргийг заавал биелүүлэх” (pacta sunt servanda) суурь зарчмыг хангах тусгайлсан зохицуулалтыг Иргэний хууль болон бусад хуульд тусгасан байдаг. Монгол улсын ИХ-ийн 16 дугаар бүлэг буюу 206-218 дугаар зүйлүүдэд үүрэг гүйцэтгэх үндсэн зарчим, журмыг дараах байдлаар зохицуулжээ. Үүнд:

- ❖ Үүргийг тогтоосон газар нь гүйцэтгэх;
- ❖ Үүргийг хугацаанд нь гүйцэтгэх;
- ❖ Үүргийг зохих ёсоор шударгаар гүйцэтгэх;

Үүргийг хаана, хэзээ гүйцэтгэхээс гадна ямар хэмжээнд, ямар журмаар гүйцэтгэхийг тодорхойлох зохицуулалт мөн хуульд тусгагдсан байна.

Үүргийн гүйцэтгэлийг тодорхойлох:

ИХ-ийн 193 дугаар зүйлд заасны дагуу үүрэг гүйцэтгэх арга, хэлбэр, журмыг талууд буюу гуравдагч этгээд тодорхойлсон нь эргэлзээ төрүүлсэн тохиолдолд шударга ёсны зарчимд нийцүүлэн шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол шүүх, арбитрын журмаар шийдвэрлэнэ.

Гэрээний үүргийн төрөл:

- ❖ ***Гүйцэтгэлийн ба харилцааны үүрэг*** – Гүйцэтгэлийн үүрэгт талуудын гэрээгээр хүлээсэн үүрэг хамаарна. (Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үнэ, хөлсийг төлөх г.м) Харилцааны үүрэгт үндсэн үүргийг баталгаажуулах зорилготой дагалдах үүрэг ба үүрэг гүйцэтгүүлэгч, ялангуяа хэрэглэгчид гэм хор учруулахаас хамгаалах, сэрэмжлүүлэх үүрэг хамаарна.
- ❖ ***Нэг бүрийн ба төрлийн шинжтэй үүрэг*** – Эртний ховор эд зүйл, онцгой шинжтэй, дахин давтагдахгүй эсхүл талууд тусгайлан сонгож тохиролцсон эд зүйлийг нэг бүрийн шинжтэй. Харин төрлийн шинжтэй зүйлд гурил, будаа, шатахуун, төмөр гэх мэт нийтлэг шинж чанартай бараа бүтээгдэхүүн мөн үс засах, хичээл заах, урлагийн тоглолт үзүүлэх зэрэг ажил үйлчилгээнүүд орно.
- ❖ ***Сонгох ба орлуулах үүрэг*** – Гэрээгээр тохиролцоогүй боловч хуульд заасан эсхүл гэрээний мөн чанараас шалтгаалж үүрэг гүйцэтгэгч хэд хэдэн үүргээс аль нэгийг нь сонгож гүйцэтгэх эрхтэй байдаг.
- ❖ ***Бодитоор гүйцэтгэх үүрэг*** – Үндсэн үүргээ гэрээнд заасны дагуу гүйцэтгэхийг үүргээ бодитоор гүйцэтгэх гэнэ.
- ❖ ***Бусад*** – Үүрэг гүйцэтгэх газар, хугацаатай холбоотойгоор хүргэх, илгээх, ирж авах үүрэг, мөн урт хугацаатай үүргүүд багтана.

1952 оноос хойшхи ИХ-дад гэрээний зөрчил болон гэрээний үүргээс чөлөөлөгдөх нөхцөл байдал гэдэг ойлголтыг хэрэглэж ирсэн ба 2002 оны ИХ-ийн төсөл боловсруулахад ХБНГУ-ын хуульч, эрдэмтэд зөвлөгөө өгч байсан учраас ХБНГУ-ын иргэний эрх зүйн ойлголт, хуулийн зохицуулалтын дэвшилтэт зүйлс манай хуульд тусгагдсан байдаг. (Т.Мэндсайхан, Гэрээний эрх зүй, 2021)

Үүрэг гүйцэтгэх дараалал:

ИХ-ийн 216 дугаар зүйлд заасны дагуу үүрэг гүйцэтгэгч нь ижил төрлийн хэд хэдэн үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэгтэй. Үүргийн гүйцэтгэл нь бүх өрийг төлөхөд

хүрэлцэхгүй бол үүрэг гүйцэтгэгч аль нэг үүргийг сонгож гүйцэтгэх эрхтэй. Үүрэг гүйцэтгэгч ийм сонголт хийгээгүй бол төлбөрийн хугацаа болсон өрийг тэргүүн ээлжинд төлүүлнэ.

- ❖ Хэд хэдэн өрийг төлөх хугацаа нэгэн зэрэг болсон тохиолдолд гүйцэтгэхэд илүү хүнд нөхцөлтэй шаардлагыг тэргүүн ээлжинд гүйцэтгэнэ.
- ❖ Шаардлагууд нь үүрэг гүйцэтгэгчийн хувьд ижил нөхцөлтэй бол биелэх боломж багатай үүргийг тэргүүн ээлжинд гүйцэтгэнэ.
- ❖ Үүргийн гүйцэтгэл нь төлөх хугацаа болсон бүх өрийг төлөхөд хүрэлцэхгүй бол тэргүүн ээлжинд шүүхийн зардал, дараа нь үндсэн үүрэг, эцэст нь хүүг төлүүлнэ.

Гэрээний аль нэг тал нь гэрээнээс татгалзсанаас үүсэх үр дагавар:

ИХ-ийн 205 дугаар зүйлд заасны дагуу хууль буюу гэрээнд заасны дагуу аль нэг тал нь гэрээнээс татгалзсан бол талууд гэрээний гүйцэтгэлийг биет байдлаар нь, түүнчлэн гэрээ биелсэнээс олсон ашгийг харилцан буцааж өгөх үүрэгтэй бөгөөд уг үүргийг гэрээний талууд биечлэн, нэгэн зэрэг гүйцэтгэх үүрэгтэй.

Дараах тохиолдолд үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлийг биет байдлаар бус мөнгөөр нөхөн төлнө. Үүнд:

- ❖ Гүйцэтгэсэн үүргийн шинж чанараас шалтгаалан биет байдлаар эргүүлж өгөх боломжгүй;
- ❖ Үүргийн гүйцэтгэлийг хүлээн авсан тал нь түүнийг ашиглаж байгаа буюу бусдын өмчлөлд шилжүүлсэн, эсхүл бусдын эрхээр хязгаарласан, түүнчлэн түүнийг боловсруулах, дахин боловсруулах замаар өөрчилсөн;
- ❖ Үүргийн зүйлийг ердийн элэгдэл, хорогдлоос гадуур гэмтээсэн, муутгасан, дутаасан, устгасан.

Мөн дараах тохиолдолд үүрэг гүйцэтгэгч нөхөн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Үүнд:

- ❖ Гэрээгээр үүрэг гүйцэтгүүлэгчийн шилжүүлсэн зүйлийн чанарын доголдол нь үүрэг гүйцэтгэгч гэрээнээс татгалзах үндэслэл болсон бөгөөд тэрээр гэрээний зүйлийг боловсруулах, дахин боловсруулах явцдаа энэхүү доголдлыг илрүүлсэн;
- ❖ Гэрээний зүйл үүрэг гүйцэтгүүлэгчийн буруугаас гэмтсэн, муудсан, дутсан, утсан;
- ❖ Үүрэг гүйцэтгэгч гэрээний зүйлийг зохих ёсоор хадгалж, арчилж, хамгаалсаар байхад тэр нь муудсан, гэмтсэн, утсан. Энэ тохиолдолд гэрээний зүйлээс үлдсэнийг нь үүрэг гүйцэтгүүлэгчид буцааж өгнө.

1.2 Зээлийн гэрээний харилцааны итгэлцэл, зан төлөв ба хэрэгжилтийн онол

Нийгмийн капиталын гол бүрэлдэхүүн нь итгэлцэл ба итгэлцэл өндөр байх үед гэрээ, хэлцлийн зардал багасч, маргаан гарах магадлал буурдаг. Харин итгэлцэл сулрахад хамтын ажиллагааг бууруулж, маргаан нэмэгдэж, иргэдэд дарамт үүсгэхээс гадна, хууль эрх зүйн оролцооны зардал өсдөг байна. (Putnam, Robert D., Summary of "Bowling Alone: The Collapse and Revival of American Community", 2000)

Зээлийн гэрээний харилцааг итгэлцэл, зан төлөв, гэрээний хэрэгжилтийн механизм болон объектив зан төлөвийн шалгуурын хүрээнд тайлбарлахыг зорьсон бөгөөд судалгаанд **итгэлцлийн онол (Trust theory)**, **зан төлөвт суурилсан эрх зүй, эдийн**

засгийн онол (*Behavioral law and economics*), **албан ёсны ба албан бус хэрэгжилтийн онол** (*Formal vs informal enforcement*) гэсэн онолуудыг суурь болгон ашиглав. Эдгээр онолууд нь гэрээний үүргийн биелэлт, маргаан үүсэх нөхцөлийг хүний зан төлөв, нийгмийн орчин, институцийн хэрэгжилттэй уялдуулан тайлбарлах боломжийг бүрдүүлдэг.

1.2.1 Итгэлцлийн онол (Trust Theory)

Итгэлцлийн онол нь нийгмийн болон эдийн засгийн харилцаанд оролцогч талуудын хоорондын итгэлцэл нь хамтын ажиллагаа, гэрээний хэрэгжилтийн үндсэн нөхцөл болдог гэж үздэг ба (Fukuyama, F. *Trust: The social virtues and the creation of prosperity*. New York: The Free Press., 1995) итгэлцлийг “нийгмийн гишүүдийн хооронд харилцан найдвартай, хүлээлтэд суурилсан зан үйлийн суурь” гэж тодорхойлсон. Итгэлцэл өндөр нийгэмд гэрээний хэрэгжилт илүү үр ашигтай, харин итгэлцэл сул нөхцөлд маргаан үүсэх магадлал өндөр байдаг.

Итгэлцэл алдагдах үед гэрээний үүрэг биелэгдэхгүй байх, улмаар маргаан үүсэх нөхцөл бүрддэг. Мөн Bryan C. McCannon-ий 2018 онд хийсэн “Social norms and cooperation” (Нийгмийн хэм хэмжээ ба хамтын ажиллагаа) судалгаагаар итгэлцэл нь гэрээний албадлагын механизмтай харилцан нөхөх шинжтэй бөгөөд итгэлцэл буурах тусам албан ёсны хэрэгжилтийн хэрэгцээ нэмэгддэг болохыг тогтоосон байдаг.

Мөн итгэлцлийг бусдад найдах, тэдний үйлдэлд хүлээлт үүсгэх, тухайн этгээд хариуцлагатайгаар үүргээ биелүүлнэ гэсэн хандлага гэж тайлбарласан байдаг бөгөөд итгэлцэл нь зөвхөн найдах биш, харин нийгмийн хүлээлт, хариуцлага, ёс зүйн үүрэгтэй холбоотой гэж үздэг байна. (Stanford Encyclopedia of philosophy, 2006)

Зээлийн болон гэрээний харилцаанд:

- ❖ Зээлдүүлэгч зээлдэгчийг буцаан төлнө гэсэн итгэлтэйгээр зээл олгодог;
- ❖ Зээлдэгч гэрээний үүргээ биелүүлнэ гэсэн хариуцлага хүлээдэг;
- ❖ Итгэлцэл өндөр байх тусам эрсдэл багасч, гэрээ тогтвортой хэрэгжинэ.

Итгэлцлийн онолын дагуу зээлдүүлэгч болон зээлдэгчийн хоорондын харилцаа нь харилцан итгэлцэл дээр суурилдаг бөгөөд итгэлцэл өндөр байх тусам зээлийн гэрээ амжилттай хэрэгжих боломж нэмэгддэг гэж үздэг. Өөрөөр хэлбэл, зээлдүүлэгч нь зээлдэгчийг хугацаанд нь төлнө гэж итгэж зээл олгодог бол зээлдэгч нь гэрээний нөхцөлийг биелүүлэх үүргийг ухамсарлан хүлээдэг байна.

Иргэд хоорондын зээлийн гэрээний хувьд итгэлцлийн онол илүү тод илэрдэг. Учир нь банк, санхүүгийн байгууллагын зээлээс ялгаатай нь иргэд хоорондын зээл нь ихэвчлэн барьцаа, батлан даалт багатай, харилцан танил талуудын итгэлцэл дээр тулгуурлан байгуулагддаг. Иймд итгэлцэл сул байх тохиолдолд гэрээний үүргийн гүйцэтгэл доголдох, маргаан үүсэх эрсдэл нэмэгддэг бол итгэлцэл өндөр байх нь гэрээний сахилга, хугацаанд нь төлөлт, харилцааны тогтвортой байдлыг хангахад чухал нөлөө үзүүлдэг.

Мөн зээлийн гэрээний эрх зүйн зохицуулалт нь итгэлцлийг хамгаалах, баталгаажуулах үүрэгтэй байдаг. Бичгээр гэрээ байгуулах, барьцаа, батлан даалт авах, хүү, хугацааг тодорхой заах зэрэг нь итгэлцлийг эрх зүйн баталгаагаар дэмжиж, эрсдэлийг бууруулдаг механизм юм. Энэ нь итгэлцлийн онолын практик хэрэглээ гэж үзэж болно.

Иймээс итгэлцлийн онол нь зээлийн гэрээ, ялангуяа иргэд хоорондын зээлийн гэрээний харилцааг ойлгох онолын суурь болж, талуудын харилцан итгэлцэл, хариуцлага, гэрээний сахилга бат нь зээлийн харилцааны амжилттай хэрэгжилтийн үндэс болдог гэж үздэг байна.

1.2.2 Зан төлөвт суурилсан эрх зүй, эдийн засгийн онол (Behavioral Law and Economics)

Зан төлөвт суурилсан эрх зүй, эдийн засаг (Behavioral Law and Economics) нь уламжлалт эдийн засгийн онолын "хүн бол оновчтой шийдвэр гаргагч" (homo economicus) гэсэн суурь төсөөллийг сэтгэл судлалын шинжлэх ухааны ололтуудаар баяжуулсан салбар дундын онол юм. Энэ нь хүмүүсийн шийдвэр гаргалт нь үргэлж рациональ байдаггүй бөгөөд сэтгэл зүй, хүлээлт, алдаатай үнэлгээ зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг гэж үздэг. (Daniel Kahneman, Thinking, Fast and Slow, 2011). Энэхүү онол нь Хүний сэтгэл зүйн шинж чанар, зан төлөв нь эдийн засгийн шийдвэр гаргалт болон хууль биелүүлэлтэд хэрхэн нөлөөлдөгийг авч үздэг ба гэрээний харилцаанд оролцогч талуудын зан төлөвийг ойлгоход чухал ач холбогдолтой. Энэхүү онол нь хүмүүс амьдрал дээр дараах гурван хүчин зүйлээс шалтгаалан үргэлж оновчтой шийдвэр гаргаж чаддаггүй гэж үздэг. Үүнд

- ❖ ***Хязгаарлагдмал танин мэдэхүй (Bounded Rationality)*** - Хүнд мэдээлэл боловсруулах чадвар, цаг хугацаа, танин мэдэхүйн нөөц хязгаартай тул хамгийн ашигтай хувилбарыг бус, өөртөө "хангалттай" гэж үзсэн шийдвэрийг гаргадаг.
- ❖ ***Хязгаарлагдмал хүсэл зориг (Bounded Willpower)*** - Хүмүүс урт хугацааны ашгаа мэддэг ч (жишээ нь: тэтгэвэртээ мөнгө хадгалах, эрүүл хооллох) богино хугацааны таашаалыг илүүд үзэж, төлөвлөгөөгөө зөрчих хандлагатай.
- ❖ ***Хязгаарлагдмал хувийн ашиг сонирхол (Bounded Self-interest)*** - Хүн зөвхөн өөрийн ашгийг харахаас гадна бусдад туслах, шударга ёсыг эрхэмлэх зэрэг нийгмийн зан төлөв гаргадаг.

Түүнчлэн энэхүү онолын дагуу эрх зүйн баримт бичиг, хууль тогтоомжийг боловсруулахдаа хүмүүсийн бодит зан төлөвт дараах байдлаар нийцүүлэхэд чиглэдэг байна.

- ❖ ***Түлхэц өгөх (Nudging)*** - Хүний сонгох эрх чөлөөг хязгаарлахгүйгээр шийдвэр гаргах орчныг нь (choice architecture) өөрчлөх замаар илүү зөв сонголт руу чиглүүлэх арга юм.
- ❖ ***Гэрээний эрх зүй*** - Хэрэглэгчид урт, төвөгтэй гэрээний нөхцөлийг уншдаггүйг харгалзан, чухал мэдээллийг энгийн, ойлгомжтой байдлаар харуулахыг компаниудаас шаардах.
- ❖ ***Гэм хорын эрх зүй*** - Хүмүүс эрсдэлийг хэт өөдрөгөөр үнэлдэг (optimism bias) тул аюулгүй байдлын стандартыг илүү чангатгах үндэслэл болдог.

Зээлийн гэрээний хүрээнд зээлдэгчид:

- Төлөх чадвараа хэт үнэлэх;
- Хугацааг хойшлуулах;
- Үүргээ үл тоомсорлох;

зэрэг зан төлөв илэрдэг нь рациональ бус шийдвэр гаргалтын жишээ юм. Эдгээрийг Jolls, Sunstein, Thaler нар “Эрх зүйн орчинд зан төлөвийн гажуудал” судалгааны ажлаараа гэрээний хэрэгжилтэд шууд нөлөөлдөг болохыг онцолсон байдаг.

2021 онд Монголын микро зээлдэгчдийн дунд (гар утасны зээл олгох аппликейшнээс авсан 1118 зээлдэгчийн мэдээллийг хамарсан) хийсэн судалгаагаар зээл төлөхгүй байх эрсдэл нь зөвхөн эдийн засгийн бус харин хувь хүний “өөрийгөө хянах чадвар”, “үр дүнтэй санхүүгийн шийдвэр гаргалт” зэрэг зан төлөвөөс нь шууд хамаардаг болохыг тогтоосон (Optimal NMax LLC, Effect of Psychological Factors on Credit Risk: A Case Study of the Microlending Service in Mongolia, 2021).

Түүнчлэн судалгаа, зөвлөх үйлчилгээний SICA компаниас 2022 онд Монголчуудын соёл болон монгол хүний зан төлөвийг тодорхойлох судалгаа хийсэн байна. Тус судалгаагаар БНХАУ, Япон, ОХУ, БНСУ зэрэг бусад улсууд ихэвчлэн урт хугацааны зорилго тавьж түүнийгээ биелүүлэхийг эрмэлздэг бол Монгол хүмүүс ойрын хугацааны зорилгодоо илүү анхаардаг (Short-Term Orientation) зан төлөвтэй нь зээл, төлбөрийн харилцаанд "Маргаашийн соёл" (прокрастинаци) бий болгож, эдийн засгийн тогтворгүй байдалд нөлөөлдөг болохыг дурдсан байна (Монголчуудын соёл болон Монгол хүний зан төлөвийг тодорхойлох судалгаа, 2022).

1.2.3 Албан ёсны ба албан бус хэрэгжилтийн онол (Formal vs Informal Enforcement Theory)

Энэхүү онол нь хууль тогтоомжыг албан ёсны (formal) – хууль, шүүх, төрийн албадлага ба албан бус (informal) – зан заншил, нэр хүнд, эвлэрүүлэн зуучлал, нийгмийн хяналт гэсэн хоёр үндсэн аргаар хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг үздэг байна.

❖ Албан ёсны хэрэгжилт (Formal Enforcement)

Энэ нь төр, засаг болон албан ёсны байгууллагуудаас тогтоосон хууль, дүрэм, журмыг албадлагын хүчээр мөрдүүлэх үйл явц юм.

- Хэрэгжүүлэгч: Цагдаа, шүүх, төрийн хяналтын байгууллагууд.
- Хэрэгсэл: Хууль, тогтоол, гэрээ, албан ёсны зааварчилгаа.
- Үр дагавар: Торгууль, хорих ял, тусгай зөвшөөрөл цуцлах зэрэг хуулийн дагуух шийтгэлүүд.
- Онцлог: Тодорхой бичигдсэн, бүх нийтээр дагаж мөрдөх ёстой, албадлагын шинжтэй.

❖ Албан бус хэрэгжилт (Informal Enforcement)

Энэ нь нийгмийн гишүүдийн хоорондын харилцаа, соёл, ёс заншил, нийгмийн хэм хэмжээнд тулгуурлан дүрэм мөрдүүлэх үйл явц юм.

- Хэрэгжүүлэгч: Гэр бүл, найз нөхөд, хамт олон, олон нийт.
- Хэрэгсэл: Нийгмийн шахалт, шүүмжлэл, нэр хүнд, итгэлцэл, уламжлал.
- Үр дагавар: Олноороо гадуурхах, зэмлэх, нэр хүнд унах, харилцаагаа таслах.
- Онцлог: Бичигдээгүй, аяндаа үүсдэг, дотоод итгэл үнэмшил болон ичгүүр дээр суурилдаг.

Монгол Улсын ИХ-ийн 281-285 дугаар зүйлүүдээр зохицуулсан зээлийн харилцаанд албан ёсны болон албан бус хэрэгжилтийн заагийг тодорхойлж үзэхэд дараах байдалтай байна.

❖ **Албан ёсны хэрэгжилт**

- *Хэлбэр*: Зээлийн гэрээг амаар байгуулж болох ч, хүү тогтоосон бол заавал бичгээр байгуулах ёстой (ИХ 282.3). Бичгээр байгуулаагүй бол шүүх дээр хүү нэхэмжлэх эрхээ алдана.
- *Гэрээ байгуулагдсанд тооцох*: Зээлийн гэрээ нь мөнгө буюу эд хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэн өгснөөр байгуулагдсанд тооцогдоно. Зөвхөн цаасан дээр гарын үсэг зурсан ч мөнгөө шилжүүлээгүй бол гэрээ хүчин төгөлдөр бус.
- *Анз (Алданги)*: Хэрэв хугацаа хэтрүүлбэл хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги тооцож болно. Гэхдээ нийт алданги нь үндсэн зээлийн 50 хувиас хэтэрч болохгүй (ИХ 232.4, 232.6.)
- *Нотариат*: Заавал нотариатаар батлуулах албагүй ч, батлуулснаар шүүхийн шатанд гэрээний хүчин төгөлдөр байдлыг нотлоход хялбар болно.

❖ **Албан бус хэрэгжилт**

- *Зан заншил*: Ажил хэргийн хүрээнд тогтсон заншил буюу тодорхой салбар, мэргэжил, бүс нутгийн хүрээнд тогтсон харилцаа зэргийг харгалзан үздэг. (ИХ 198.6)
- *Нийгмийн шахалт*: Хамтын хүрээллийнхэнд нь мэдэгдэх, гэр бүлээр нь дамжуулж шахалт үзүүлэх зэрэг нь шүүхээс илүү хурдан үр дүнд хүрэх тохиолдол бий.
- *Барьцаа*: Албан ёсны бүртгэлгүй ч (жишээ нь машины түлхүүр, бичиг баримт, үнэт эдлэл) эд зүйлийг нь авч үлдэх замаар үүргийн гүйцэтгэлийг хангуулдаг.
- *Эвлэрүүлэн зуучлал*: Шүүхээс гадуурх (албан бус) эвлэрүүлэн зуучлах замаар шийдвэрлүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь шүүхийн процессоос илүү цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх ач холбогдолтой.

Гэрээний эрх зүйн онолын үндэс, гэрээний ойлголт, шинж чанар, зээлийн гэрээний эрх зүйн зохицуулалт мөн гэрээний үүргийн гүйцэтгэлд нөлөөлөх итгэлцэл, зан төлөв, хэрэгжилтийн онолын асуудлыг цогцоор нь авч үзлээ.

Гэрээний харилцаа нь талуудын хүсэл зоригийн илэрхийлэлд тулгуурлан иргэний эрх, үүргийг бий болгох, өөрчлөх, дуусгавар болгох эрх зүйн үндсэн хэлбэр боловч ялангуяа амаар тохиролцоонд талуудын дотоод санаа, зорилго болон гадна илэрхийллийн зөрүүгээс үүдэн үл ойлголцол үүсэх, улмаар гэрээний үүргийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх үндэслэл болдог. Талууд гэрээний агуулгын талаар нэгдмэл ойлголт, тодорхой тохиролцоонд хүрсэн байх нь зөвхөн гэрээний хүчин төгөлдөр байдлыг хангахаас гадна үүргийн биелэлтийг баталгаажуулах үндсэн нөхцөл болдог байна.

Гэрээний эрх зүйн онолын хандлагуудыг нэгтгэн авч үзэхэд иргэд хоорондын зээлийн гэрээний маргаан үүсэх үйл явц нь итгэлцэл, эрх зүйн суурь зарчим болон зан төлөвийн хүчин зүйлсийн харилцан уялдаанд тодорхойлогдож байна. Тодруулбал,

итгэлцэлд суурилсан албан бус зээлийн харилцаанд үнэнч шударга байх зарчим (good faith) давамгайлж, гэрээний хэрэгжилт сул байх хандлагатай байдаг бол бичгийн гэрээ, барьцаанд тулгуурласан албан ёсны харилцаанд гэрээг заавал биелүүлэх зарчим (pacta sunt servanda) илүү хүчтэй хэрэгжиж, үүргийн гүйцэтгэл сайжарна.

Үүний зэрэгцээ зан төлөвийн хүчин зүйлс нь эдгээр хоёр төрлийн харилцаанд аль алинд нь нөлөөлж, тухайлбал үүргээ хойшлуулах, төлөх чадвараа хэт үнэлэх, хариуцлагаас зайлсхийх зэрэг зан үйл нь гэрээний үүргийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх замаар маргаан үүсэх нөхцөл болдог байна.

Мөн тус бүлэгт зээлийн гэрээний харилцаанд нөлөөлөх зан төлөвийн болон нийгмийн хүчин зүйлсийг тайлбарлах зорилгоор итгэлцлийн онол (Trust Theory), зан төлөвт суурилсан эрх зүй, эдийн засгийн онол (Behavioral Law and Economics), албан ёсны болон албан бус хэрэгжилтийн онол (Formal vs Informal Enforcement)-ыг судлав. Уг онолууд нь гэрээний үүргийн биелэлтийг зөвхөн эрх зүйн зохицуулалтаар бус, харин итгэлцэл, зан төлөвийн нөлөөлөлтэй уялдуулан тайлбарлах боломжийг бүрдүүлж байна.

Иргэд хоорондын зээлийн гэрээний маргааныг ойлгох, тайлбарлахад зөвхөн эрх зүйн зохицуулалтаар хязгаарлах бус, гэрээний суурь зарчмууд, итгэлцэл, зан төлөв, хэрэгжилтийн орчны харилцан хамаарлыг цогцоор нь авч үзэх шаардлагатай ба дээрх онолын үндэслэлүүд нь дараагийн бүлэгт Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын бодит байдал болон эмпирик судалгааны үр дүнг шинжлэх суурь үндэс болно.

БҮЛЭГ 2. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1 Монгол улс дахь зээлийн гэрээний эрх зүйн зохицуулалт

2.1.1 Зээлийн гэрээний эрх зүйн үндсэн зохицуулалт

Монгол улсад зээлийн гэрээний эрх зүйн зохицуулалт нь түүхэн хөгжлийн явцад үе шаттайгаар өөрчлөгдөж, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан боловсронгуй болсон. Тухайлбал, 1952 оны ИХ-ийн 189 дүгээр зүйлд “Зээлдэн олгох гэрээний ёсоор зээлдүүлэгч нь мөнгө буюу нэр төрлийн шинжээр тодорхойлох эд юмыг зээлдэн авагчид өмч болгон олгох бөгөөд зээлдэн авагч нь авсан мөнгө буюу мөн тэр төрлийн эд юмыг зохих тоо чанараар нь проценттой буюу процентгүйгээр буцааж өгөх үүргийг хүлээлгэнэ” гэж заасан байна (З.Сүхбаатар, Б.Батбаяр, П.Оюундэлгэр. Монгол улсын иргэний хууль тогтоомж, түүхэн эмхэтгэл, 2012). Мөн 191-р зүйлд “Зээллэгийн явдал дээр процент төлөхдөө зөвхөн үндсэн дүнгээс бодох бөгөөд процент дээр процент нэмэгдүүлэн бодох явдлыг хориглоно. Зээлдүүлэгч нь зээлдүүлсэн зүйлийн процентийг гагцхүү гэрээгээр тодорхойлон тогтоосон байвал шаардаж болно” гэж заасан нь зээлийн хүүг зөвхөн үндсэн дүнгээс бодох, хүүнээс хүү бодохыг хориглосон нь зээлийн харилцаанд шударга байдлыг хангах зорилготой байжээ.

1963 оны ИХ-ийн 264 дүгээр зүйлд “Зээлийн гэрээгээр зээл өгөгч нь мөнгө буюу адил шинж чанараар тодорхойлогдох эд хогилыг зээлдэн авагчийн өмчид шилжүүлэн өгөх үүрэг хүлээнэ. Зээлдэн авагч нь уул тоот мөнгө буюу адил шинж чанар, төрлийн эд хогилыг зээл өгөгчид буцаан өгөх үүрэг хүлээнэ” гэж гэрээний ойлголтыг илүү тодорхойлж, өмчлөлд шилжүүлэх хөрөнгө болон буцаан өгөх үүргийн харилцааг тодорхойлжээ. Мөн 269, 270 дугаар зүйлүүдээр банкнаас албан байгууллага болон иргэдэд зээл олгох асуудлыг тусгайлан зохицуулж эхэлсэн.

1994 оны ИХ-ийн 229.1 дүгээр зүйлд “Зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь мөнгө, бусад эд хөрөнгийг зээлдэгчийн өмчлөл буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд шилжүүлэх, зээлдэгч нь авсан мөнгө буюу ижил төрөл, чанар хэмжээний эд хөрөнгийг зээлдүүлэгчид буцаан өгөх үүрэг тус тус хүлээнэ” гэж зээлийн гэрээний зохицуулалтыг зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцүүлэн шинэчилсэн.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2002 оны ИХ-ийн 281-286 дугаар зүйлд зээлийн гэрээний үндсэн зохицуулалтыг тусгасан бөгөөд мөнгөн зээлийн гэрээний суурь эрх зүйн үндэс болдог. (Монгол улсын Иргэний хуулийн тайлбар, 560 дугаар тал, 2018 он)

2.1.2 Зээлийн гэрээтэй холбоотой гол хууль тогтоомж

Монгол улсын хууль тогтоомжид зээлийн харилцааг зээл олгож буй субъект зориулалтаас хамааран хэд хэдэн хэлбэрт хувааж ялгаатай байдлаар зохицуулдаг. ИХ-иар иргэд хоорондын зээл (281-285 дугаар зүйл), барьцаалан зээлдэх журмаар олгох зээл (286 дугаар зүйл)-ийн харилцааг тус тус зохицуулдаг.

ИХ-ийн тусгай ангийн 451-453 дугаар зүйлүүдэд банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээний харилцааг зохицуулжээ. Энэхүү зээлийн гэрээний хувьд ИХ-ийн 281 дүгээр зүйлийн 281.1-д заасан банк, эрх бүхий

этгээдээс бусад зээлдүүлэгчээс зээлдэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрөл, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх үүргийг тус тус хүлээсэн зээлийн гэрээ болон 286 дугаар зүйлийн 286.1-д заасан барьцаалан зээлдэх журмаар зээл олгох зээлийн гэрээнээс ялгаатай зохицуулалттай байдаг. Учир нь 451 дүгээр зүйлийн 451.1-д заасан гэрээний дагуу банк болон зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгож байгаа зээлийн харилцааг зохицуулсан гэдгээрээ онцлог юм.

Банкны тухай хууль (2010), Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002), Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль (2011) нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулдаг. Тухайлбал Банкны тухай хуулийн 1.1-т хуулийн зорилтыг *банк байгуулах, зөвшөөрөл олгох, түүнийг хүчингүй болгох, үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоох, хяналт тавих, тэдгээрт албадагын арга хэмжээ авахтай холбоотой харилцааг зохицуулахад* гэж, 2.1-т *“Банкны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”* гэж, 6.1.2-т банк Монголбанкны зөвшөөрөлтэйгээр зээлийн үйл ажиллагаа эрхлэх талаар заасан. (Банкны тухай хууль, 2010)

ББСҮАтХ-ийн 1.1-т *“банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.”* гэж, 2-1-т *“Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”* гэж, СЗХ-оос олгосон зөвшөөрлийн дагуу хуулийн 7.1.1-т заасан зээлийн үйл ажиллагаа эрхлэх талаар хуульчилсан. (Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, 2002)

ХЗХтХ-ийн 1.1-т *“Энэ хуулийн зорилт нь хадгаламж, зээлийн хоршооны эрх зүйн үндсийг тодорхойлж, түүний үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.”* гэж, 2.1-т *“Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”*, 10.1-т хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-оос олгохоор хуульчилсан. (Хадгаламж, зээлийн хоршооны тухай, 2011)

Түүнчлэн, МЗҮАтХ-ийг 2022 онд шинээр баталж, хуулийн 2.1-т *“Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”* гэж, 3.1-т хуулийн үйлчлэх хүрээг барьцаалан зээлдүүлэх журмаар

иргэнээс байнга ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбогдох харилцааг гэж, 11 дүгээр зүйлд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр, шаардлага хангасан этгээд аймаг, нийслэлийн засаг даргад, эсхүл СЗХ-нд өргөдөл гаргасны үндсэн дээр мөнгө зээлийн үйл ажиллагааг эрхлэх этгээдийн бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгохоор хуульчилсан байна. (Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай, 2022)

БЭБЭМХЗХШЗҮАтХ-ийн 4 дүгээр бүлэгт Банк болон зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн харилцааг илүү нарийвчлан зохицуулсан байдаг.

Хуулийн 19 зүгээр зүйлд банк, эрх бүхий этгээдийн зээлийн үйл ажиллагааг нарийвчлан зааж, хуулийн 19.10-т банкнаас олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Монголбанк, эрх бүхий этгээдээс олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг СЗХ баталж, хэрэгжилтэд хяналт тавихаар, 19.11-т банк болон эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээтэй холбогдсон журмыг зээлдүүлэгч этгээдийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу Монголбанк, СЗХ нь Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавихаар тус тус заасан байна. (Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай, 2021)

Түүнчлэн уг хуулийн 20 дугаар зүйлд зээлийн гэрээ, 21 дүгээр зүйлд зээлийн хүү, 23 дугаар зүйлд зээлийн батлан даалт, 24 дүгээр зүйлд барьцаа, 26 дугаар зүйлд зээл төлүүлэхтэй холбогдсон асуудлыг нарийвчлан зохицуулсан ба 27 дугаар зүйлийн 27.1-т *“Зээлдүүлэгч олгосон зээлдээ судалгаа хийж, зээлийнхээ үлдэгдлийг хууль, журамд заасны дагуу ангилж, харгалзах эрсдэлийн сан байгуулна.”* гэж хуульчилжээ.

Уг зээлийг ангилах, эрсдэлийн сан байгуулах зохицуулалт нь зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хянах, үүргийн биелэлтийг бодитой үнэлэх, маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх эрх зүйн ач холбогдолтой зохицуулалт тул холбогдох хуульд оруулсан хуулийн хамрах хүрээг судалж үзэв.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн 3.1-т *“Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон энэ хууль, гэрээнд заасан иргэн, төрийн болон хувийн өмчит хуулийн этгээдийн хооронд зээл, төлбөртэй холбогдон үүсэх мөнгөн төлбөрийн үүргийн талаарх мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хяналт тавихад энэ хууль үйлчилнэ.”* гэж хуулийн хамрах хүрээг тодорхойлсон. (Зээлийн мэдээллийн тухай, 2011)

Уг заалт нь ихэвчлэн ЗМС-нд мэдээлэл нийлүүлэгч болон уг сангаас мэдээлэл авагч этгээдүүд хамаардаг. Хууль гэрээнд заасан иргэн, хуулийн этгээд гэх ангилалд зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй жирийн иргэд хоорондын зээлийн харилцаа шууд хамаардаггүй.

Иргэд хоорондын зээлийн мэдээллийг уг санд бүртгэх эсхүл иргэн өөрөө зээлдэгчийнхээ мэдээллийг уг санд нийлүүлэх боломжтой эсэх болон энэ төрлийн зээлийн мэдээллийг санд нийлүүлэх эрх зүйн зохицуулалт холбогдох хууль, тогтоомжид тодорхой тусгагдаагүй байна.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд гэдэгт холбогдох төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан хуулийн

этгээдүүд болох банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо багтаж байна.

Эдгээр эрх бүхий этгээдийн эрхлэн явуулах зээлийн үйл ажиллагаанд холбогдох хууль, зохицуулагч байгууллагын дотоод бодлого, журамд зааснаар зээлдэгчийн төлбөрийн чадварыг үнэлэх, эрсдэлийг тооцох, барьцаа, баталгааг шаардах зэрэг үндсэн шаардлагыг тогтоосон. Зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаа, батлан даалт, даатгал зэрэг олон төрлийн үүргийн гүйцэтгэл хангах арга, хэрэгслийг зээлийн гэрээний харилцаанд нь өргөн хэрэглэгддэг. Эрх бүхий этгээдээс олгох зээл нь хэрэглээний, бизнесийн, орон сууцны, ипотекийн, цалингийн, кредит картын, тэтгэврийн гэх зэрэг бүтээгдэхүүний төрлөөр, заавал бичгээр болон цахим хэлбэрээр байгуулсан зээлийн гэрээний үндсэн дээр байгуулагддаг, гэрээнд зээлийн хэмжээ, хүү, хугацаа, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, хариуцлагын нөхцөл зэрэг тодорхой байдаг.

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын дагуу актив /зээл/ төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан байгуулах, зарцуулахад банканд тавигдах доод шаардлагыг тогтоодог бөгөөд журмын 1.3-т зааснаар активыг хугацааны олон чанарын ангиллаар 5 түвшинд ангилж, эрсдэлээ тооцдог.

Зээлийн харилцаа, зээл олгох, үүргийн гүйцэтгэл хангуулах болон бусад үйл ажиллагаанд банк нь Монголбанкны хяналтад, бусад эрх бүхий этгээд нь СЗХ-ны хяналтын дор явагддаг. Монголбанк болон СЗХ нь эдгээр эрх бүхий этгээдэд үйл ажиллагаанд заавал мөрдөх шинжтэй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, тус шалгуур үзүүлэлт хангагдаагүй тохиолдолд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах эрхтэй байдаг.

Дээрхээс үзэхэд зээлдүүлэгчийн эрх зүйн байдалтай холбоотойгоор банк болон болон эрх бүхий этгээдийн зээлийн харилцаа салбарын тусгай зохицуулсан хууль эрх зүйн нарийвчилсан зохицуулалттай, (1) урьдчилсан судалгаа, (2) бичгээр гэрээ, (3) барьцаа батлан даалт, (4) зохицуулагч эрх бүхий байгууллагын хяналт гэсэн хэд хэдэн төрлийн давхар хамгаалалттай хэрэгждэг.

2.1.3 Иргэд хоорондын зээлийн гэрээ, үүргийн гүйцэтгэлийн онцлог

Иргэд хоорондын зээлийн гэрээ нь ИХ-ийн 281-285 дугаар зүйлээр зохицуулагддаг бөгөөд гэрээний чөлөөт байдлын зарчимд тулгуурласан, ихэвчлэн итгэлцэлд суурилсан, албан бус шинж давамгайлсан харилцаа юм. Тодруулбал нэг удаагийн шинжтэй буюу тогтмол үйл ажиллагаа явуулж ашиг олох зорилгогүй, ах дүү, хамаатан садан, найз нөхөд, танилын хүрээнд олгох зээлд 281 дүгээр зүйлд заасан зээлийн гэрээний харилцаа хамаарна.

Зээлийн гэрээ нь (1) өмчлөх эрх шилжүүлэх шинжтэй буюу зээлдэгч нь эд хөрөнгийг эзэмших, өмчлөх эрхтэй, (2) үүрэг нь төрлийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгийг буцаан өгөх хэлбэртэй, (3) зээлийн гэрээ нь практикт ихэвчлэн мөнгөн хэлбэрээр хэрэгждэг шинжийг агуулдаг.

Иргэний хуулийн 42.1-т зааснаар талууд зээлийн гэрээг хэлэлцэн тохирч амаар, бичгээр, цахим хэлбэрээр байгуулах боломжтой.

Мөн талууд тохиролцвол хуулийн 282.1-д заасны дагуу хүү тогтоож болно. Харин хүүгийн хэмжээ зээлдэгчийн хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтой тогтоогдсон бол түүний хүсэлтээр шүүх зээлийн хүүг багасгаж болохыг 282.2-т заасан. Хэдийгээр талууд зээлийн хүүг гэрээний чөлөөт байдлын зарчмын үндсэн дээр тохиролцон тогтоох боломжтой ч уг зарчмыг нийгмийн тэнцвэрт байдлыг хангах зарчим, шударга ёсны зарчим болон нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн хязгаарлаж байгаа хэлбэр болно. Гэвч зээлийн гэрээний хувьд тусгай ангийн шийдлийг сонгосон явдал нь зах зээлд нөлөө бүхий байр суурийг эзэлсэн тал гэрээт хугацаанд ямар ч эрсдэлгүй өндөр хүүтэй зээлийн гэрээ байгуулж, эсрэг тал нь маргаан гаргасан нөхцөлд л дундаж хүүг тогтоолгох шударга бус алхмыг сонгосон шийдэл байна. (Буянхишиг.Б, Иргэний эрх зүйн тусгай анги: Гэрээний эрх зүй, 2021) .

Харин хүү тогтоосон зээлийн хувьд бичгийн хэлбэр заавал шаардлагатай ба энэ шаардлагыг хангаагүй бол хүү шаардах эрх үүсэхгүй (ИХ 282.4). Практикт зээлийн гэрээг бичгээр байгуулах хандлага нэмэгдэж байгаа боловч амаар байгуулагдсан гэрээний хэлбэрээр зээлийн харилцаа үүсэх нь түгээмэл хэвээр байна.

Зээлдүүлэгчийн үндсэн үүрэг нь зээлийн гэрээний дагуу зээлдэгчийн өмчлөлд мөнгө шилжүүлэх бол зээлдэгч нь зээлийг буцаан төлөх, хүү тохиролцсон бол хүү төлөх үүрэгтэй. Зээлийг буцаан төлөх хугацааг талууд гэрээгээр тогтоох бөгөөд хэрэв хугацаа тохиролцоогүй бол зээлдүүлэгчийн шаардсанаас хойш нэг сарын дотор үүргийг гүйцэтгэхээр хуульчилсан (ИХ 283.1).

Иргэд хоорондын зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг дараах үе шатны хүрээнд авч үзэх боломжтой. Үүнд:

Гэрээ байгуулах үе шат: Зээлдүүлэгч нь мөнгө буюу эд хөрөнгийг зээлдэгчийн өмчлөлд шилжүүлснээр гэрээ байгуулсанд тооцогддог. Бэлнээр өгөх, шилжүүлэх гэхчлэн захиран зарцуулах эрхийг бий болгох аль ч төрлийн хэлбэрээр гүйцэтгэх боломжтой. Мөн зээлдүүлэгч гуравдагч этгээдийн хэрэгжүүлэх шаардах эрхээ зээлдэгчид шилжүүлж (ИХ 123 дугаар зүйл), уг этгээдийг зээлдэгчид өрөө төлөхийг мэдэгдэх боломжтой. Гуравдагч этгээдээс зээлдэгчид мөнгө шилжүүлсэн нөхцөлд зээлдүүлэгчийн үүрэг гүйцэтгэгдсэнд тооцогдоно (Буянхишиг.Б, Иргэний эрх зүйн тусгай анги: Гэрээний эрх зүй, 2021) .

Практикт гэрээ нь ихэвчлэн бичгээр баталгаажаагүй, ойр дотно, танилын хүрээнд байгуулагддаг нь үүргийн гүйцэтгэлийн шатанд нотлох баримтын сул талыг бий болгодог.

Эх үүсвэр: Банк, эрх бүхий этгээд нь өөрийн болон түүнд хадгалуулсан бусдын мөнгөн хөрөнгө (хадгаламж, харилцах данс дахь мөнгөн хөрөнгө гэх мэт)-ийн зохих хэсгийг өөрийн нэрийн өмнөөс бусад этгээдэд зээл олгодог бол иргэд өөрийн хөрөнгөөр зээл олгодог.

Үүрэг гүйцэтгэх үе шат: Зээлдэгч тохирсон хугацаа, нөхцөлийн дагуу зээлийг буцаан төлөх үүрэг хүлээдэг (ИХ 281.1, 282.1). Гэрээгээр хугацаа тогтоогоогүй бол зээлдүүлэгчийн шаардсанаас хойш 1 сарын дотор төлөх үүрэгтэй (ИХ 283.1). Гэрээний гүйцэтгэл нь гэрээний нөхцөлөөс гадна талуудын харилцан итгэлцэл, зан төлөвөөс ихээхэн хамаарах бөгөөд гэрээнд заасан эрх, үүргээ үнэнч шударга хэрэгжүүлэх (ИХ

13.1) зарчимтай (good faith) уялдаатай байдаг нь уг зээлийн харилцааны онцлог юм.

Үүрэг зөрчигдөх үе шат: Зээлдэгч үүргээ хугацаанд нь биелүүлээгүй нөхцөлд зээлдүүлэгч алданги, хүү шаардах, барьцаа болон бусад эд хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангах, онцгой нөхцөл буюу зээлдэгчийн барьцаа хөрөнгө муудсан, үнэлгээ буурсан, эд хөрөнгийн байдал доройтсон гэж үзэх үндэслэл зээлдүүлэгчид бий болвол нэн даруй буцаан шаардах эрхтэй (ИХ 284 дугаар зүйл). Гэвч бичгээр гэрээгүй, нотлох баримт сул нөхцөлд үүргийн зөрчлийг тогтооход хүндрэл үүсдэг.

Төлбөр барагдуулах дараалал: ИХ-ийн 216.4-т зааснаар үүргийн гүйцэтгэл нь өрийг төлөхөд хүрэлцэхгүй бол тэргүүн ээлжинд шүүхийн зардал, дараа нь үндсэн үүрэг, эцэст нь хүү төлүүлэхээр хуульчилсан. Харин олон улсын практикт үүргийн гүйцэтгэлийн хугацаа хэтрүүлсэн нөхцөлд хүү тохирсон гэрээнд тэргүүн ээлжинд зардал, хүү, үндсэн төлбөр гэсэн дарааллаар үүргийн гүйцэтгэлийг хуваарилах зохицуулалттай байна. Энэ нь зээлийн гэрээнээс үүдэлтэй маргаанаас зайлсхийж, гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар хэрэгжүүлэх нөхцөлийг бий болгоход ач холбогдолтой гэж үздэг байна.

Шүүхийн өмнөх шат: Эвлэрүүлэн зуучлалыг хэрэгжүүлэх нь шүүхийн ачааллыг бууруулах, иргэд үүссэн маргааныг шүүхэд хянан шийдвэрлүүлэхтэй харьцуулахад мөнгө, цаг хугацааны хэмнэлттэй, эвийн журмаар шийдвэрлэх зэрэг сонголтот хувилбар байдаг.

ЭЗТХ-ийн 3.1-т зааснаар Иргэний эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх боломжтой ба эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэй байгуулсан гэрээ нь ИХ-д нийцсэн, гуравдагч этгээдийн эрх ашгийг хөндөөгүй, хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан, бичгээр хийсэн тохиолдолд шүүгч баталгаажуулах боломжтой. Иргэний хэрэгт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхэд шүүхэд иргэний хэрэг маргаан үүсгэснээс хойш талууд хүсэлт гаргах, эсхүл шүүгч санал болгосныг талууд зөвшөөрвөл эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулж болох зохицуулалттай. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхэлснээс хойш 60 хоногийн хугацаанд талууд эвлэрэн хэлэлцэх боломжтой, энэхүү хугацаанд багтаж эвлэрлийн гэрээ байгуулаагүй бол тус ажиллагаа дуусгавар болно. Иргэд хоорондын зээлийн гэрээний маргааны агуулга, нөхцөл байдал нь ялгаатай хугацаа шаардагддаг тул хуулиар хугацааны хязгаар тогтоосон нь эвлэрэл амжилттай болоход сөрөг нөлөөлөх үр дагавартай байна.

Монгол улсад шүүх дэх эвлэрүүлэн зуучлал, шүүхээс гадуур бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлал байх холимог тогтолцоотой ба шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын бодит хэрэгжилт хангалтгүй түвшинд байна. Шалтгааныг шүүхээс гадуурх төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод эвлэрүүлэн зуучлагч ажиллаж, талуудын маргааныг амжилттай шийдвэрлэсэн ч тус эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулдаггүй нь тухайн маргаанаар дахин шүүхэд хандах, нэмэлт зардал үүсэх, цаг хугацаа алдах зэрэг сөрөг нөлөөллийг үзүүлж байсантай холбоотой гэж дүгнэсэн байна (JICA, Шүүхийн ерөнхий зөвлөл, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний тайлан, 2020) .

Шүүхийн шат: Зээлдүүлэгч үүргийн гүйцэтгэл хангуулах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд энэ харилцааг ИХШХШТХ-иар зохицуулдаг ба шүүхэд нэхэмжлэл гаргахад гэрээ, холбогдох баримтууд, гэрчийн мэдүүлэг зэрэг нотлох баримтууд ач

холбогдолтой байдаг.

Шийдвэр гүйцэтгэх үе шат: Шүүхийн шийдвэр гарсны дараа үүргийн гүйцэтгэлийг албадан хангуулах ажиллагаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд хэрэгждэг. Энэ үед данс битүүмжлэх, орлогоос суутгах, эд хөрөнгө хураах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг боловч зээлдэгчийн хөрөнгийн ил тод бус байдал зэргээс шалтгаалан гүйцэтгэл хангагдахгүй байх эрсдэлтэй байна.

Үүрэг дуусгавар болох үе шат: Зээлдэгч үндсэн зээл болон хүүг бүрэн төлснөөр үүрэг дуусгавар (ИХ 236 дугаар зүйл) болно. Мөн талуудын харилцан тохиролцоогоор гүйцэтгэсэн үүрэгтэй ижил өөр үүргийн гүйцэтгэл хүлээн авсан бол гэрээний талууд өмнөх үүргийг солихоор харилцан тохиролцсноор үүрэг дуусгавар болж болно.

Иргэд хоорондын зээлийн харилцаа нь банк, эрх бүхий этгээдийн зээлээс ялгаатай нь хууль эрх зүйн орчны нарийн зохицуулалтгүй, аливаа зохицуулагч байгууллагын хяналтгүй хэрэгждэг, нотлох баримтын сул байдал, өрийн дарамтад ордог зэрэг нь нэг талаас үүргийн гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйл болдог бол нөгөө талаас үүргээ үнэнч шударгаар биелүүлэх, харилцан итгэлцлийг хүндэтгэх суурь зарчим хэрэгжихгүй байгаатай холбоотой байна.

2.2 Иргэд хоорондын зээлийн гэрээний маргааны өнөөгийн байдал

Монгол улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2021-2025 оны нэгдсэн статистик мэдээллээс харахад иргэний эрх зүйн маргааны тоо тогтвортой өсөх хандлагатай байна.

Үүний дотор банк болон эрх бүхий байгууллагаас олгосноос бусад төрлийн иргэд хоорондын шинжтэй зээлийн гэрээтэй холбоотой маргааны тоо жил ирэх тусам нэмэгдсэн үзүүлэлттэй байна. (Хүснэгт 3-ыг үзнэ үү)

Хүснэгт 3. Иргэний хэрэг, түүнд эзлэх зээлийн хэрэг маргааны тоо, өсөлт

№	Он	Иргэний эрх зүйн маргаан (тоо)	Иргэний эрх зүйн маргааны өсөлт %	Бусад зээлийн маргаан (тоо)	Бусад зээлийн маргааны өсөлт %
1	2021 он	24531	22.8%	925	16.0%
2	2022 он	34015	38.7%	1,032	42.0%
3	2023 он	41354	21.6%	923	19.9%
4	2024 он	49091	18.7%	7,020	10.4%
5	2025 он	71017	44.7%	11,584	10.2%

Эх сурвалж: (ШЕЗ, Шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ, 2021-2025; ШЕЗ, Шүүн таслах ажиллагааны нэгдсэн тайлан, 2021-2025)

Хүснэгт 3-аас харахад 2021 онд 24,531 хэрэг маргаан шийдвэрлэгдэж байсан бол 2025 онд 71,017 болж 2.9 дахин өссөнөөс иргэд хоорондын зээлийн шинжтэй маргаан 925-аас 11,584 болж 12.5 дахин өссөн нь нийт иргэний хэргийн өсөлтөөс илүү нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэсэн өргөдлийн тоо

ЭЗТХ-ийг 2012 онд баталж, эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэй хэрэгжүүлэх буюу албан бус замаар шийдвэрлэх тогтолцоог (Informal Enforcement) бүрдүүлсэн.

ШЕЗ-ийн 2021-2025 оны шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээнд үндэслэн Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдөл болон шийдвэрлэсэн байдлыг динамикаар Зураг 3-т харуулав.

Зураг 3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны динамик 2021-2025 он



Эх сурвалж: (ШЕЗ, Шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ, 2021-2025)

Зураг 3-аас харахад 2021 онд 19,337 өргөдөл ирж эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны амжилттай эвлэрэл 68.6 хувь байгаа нь амжилтын хувьд өндөр үзүүлэлт байна. Харин өргөдөл гаргасан тоо 2022 онд хамгийн өндөр буюу 22,059 болж өссөн боловч амжилттай эвлэрлийн хувь 64 хувь байж өмнөх оноос 4.6 хувиар буурсан. Амжилттай эвлэрлийн хувь 2024 онд хамгийн бага буюу 61 хувь болсон ба 2025 оны байдлаар энэ үзүүлэлт 62.9 хувь болж өссөн. Жилд дунджаар 12,000-14,000 гаруй өргөдлийг эцэслэн шийдвэрлэж байгаагаас эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ тогтворжиж байна.

Эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэгдэж байгаа маргааны төрөл болон шүүхийн ачааллыг бууруулахад гүйцэтгэж буй үүргийг мөн харуулав. (Зураг 4-ийг үзнэ үү)

Зураг 4. Маргааны төрөл, шүүхийн ачаалал 2021-2025 он



Эх сурвалж: (ШЕЗ, Шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ, 2021-2025)

Зураг 4-өөс харахад нийт шийдвэрлэсэн өргөдлийн 71.2 -74.2 хувийг иргэний эрх зүйн маргаан, 25-29 хувийг гэр бүлийн эрх зүйн маргаан, харин үлдэх 0.1 хувийг хөдөлмөрийн маргаан эзэлж байна.

Эвлэрүүлэн зуучлал нь ИХАШШ-ийн ачааллыг дунджаар 17-25 хувиар бууруулдаг талаар судалгаанд дурдсан байна (жишээ нь 2021 онд амжилттай болсон эвлэрэл нь нийт шийдвэрлэсэн хэргийн 18.1 хувийг эзэлж байв). Мөн зарим ачаалал ихтэй дүүргүүдэд 1 эвлэрүүлэн зуучлагчид жилд 1,300 гаруй өргөдөл ногдож байгаа нь шийдвэрлэлтийн чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэл байгааг онцолсон (ХЗДХЯ, “Эвлэрүүлэн зуучлалын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгцээ шаардлагыг урьдчилсан тандан судлах судалгааны тайлан, 2024) .

Гэвч ХЗДХЯ-ны хуулийн хэрэгжилт, хэрэгцээ шаардлагын тандах судалгааны 2024 оны тайлангаас үзэхэд Шүүхээс гадуурх (албан бус) эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагаа Монгол улсад зогсонги байдалд орсон байна. Үүний шалтгаан нь тэнд байгуулсан гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулж, албадан гүйцэтгэх (албан

ёсны) механизм байхгүйгээс иргэд заавал шүүхэд хандахаас өөр аргагүйд хүрдэгтэй холбоотойг судалгаагаар тогтоожээ. Өндөр хөгжсөн орнуудад шүүхээр шийдвэрлүүлсэн маргаан болон эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлсэн маргааны харьцаа 1:1 буюу ойролцоо байдаг бол манай улсад энэ харьцаа 4:1 байна. Эндээс хувийн буюу арилжааны эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага, нөөц, эрэлт хэрэгцээ байгааг харуулж байна (ХЗДХЯ, “Эвлэрүүлэн зуучлалын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгцээ шаардлагыг урьдчилсан тандан судлах судалгааны тайлан, 2024).

Бусад зээлийн гэрээний маргааны тоо:

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх 5 жилийн хугацаагаар шүүлт хийж үзэхэд бусад зээлийн маргааны төрөлд нийт 21,484 маргааныг ИХАШШ-ээр хянан шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэсэн хэрэг маргааны шүүхийн шатлал, шийдвэрийн байдлаар үзвэл дараах байдалтай байна. (Хүснэгт 4-ийг үзнэ үү)

Хүснэгт 4. ИХ-ийн шүүхээр шийдвэрлэсэн зээлийн маргааны шийдвэр

Он	Анхан шатны шүүх			Давж заалдах шатны шүүх			Хяналтын шатны шүүх		
	хүчинтэй	хүчингүй	нийт	хүчинтэй	хүчингүй	нийт	хүчинтэй	хүчингүй	нийт
2021	613	312	925	305	2	307	117	10	127
2022	563	469	1032	333	7	340	190	23	213
2023	521	402	923	283	8	291	6	4	10
2024	5397	1623	7020	268	1	269	17	1	18
2025	8604	2980	11584	247	3	250	12	2	14
Нийт	15698	5786	21484	1436	21	1457	342	40	382

Эх сурвалж: (МУ-ын шүүхийн шийдвэрийн цахим сан, 2021-2025)

Хүснэгт 4-өөс харахад Анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн зээлийн маргааны 15,968 (73.1%) хэрэгт нэхэмжлэлийг хангаж, 5786 (26.9%) хэрэгт нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. Ойролцоогоор дөрвөн хэрэг тутмын нэгэнд зээлдүүлэгчийн шаардлага хангагдахгүй байна. Тодруулбал нийт 5,786 хэрэгсэхгүй шийдвэрлэгдсэн нь зээлийн харилцаа үүссэн боловч зээл олгосон эсэх, үүргийн гүйцэтгэлийг нотлох баримт хангахгүй байх тохиолдол байгааг харуулж байна.

Мөн Анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо өндөр байгаа боловч Давж заалдах шатны шүүхэд шилжсэн хэргийн тоо харьцангуй бага байна. Тухайлбал 2025 онд Анхан шатны шүүхэд 11,584 хэрэг шийдвэрлэсэнээс Давж заалдах шатны шүүхэд 250 хэрэг хянан шийдвэрлэгдсэн. Үүнээс ихэнх тохиолдолд Анхан шатны шүүхийн шийдвэр хэвээр үлдэх, эсхүл талууд Эвлэрлийн гэрээ байгуулдаг буюу маргааныг дараагийн шатанд үргэлжлүүлэх сонирхол бага байгааг харуулж байна.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргээс маргааны шийдвэр, магадлалыг хэвээр үлдээх, гомдлыг хангахгүй орхих, нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг тогтоолтой 342 (89.5%) хэрэг, харин шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийг хэрэгсэхгүй болгосон 40 (10.5%) хэрэг байна.

Хяналтын шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн 342 маргаанаас 138 (40.4%) нь иргэд хоорондын зээлийн гэрээтэй холбоотой маргаан байгаа нь уг төрөл нь тусгайлан судлах шаардлагатай бие даасан асуудал болохыг харуулж байна.


Уг үзүүлэлтийн нь зээлийн маргааны тодорхой хэсэг нь гэрээний хэлбэр, нотлох баримтын бүрдэл, харилцааны шинж чанараас хамаарах боломжтой бөгөөд шалтгааныг кейс судалгаанд тулгуурлан нарийвчлан шинжлэх шаардлагатай байна.

2.3 Монгол улсын нийгмийн итгэлцлийн өнөөгийн байдал

Монгол улс дахь нийгмийн итгэлцлийн түвшин харьцангуй сул байгааг Олон улсын болон дотоодын судалгааны дүнд дурджээ. Энэ нь зөвхөн нийгмийн харилцаанд төдийгүй иргэд хоорондын гэрээний үүргийн гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйл болох боломжтой.

Олон улсын судалгааны хувьд 2022 оны World Values Survey-ийн тайланд иргэдийн итгэлцлийн түвшин Монгол Улсад 26 хувь байна. Бусад улстай харьцуулахад Дани 74 хувь, БНХАУ 63 хувь, АНУ 40 хувь, ОХУ 23 хувь байна.

Зураг 5. Итгэлцлийн түвшин 2022 он




Эх сурвалж: (Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа, IRIM)

Дотоодын судалгааны хувьд Хараат бус судалгааны хүрээлэн IRIM-ийн 2018 онд хэрэгжүүлсэн “Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-ны тайланд судалгаанд оролцогчдын талаас илүү (61%) нь бусдад итгэдэггүй гэж хариулсан. Бусдад туслах, бусдаас тусламж авах, бусдад итгэх үзүүлэлт дунджаар 10 онооноос 4.7 оноо байсан. Энэ нь иргэдийн хоорондын харилцан итгэлцэл хангалттай тогтворжоогүй байгааг харуулж байна.

Судалгаагаар хүмүүсийн итгэлцэл нь нийгмийн бүлгээс хамааран ихээхэн ялгаатай байгааг тогтоосон. Тухайлбал, танихгүй хүмүүст итгэх итгэл хамгийн бага (3.06) байгаа бол гэр бүлийн гишүүдэд итгэх итгэл хамгийн өндөр (9.74) байна. Өөрөөр хэлбэл, итгэлцэл нь өргөн нийгмийн хүрээнд бус, ойр дотно харилцаанд төвлөрсөн шинжтэй байна.

Зураг 6. Нийгмийн аль бүлэгт хамгийн их итгэдэг вэ?



Эх сурвалж: (Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа, IRIM)

Зураг 6 дахь үр дүнгээс харахад Монголд хувь хүмүүсийн хоорондын итгэлцэл нь нийт нийгмийн хэмжээнд жигд тархаагүй, харин гэр бүл, хамаатан садан, найз нөхдийн хүрээнд илүү төвлөрсөн байдал ажиглагдаж байна. Ийм нөхцөлд танилын хүрээнд үүссэн зээлийн харилцаа нь итгэлцэлд тулгуурлах боловч уг итгэл нь өргөн хүрээний нийгмийн баталгаагаар дэмжигдээгүй байдаг онцлогтой (IRIM, Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа: тойм, 2018).

Дээрх үр дүнг Олон улсын түвшинд харьцуулбал (Дэлхийн үнэлэмжийн судалгааны үр дүнгийн (2010) талаарх Ларсений дүн шинжилгээнд (2014)) 52 орны 5-д нь “бусдад итгэдэг” гэсэн хариулт “бусдад итгэдэггүй” гэснээсээ өндөр байдаг. Ларсен (2014) “нийгмийн итгэлцэл өндөр түвшинд байх нь ховор үзэгдэл юм” хэмээн онцолсон байна. Үүнтэй адилаар Монголд ч мөн хүн амын талаас илүү хувь нь (61% нь 5 хүртэлх оноогоор үнэлсэн) “бусдад итгэдэггүй” гэж хариулсан байлаа (IRIM, Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа: тойм, 2018).

Нийгмийн итгэлцлийн түвшин сул байгаа нөхцөлд иргэд хоорондын зээлийн харилцаа ихэвчлэн танилын хүрээнд, хувийн итгэл дээр тулгуурлан үүсдэг бөгөөд энэ нь нэг талаас гэрээ байгуулахад хялбар байдал үүсгэх боловч нөгөө талаас үүргийн гүйцэтгэлийг хангахад сөрөг үр дагавар үзүүлэх боломжтой байна.

2.4 Гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт

Япон улс: Тус улсын иргэд хоорондын зээлийн эрх зүйн харилцааг Иргэний хууль (Civil code, Act No. 89 of April 27, 1896, n.d.)-ын зохицуулалтын хүрээнд авч судлав.

Япон улсын ИХ-ийн 587 дугаар зүйлд зааснаар хэрэглээний зээлийн гэрээ (loans for consumption) нь нэг тал нь нөгөө талынхаа өмчлөлд мөнгө болон бусад төрлийн эд хөрөнгө шилжүүлэх, нөгөө тал нь ижил төрөл, чанар, тоо хэмжээ бүхий эд хөрөнгө буюу мөнгө буцаан өгөхөөр амалснаар хүчин төгөлдөр болдог. Бичгээр байгуулсан зээлийн

гэрээ нь зээлийн зүйлийг бодитоор шилжүүлэн өгөхөөс өмнө талууд харилцан амлалт авснаар хүчин төгөлдөр болдог байна (Civil code 587.2(1)).

Хэрэв талууд хүүгийн талаар тухайлан тохиролцоогүй бол хуулиар тогтоосон 3 хувийн хүү үйлчилнэ (Civil code 404.1). Хүүгийн хэмжээ 3-н жил тутам зах зээлийн байдлаас хамааран өөрчлөгдөх боломжтой (Civil code 404.2). Зээлдүүлэгч нь зээлдэгч мөнгөө хүлээн авсан өдрөөс эхлэн хүү тооцох эрхтэй (Civil code 589.1). Монгол улсад зээлийн хүүгийн хэмжээг хуулиар тогтоогоогүй ба банкны зээлийн хүүгийн хэмжээг Монголбанкнаас тогтоосон аргачлалын дагуу тогтоодогоор ялгаатай байна.

Япон улсын ИХ-ийн 419 дүгээр зүйлийн 419.1 дэх заалтаар үүрэг гүйцэтгэгч мөнгөн төлбөрөө хугацаандаа төлөөгүй тохиолдолд талууд хүүгийн талаар тухайлан тохиролцоогүй бол хуулиар тогтоосон хүүгийн хэмжээгээр, эсхүл гэрээгээр тохирсон өндөр хүүгээр хариуцлага хүлээлгэх зохицуулалттай байна. Харин Монгол улсын ИХ-ийн 282.3-т хүү тогтоосон бол бичгээр, бичгээр хийгээгүй бол хүү шаардах эрхээ алддаг. Японы ИХ-ийн уг зохицуулалт нь зээлдэгчийн хариуцлагыг илүү албажуулсан буюу санхүүгийн ашиг сонирхолд шууд нөлөөлж, үүргийн гүйцэтгэлийг сайжруулахад дэмжлэг болохуйц байж болно.

Япон улсын ИХ-ийн 489 дүгээр зүйлээр төлбөр хуваарилах дарааллыг зохицуулсан. Хэрэв зээлдэгчийн төлсөн мөнгө нь нийт өрийг барагдуулахад хүрэлцэхгүй бол төлбөрийг (1) зардал, (2) хүү, (3) үндсэн зээл гэсэн дарааллаар хасдаг. Уг өрийн дараалал нь Монгол улсын ИХ-ийн 216.4-т заасан (1) үндсэн зээл, (2) хүү дарааллаас эсрэг бөгөөд зээлдэгчид санхүүгийн хариуцлага хүлээлгэх зарчимд суурилдагтай холбоотой. Мөн уг дараалал нь зээлдэгчийн өр хяналтгүй өсөхөөс сэргийлсэн, зээлдэгчийн үүргийн гүйцэтгэлд нөлөөлөх өрийн дарамтыг бууруулах ач холбогдолтой гэж үзэж байна.

Нээлттэй нийгэм форумын 2021 онд хийсэн Шүүхийн шийдвэрийн судалгааны тайланд Япон Улсын Иргэний болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиуд, шүүхийн шийдвэрүүдээс үзвэл нэхэмжлэгч нь шүүхэд нэхэмжлэл гаргахдаа төлж барагдуулаагүй зээлийн үлдсэн өр төлбөр, түүний хүүг шаардахын зэрэгцээ нэхэмжлэл гаргасан өдрөөс хойш бодогдох хугацаа хэтэрсний хүүг тодорхой дүн тусгалгүйгээр зөвхөн хүүгийн хувийг тодорхойлон хариуцагчаас нэхэмжилдэг байна. Үүний гол шалтгаан нь зээлдэгч болон зээлдүүлэгч хоорондын зээлийн харилцаанд зээлийн өр төлбөрөө төлж барагдуулах хүртэлх хугацааны турш зээлдэгч өр төлбөр төлж барагдуулах үүрэг хүлээх бөгөөд зээлийн гэрээний хугацаа дуусгавар болсноос үл хамааран хэтэрсэн хугацааны хүү төлөх нь шударга ёсны зарчимд нийцнэ гэж үздэг онолын ойлголтоос улбаатай. Ингэснээр Япон Улсын хувьд зээлдэгчид санхүүгийн сахилга бат бий болгож, зээлдэгчид шүүх дээр болон шүүхийн шийдвэрийг биелүүлэх, зээлийн үүргийг бүрэн гүйцэтгэх хүртэл хариуцлагаа хүлээсээр байна (Нээлттэй Нийгэм Форум, 2021).

Шүүхэд нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэл гаргасан өдрөөс хойш өр бүтэн төлөгдөх хүртэлх хугацаанд бодогдох хүүг тодорхой мөнгөн дүнгээр бус хүүгийн хувь хэмжээг (жишээлбэл жилийн 5%) тодорхойлон шаарддаг онцлогтой байна. Ингэснээр зээлдэгч зээлээ хэзээ төлж барагдуулна, тухайн цаг хугацаа хүртэл хүү төлөх үүрэгтэйг баталгаажуулж өгдөг давуу тал гэж үзэж байна.

Монгол улсын шүүхийн шийдвэрийн судалгаануудаас харахад шүүхийн практик зээлийн гэрээг цуцалснаас хойш хүү тооцох эсэхэд ялгаатай шийдвэрүүд гардаг. Харин Япон улсад зээлийн гэрээ цуцлагдсан эсэхээс үл хамааран зээлийг бодитоор буцаан төлөх хүртэл хүү төлөх үүрэг нь хэвээр үлддэг ялгаатай байна.

Оросын холбооны улс: ОХУ-ын ИХ болон Монгол улсын ИХ нь хоёулаа эх газрын буюу иргэнлэг эрх зүйн бүлд хамаардаг тул тогтолцооны хувьд ижил төстэй суурь зарчимтай байна.

ОХУ-ын Иргэний хууль (Гражданский кодекс - ГК РФ) нь үндсэн 4 бүлэгтэй ба 4 дүгээр бүлэг 1996 онд батлагдсан (Гражданский кодекс Российской Федерации часть 2 (ГК РФ ч.2), 1996). ОХУ-ын ИХ-ийн 42 дугаар бүлгийн 807-814 дүгээр зүйлд зээлийн гэрээний үндсэн зохицуулалтыг, 817-818 дугаар зүйлд тусгай төрлийн зээлийн харилцааг тус тус зохицуулсан байна.

- ❖ Зээлийн гэрээ (ст.807)
- ❖ Зээлийн гэрээний хэлбэр (ст.808)
- ❖ Зээлийн гэрээний хүү (ст.809)
- ❖ Зээлдэгчийн зээлийн мөнгөн дүнг буцаан төлөх үүрэг (ст.810)
- ❖ Зээлдэгч зээлийн гэрээг зөрчсөнөөс үүсэх үр дагавар (ст.811)
- ❖ Зээлийг бодит мөнгөн шилжүүлэг хийгдээгүй үндэслэлээр маргах (ст.812)
- ❖ Зээлдэгчийн үүргийн барьцаа, баталгааг алдагдуулсны үр дагавар (ст.813)
- ❖ Зориулалтын зээл (ст.814)
- ❖ Улсын зээл (ст.817)
- ❖ Өрийн үүргийг зээлийн үүрэгт шилжүүлэх (ст.818)

Гражданский кодекс-ийн 807 дугаар зүйлд заасан зээлийн гэрээний тодорхойлолт нь Монгол улсын ИХ-ийн 281.1-т заасантай ижил шинжийг агуулсан. Харин 808 дугаар зүйлээр иргэд хоорондын зээлийн хэмжээ 10,000 рублиас дээш, эсхүл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 10 дахин их бол заавал бичгээр гэрээ байгуулна. Хуульд заасан хэмжээнээс зээлийн дүн хэтэрсэн бол хүүтэй эсэхээс үл хамааран бичгээр байгуулахыг шаарддаг.

Хэрэв зээлийн гэрээнд хүүгийн талаар тохиролцож тусгайлан заагаагүй бол Оросын Төв банкны тухайн үеийн бодлогын хүүгээр хүү тооцох зохицуулалттай (ст.809). Уг заалтаас үзэхэд иргэд хоорондын зээл хүүтэй байх нөхцөл тогтсон байна.

Зээлийн үүргийг гэрээний нөхцөл хуулийн шаардлагын дагуу хэрэв тийм нөхцөл байхгүй бол ажил хэргийн хүрээнд тогтсон заншил болон үнэнч шударга байх (good faith) зарчимд нийцүүлэн “зохих ёсоор” гүйцэтгэхээр зохицуулсан (ст.309). ОХУ-ын шүүхийн практикт “зохих ёсоор” гүйцэтгэх зарчмыг тайлбарлахдаа хуулийн үгээр бус, харин зорилго талаас нь (purposive interpretation) хандаж, талуудын анхны хүсэл зоригийг хамгаалдаг байна (Правовая Навигационная система Закон РФ, 2010).

Үүргийн зөрчлийн хариуцлагын зохицуулалтыг авч үзвэл мөнгөн төлбөрийн үүргийг хугацааг хэтрүүлсэн бол бусдын мөнгийг хууль бусаар ашигласанд тооцож, Төв банкны бодлогын хүүгээр хүү тооцно (ст.395).

Зээлдэгч зээлээ хугацаанд нь төлөөгүй бол үндсэн хүүгээс гадна 395 дугаар зүйлд заасан хүүг нэмж төлнө. Тодруулбал ОХУ-д хариуцлагын хүүг Төв банкны бодлогын хүүтэй уялдуулах байдлаар үүргийн зөрчлийн хариуцлагыг илүү тодорхой зохицуулжээ.

Түүнчлэн 812 дугаар зүйлд зээлдэгч мөнгө буюу эд хөрөнгийг бодитоор хүлээн аваагүй гэдгээ нотлох замаар гэрээг маргах эрхийг тодорхой зааж өгсөн.

Уг заалтыг тодруулбал мөнгийг бодитоор шилжүүлэн өгснөөр зээлийн гэрээ байгуулсанд тооцогддог нь бодит гэрээ гэж үзэгддэг ижил шинжтэй. Монгол улсын Дээд шүүхийн зөвлөмжид зааснаар зээлдүүлэгч нь гэрээ байгуулж мөнгийг бодитоор шилжүүлснээ нотлох үүрэгтэй байдаг. Харин ОХУ-ын ИХ-д зааснаар зээлдэгч өөрөө мөнгө аваагүй болохоо нотлох буюу хариуцагчийн идэвхтэй үйлдлийг шаарддагаараа онцлог байна (ст.812). Учир нь зээлдэгч итгэл эвдэж, хариуцлагаас зугтах оролдлого хийх үйлдлээс тус заалтаар сэргийлдэг байна.

Итгэлцэл ба зан төлөвийн хүрээнд авч үзвэл Шүүхийн практикт хариуцагч тал мөнгийг бодитоор авсан атлаа “зээл биш байсан, зүгээр мөнгө авсан” гэж маргах нь үнэнч шударга байх зарчимд (good faith) харш гэж үздэг (Э.Мандалмаа Good faith in Mongolia (Монгол улс дахь үнэнч шударгын зарчим), 2015).

Бүлгийн дүгнэлт

Иргэд хоорондын зээлийн гэрээний хувьд банк, эрх бүхий этгээдийн зээлийн гэрээнээс ялгаатай боловч ИХ-д заасан нийтлэг шаардлагыг заавал хангах ёстой байна. Иргэд хоорондын зээлийн гэрээ нь ихэвчлэн харилцан итгэлцэл дээр суурилдаг, энгийн хэлбэрээр байгуулагддаг, зарим тохиолдолд бичгээр баталгаажуулдаггүй зэрэг онцлогтой тул маргаан үүсэх эрсдэл өндөр байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар иргэд хоорондын зээлийн маргаан 11,584 болж 12.5 дахин өссөн нь нийт иргэний хэргийн өсөлт (2.9 дахин)-өөс өндөр байгаа нь иргэний хэргийн шүүхийн үндсэн ачаалалд нөлөөлж байна. Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэн маргааны 40.4 хувийг энэ төрлийн маргаан эзэлж байгаагаас иргэд хоорондын зээлийн харилцааны эрх зүйн тодорхойгүй, хяналтгүй хэрэгждэг байдалтай холбоотой гэж дүгнэж болохоор байна.

Монгол хүмүүсийн зээлийн харилцаанд оролцох зан төлөвийн хандлага нь итгэлцэл дээр түлхүү суурилснаас эргээд үүргийн гүйцэтгэл хангагдахгүй, маргаан үүсэх гол хүчин зүйл болдог. Учир нь нийгмийн итгэлцэл сул (61% нь бусдад итгэдэггүй) боловч зээлийн харилцаа нь ихэвчлэн ойр дотнын танилын хүрээний итгэлцэлд тулгуурлан амаар байгуулагддаг. Зээлдэгчийн зээлээ төлөхгүй байх эрсдэл нь орлого, санхүүгийн чадамжаас илүүтэй хувь хүний өөрийгөө хянах чадвар, санхүүгийн шийдвэр гаргалт, маргаашийн соёл буюу юмыг хойшлуулах зан үйлтэй шууд холбоотой гэсэн бусад судлаачдын дүгнэлттэй судлаачийн зүгээс санал нийлж байна. Уг саналын үндэслэлийг дараагийн судалгааны бүлэгт кейс шинжилгээ хийх болно.

Япон болон ОХУ-ын иргэд хоорондын зээлийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан үзэхэд зээлийн харилцааг үнэнч шударга байх зарчимд (good faith) тулгуурлан зээлдэгчийн санхүүгийн хариуцлагыг хангах чиглэлд системтэйгээр зохицуулсан нийтлэг хандлага ажиглагдаж байгаа бөгөөд үүнд төлбөр барагдуулах дарааллыг (зардал, хүү, үндсэн зээл) тогтоож өрийн хяналтгүй өсөлтийг хязгаарлах, хүүг бодит хугацаанд тасралтгүй тооцох замаар үүргийн гүйцэтгэлийг түргэсгэх, зээлийн хүүг зах зээлийн эсхүл Төв банкны бодлоготой уялдуулах, тодорхой нөхцөлд гэрээг заавал бичгээр байгуулах, мөн шүүхийн практикт гэрээний тогтвортой байдлыг хамгаалан зээлдэгчээс идэвхтэй нотлох үүрэг шаардах зэрэг зохицуулалтууд зонхилж байна. Эдгээр зохицуулалт нь зээлдэгчийг үүргээ хугацаанд нь биелүүлэх эдийн засгийн болон эрх зүйн хөшүүргийг бүрдүүлж улмаар зээлийн маргааныг урьдчилан бууруулахад чиглэж байна.

Иргэд хоорондын зээлийн эрх зүйн зохицуулалтын сул байдал, тухайлбал Монгол улсын ИХ-ийн төлбөр төлөх дарааллын болон хүү шаардах эрхийн зохицуулалт зэрэг зарим заалт зээлдэгчийн санхүүгийн сахилга батыг сулруулж, зээлийн өр төлбөр төлөх сонирхлыг бууруулах, гэрээний хариуцлагаас зайлхийх давуу талыг олгож, зээлдүүлэгчийн хууль ёсны эрх ашгийг хохироох нэг шалтгаан болж байна.

Иймд зээлдэгчийн зан төлөвт нөлөөлөхүйц санхүүгийн хариуцлага болон үнэнч шударга байх зарчмыг хэвшүүлэх талаар цаашид судлах шаардлагатай болно.

БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

3.1 Судалгааны хүрээ, арга зүй

Энэхүү судалгаа нь иргэд хоорондын зээлийн гэрээний маргааны шалтгааныг тодорхойлох зорилготой ба чанарын болон тоон судалгааны аргыг хослуулсан эмпирик судалгааны дизайн ашигласан. Судалгааны ажлын үе шатыг найман алхамт загварт тулгуурлан тодорхойлсон болно. (Kumar Ranjit, “Research Methodogy: a step by step guide for beginners”, 2014)

3.1.1 Судалгааны таамаглал дэвшүүлсэн онол, арга зүй

Энэхүү судалгааны таамаглалууд нь Trust Theory, Behavioral Law and Economics болон Formal vs Informal Enforcement онолуудад тулгуурлан, иргэд хоорондын зээлийн гэрээний маргаанд нөлөөлж буй хүчин зүйлсийн шалтгаант хамаарлыг тодорхойлох зорилгоор дэвшүүлэв.

H1 : Гэрээний тодорхойгүй байдал маргаан үүсэх магадлалыг нэмэгдүүлнэ.

H2 : Ойр дотнын, итгэлцэлд суурилсан харилцаа маргаанд өртөх магадлал өндөр.

H3 : Зээлдэгчийн төлбөрийн чадвараас гадна хариуцлагын сул зан төлөв үүргийн гүйцэтгэлд нөлөөлнө.

H4 : Иргэдийн эрх зүйн мэдлэг, гэрээний соёл сайжрах нь маргаан бууруулна.

Таамаглалыг шалгах арга зүйг дараагийн дэд бүлгүүдэд дэлгэрэнгүй оруулав.

3.1.2 Судалгааны арга зүй

- ❖ Кейс судалгааны арга – Кэйс судалгааны дараах үндсэн алхмуудыг хэрэгжүүлж шүүхийн бодит шийдвэрүүдээс хариуцагчийн тайлбар, маргааны агуулгыг үзэж, нийтлэг шинжийг тодорхойлсон.
 - *Асуудлыг тодорхойлох*: Судалгааны гол зорилго юу вэ?
 - *Баримт цуглуулах*: Бодит болсон үйл явдал, оролцогч талууд, цаг хугацаа, орон зай болон холбогдох нотлох баримтуудыг цуглуулах ба ингэхдээ олон төрлийн эх үүсвэр ба арга техникийг ашиглахад оршино. Судалгааны асуултанд хариулах ямар баримтуудыг цуглуулах вэ, баримт шинжлэхдээ ямар арга хэрэглэх зэргээ судлаач өөрөө тодорхойлдог. Цугларсан баримтын ихэнх хувь нь чанарынх байх ба нөхцөл байдалд хөтлөх цөөн хэдэн өгөгдлийг харуулдаг. Кэйс тус бүрийн гаргасан тайлбар, агуулгыг шинжилж, нийтлэг хэв шинжийг тодорхойлно.
- ❖ Тоон судалгааны арга – Кэйс судалгаанаас гарсан өгөгдөлд статистик боловсруулалт, шинжилгээ хийнэ. Өгөгдлийг SPSS (Statistical Packages for Social Science) програмд оруулж тоон шинжилгээ хийнэ. (ашиглагдах цонх Data Editor /хянах/, Output /гаргах цонх/, Syntax /командын цонх/). Шинжилгээний үр дүнгээс маргаанд нөлөөлж буй хүчин зүйлсийг тоон байдлаар тодорхойлно.
- ❖ Харьцуулалтын арга: Тоон шинжилгээнээс тодорхойлогдсон үр дүнг харьцуулан ижил төстэй болон ялгаатай шинжүүдийг шинжилж, нэгтгэн дүгнэнэ.
- ❖ Анализ-синтезийн арга: Судалгааны явцад цуглуулсан хууль зүйн эх сурвалж, шүүхийн кейс, тоон үр дүн, харьцуулалтын шинжилгээний дүгнэлтүүдийг нэгтгэн

тайлбарлахад ашиглана. Маргаан үүссэн нийтлэг шалтгаан, эрх зүйн зохицуулалтын сул тал, практик хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх боломжтой санал, зөвлөмжийг боловсруулна.

3.2 Мэдээлэл цуглуулах болон шинжилгээ хийх

3.2.1 Мэдээлэл цуглуулах

Судалгаанд хоёрдогч эх сурвалжын мэдээлэл ашигласан ба Шүүхийн албан ёсны цахим сангаас (www.shuukh.mn) “бусад зээл” түлхүүр үгээр хайж 2021-2025 оны Хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдийг сонгон авсан. Кейс сонгоход дараах шалгуурыг баримталсан.

- ❖ Иргэн-иргэн хоорондын зээлийн маргаан байх;
- ❖ Зээлийн гэрээний харилцаа үүссэн байх;
- ❖ Шүүхэд нэхэмжлэл гаргах хүртэл төлөөгүй шалтгаан хариуцагчийн хариу тайлбарт тодорхой туссан байх;
- ❖ Төлөөгүй шалтгаан хариуцагчийн хариу тайлбарт тодорхой бус нөхцөлд Анхан шатны шүүх, Давж заалдах шатны шүүхийн шийдвэрээс шалтгааныг нягтлан баталгаажуулах;
- ❖ Гэрээний хэлбэр, барьцааны мэдээлэл байх.

3.2.2 Судалгааны түүвэр сонгох

Судалгааны зорилгод тулгуурлан энэхүү судалгаанд санамсаргүй бус/магадлалт бус түүврийн зорилгот түүврийн (purposive sampling) аргыг ашигласан. Энэ төрлийн түүвэр нь тухайн үзэгдлийг гүнзгий ойлгох зорилготой чанарын судалгаанд тохиромжтой арга юм (Kumar Ranjit, “Research Methodogy: a step by step guide for beginners”, 2014).

Шүүхийн албан ёсны цахим сангаас [/www.shuukh.mn/](http://www.shuukh.mn) 2021-2025 онд эцэслэн шийдвэрлэгдсэн иргэд хоорондын зээлийн гэрээтэй холбоотой 138 кейсийг урьдчилан тогтоосон шалгуурын дагуу сонгон авч маргааны шалтгаан, хэв шинжийг гүнзгий илрүүлэхэд чиглэсэн байдлаар судалгаанд хамруулав.

3.2.3 Судалгааны хязгаарлалт

- ❖ Зорилгот түүврийн арга ашигласан тул судалгааны үр дүн иргэд хоорондын зээлийн бүх маргааныг бүрэн төлөөлөхгүй.
- ❖ Шүүхийн шийдвэрт туссан хоёрдогч эх сурвалжид тулгуурласан тул бодит байдал дээрх албан бус тохиролцоо, харилцааг бүрэн илэрхийлэгдэхгүй байх боломжтой.
- ❖ Кейсийн агуулгыг тоон хэлбэрт оруулахад тодорхой хувьсагч, ангилалд бүлэглэхэд тодорхой хэмжээний субъектив байдал орж болно.
- ❖ SPSS програм ашигласан статистик шинжилгээ нь кейсийн өгөгдөлд суурилсан хамаарлыг илрүүлэх зорилготой тул шалтгаан хамаарлыг бүрэн нотлох боломжгүй байх, хувьсагчдын бүтэц нь гүнзгий статистик загварт хязгаарлалт үүсгэж болзошгүй.

3.2.4 Агуулгын шинжилгээ

Энэхүү судалгаанд кейсийн текстэн мэдээллийг задлах зорилгоор агуулгын шинжилгээний аргыг ашигласан (Hsieh H.F & Shannon S.E, https://www.researchgate.net/publication/7561647_Three_Approaches_to_Qualitative_Content_Analysis, 2005). Агуулгын шинжилгээг өгөгдлөөс шууд илэрч буй утга, хэв шинжийг тодорхойлох inductive болон онолын хүрээнд тулгуурлан ангилах deductive хандлагыг хослуулан хийсэн.

Кейс тус бүрийн хариуцагчийн тайлбар, төлбөр төлөөгүй шалтгаан, талуудын маргааны агуулга, шүүхийн тогтоосон үйл баримт, гэрээний нөхцөл болон нотлох баримтын агуулгыг харгалзан кодчилол хийсэн. Хариу тайлбар дахь түлхүүр утга, давтагдсан хэв шинж, ижил агуулгатай тайлбаруудыг нэгтгэн ангилж, нэг кейст хэд хэдэн хүчин зүйл давхар илэрч болох боловч маргаан үүсэхэд давамгайл нөлөө үзүүлсэн нөхцөл байдлыг үндсэн ангилал болгон тодорхойлсон.

Тухайлбал талуудын хувийн харилцаа, танилын хүрээ, албан бус тохиролцоо, хамтын ажиллагааны үл ойлголцол, үүргийн зааг тодорхойгүй байдал зонхилсон тохиолдлыг “итгэлцэл, харилцааны маргаан” гэж ангилсан. Харин гэрээний нөхцөл, мөнгөн дүн, зориулалт, хугацаа зэрэг нь бичгээр тодорхойгүй, эсхүл харилцан зөрүүтэй тайлбарлагдсан нөхцөл байдлыг “гэрээний тодорхойгүй байдал” хувьсагчид кодчилсон. Мөн “би биш”, “зээл биш”, “өөр хүн авсан” гэх байдлаар өмнөх тохиролцоо, үүргээс зайлсхийсэн шинж илэрсэн кейсүүдийг зан төлөвийн хүчин зүйлтэй холбоотой ангилалд хамруулсан.

Хүснэгт 5. Хувьсагчдын ангилал

№	Хувьсагчийн нэр	Код	Код/ утга	Кодолсон шалтгаан, агуулгын тайлбар
<i>Маргааны үндсэн шалтгаан (DV) REASON MAIN - Нийт 138 кейсийг маргааны үндсэн шинжээр нь 5 төрөлд багцалсан ангилал</i>				
1	Гэрээ, үүргийг үгүйсгэсэн	Reason1	0/1	Зээлдэгч мөнгө аваагүй, зээл биш гэж маргасан, үүргийг бүхэлд нь үгүйсгэж буй кейсүүд
2	Санхүүгийн боломжгүй байдал	Reason2	0/1	Зээл авснаа зөвшөөрөх боловч төлбөрийн чадваргүй болсон, орлого тасарсан, дампуурсан гэсэн шалтгаанаар төлж чадахгүй байгаа кейсүүд
3	Итгэлцэл, харилцааны маргаан	Reason3	0/1	Талуудын танил, хувийн харилцаа болон хамтын ажиллагааны үл ойлголцоолоос үүдэлтэй, үүргийн зааг тодорхойгүй болсон кейсүүд
4	Гуравдагч этгээдийн оролцоо	Reason4	0/1	Зээлийг өөр хүнд дамжуулсан эсхүл өөр хүний өмнөөс зээл авсан гэх шалтгаанаас үүдсэн кейсүүд
5	Тооцооны маргаан	Reason5	0/1	Хүү, алданги болон үндсэн зээлийн үлдэгдэл тооцоолол, дүн дээр хүлээн зөвшөөрөхгүй нөхцөл үүссэн кейсүүд
<i>Итгэлцлийн онолын хүчин зүйлс (TT)</i>				
6	Гэрээний тодорхойгүй байдал ба үүрэг үгүйсгэл	TT1	0/1	Танил тал, ойр, байнгын харилцаанд гэрээг албажуулаагүй эсхүл бичгээр гэрээгүй, гэрээний нөхцөл тодорхойгүй тохиолдлууд

7	Итгэлцэл 3-гч этгээдэд "тархах", хяналт алдагдах	TT2	0/1	Танил тал, ойрын, хувийн харилцааны итгэлээс зээлийг 3-гч этгээдийн нэрээр дамжуулснаар өөрийгөө бодит хариуцагч гэдгээ ухамсарлахгүй, үүргийн гүйцэтгэл шилжнэ гэсэн тохиолдлууд
8	Эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл	TT3	0/1	Барьцаагүй, бичгээр гэрээгүй, эрсдэлийг үнэлээгүй, цэвэр итгэлцлийн тохиолдлууд
<i>Зан төлөвийн эдийн засгийн хүчин зүйлс (BLE)</i>				
9	Хойшлуулах, хайхрамжгүй байдал	BLE1	0/1	Гэрээний нөхцөл тодорхойгүй, нотлох баримтгүй олголт зэргээр ирээдүйн үр дагаврыг тооцоогүй байдлаас хойшлуулах, хайхрамжгүй үйлдэл нөлөөлсөн тохиолдлууд
10	“Би биш” хандлага	BLE2	0/1	Мөнгө аваагүй, би биш өөр хүн авсан гэх хандлагаар үйл баримт болон гэрээний нөхцлийг өөрт ашигтайгаар тайлбарлаж, үүрэг хариуцлагаас зайлсхийсэн тохиолдлууд
11	Ашиггүй үеийн стратегийн үгүйсгэл	BLE3	0/1	Зээл биш ХО, хамтын ажиллагаа, тусламж гэж нөхцөл байдал өөрт ашиггүй болж өөрчлөгдөхөд өмнөх амлалтаасаа буцсан тохиолдлууд
12	Хэт өөдрөг төсөөлөл ба эрсдэлийн алдаа	BLE4	0/1	Бизнесийн ашиг болон төлбөрийн чадвараа бодит нөхцөл байдлаас хэт өөдрөг төсөөлж, эрсдэлээ тооцоогүйтэй холбоотой тохиолдлууд
<i>Эрх зүйн хэрэгжилтийн хүчин зүйлс (FIE)</i>				
13	Баримтгүй олголт ба төлөлт	FIE1	0/1	Зээл олголт, төлөлтийг баримтжуулаагүй буюу бэлэн олголт, бараагаас төлөлт гэх зэргээс нотлох баримтын бүрдүүлэлт дутуу нөхцөлтэй холбоотой тохиолдлууд
14	Гэрээнд оролцоогүй этгээд	FIE2	0/1	Зээлийг өөр хүнээр дамжуулан олгосон, өөр хүний нэр дээр авсан эсхүл дамжуулсан зээлсэн гэх байдлаар гэрээний хууль ёсны хариуцагч болон бодит ашиглагч зөрснөөс хариуцлагыг бусад руу шилжүүлсэн тохиолдлууд
15	Гэрээний төрөл тодорхой бус	FIE3	0/1	Албан ёсны гэрээний стандарт сул байдлаас шалтгаалж зээлийг хамтын ажил, тусламж гэх зэргээр өөр харилцаанд шилжүүлэн тайлбарласан тохиолдлууд

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Судалгааны ажлын энэхүү бүлэгтээ иргэд хоорондын зээлийн гэрээний маргааны шалтгаан, шийдвэрлэх арга замыг тодорхойлох чанарын болон тоон судалгааны хосолмол эмпирик судалгааны арга зүйг танилцуулав. Энэхүү арга зүй нь зээлийн маргааныг зөвхөн хууль, эрх зүйн зохицуулалт талаас бус, зан төлөв талаас ойлгох боломж бүрдэнэ.

Мөн судалгаанд мэдээлэл цуглуулах хоёрдогч эх үүсвэр болон санамсаргүй бус/магадлалт бус түүврийн аргыг зорилгот түүврийн (purposive sampling) аргын талаар тусгасан билээ. Зорилгот түүврийн хувьд 2021-2025 онд эцэслэн шийдвэрлэгдсэн иргэд хоорондын зээлийн гэрээтэй холбоотой 138 маргааны кейсийг урьдчилан тогтоосон шалгуурын дагуу сонгон авч судалгаанд хамруулав.

БҮЛЭГ 4. ЭМПИРИК СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ БА ҮР ДҮН

4.1 Өгөгдлийн шинжилгээ

Энэхүү судалгаанд иргэд хоорондын зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой маргаанд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор дараах статистик шинжилгээнүүдийг үе шаттайгаар гүйцэтгэлээ.

Судалгааны бүрэн бүтэн байдал болон үнэн зөвийг SPSS (Statistical Packages for Social Science) программ ашиглан шалгаж, алдаатай болон дутуу утгын хяналт (missing value check), тархалтын шалгалт болон статистикийн ач холбогдлын түвшинг 95%-ийн итгэлцлийн интервал ($\alpha = 0.05$)-аар үнэлсэн. Шалгалтын үр дүнгээс харахад өгөгдөл нь статистикийн шинжилгээ хийхэд шаардлагатай найдвартай байдлыг хангаж байгаа бөгөөд хувьсагч бүр нь магадлалын хувьд 95%-иас дээш итгэлцлийн түвшинд тайлбарлах боломжтой гэж үзэв.

Тус програмаар судалгаанд хамрагдсан 138 кейсийн үндсэн хувьсагчдын өгөгдлийн ерөнхий бүтэц, шинж чанарыг тодорхойлох, хувьсагч бүрийн давтамж, тархалтын хандлагыг илрүүлэх, хэлбэлзлийг тодорхойлох зорилгоор тодорхойлогч статистикийн шинжилгээ (Descriptive Statistics) болон давтамжийн (Frequency) шинжилгээ, хувьсагчдын хоорондын хамаарал статистикийн ач холбогдолтой эсэхийг хос хувьсагчийн хамаарлын (Crosstab Chi-square) шинжилгээ тус тус хийв.

Мөн хувьсагчдын хоорондын хамаарлын чиглэл, хүчийг тодорхойлох зорилгоор Корреляцийн шинжилгээ (Correlation Analysis), тодорхой маргааны төрөл үүсэх магадлалд аль хувьсагчид хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох зорилгоор Регрессийн шинжилгээ (Binary Logistic Regression) шинжилгээг тус тус хийж гүйцэтгэсэн бөгөөд эдгээр шинжилгээ нь тус бүр өөр өөр зорилготой боловч нийлбэр дүнгээрээ судалгаанд дэвшүүлсэн таамаглалуудыг шалгах, хувьсагчдын хоорондын хамаарал болон нөлөөллийг тогтоох, улмаар үр дүнг тайлбарлахад чиглэгдсэн болно.

4.1.1 Найдвартай байдлын шинжилгээ / Reliability Analysis /

Шинжилгээ хийж эхлэхээс өмнө судалгааны бүрэн бүтэн байдал болон үнэн зөвийг SPSS програмаар шалгаж, үнэн зөв байдлын статистикийн үзүүлэлт буюу Кронбахын альфа (Cronbach's Alpha, 1951) шалгасан ба Кронбахын альфа нь $0 \leq X \leq 1$ хооронд утгаа авах ба $0.7 \leq X$ байх нь ач холбогдолтой буюу судалгааны асуултуудын найдвартай байдлыг илэрхийлэхээс гадна энэхүү коэффициентээр шкалын хэмжээ оновчтой эсэхийг тодорхойлж байдаг. Тус судалгааны хувьд Кронбахын альфа = 0.774 буюу найдвартай байдлын хувьд ач холбогдолтой гэсэн үр дүн гарсан байна. (Хүснэгт 9-г харна уу)

Хүснэгт 6. Судалгааны найдвартай байдал (Reliability Statistics)

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.774	.791	29

Эх сурвалж. Судлаачийн тооцоолол, SPSS

4.1.2 Тодорхойлогч статистикийн шинжилгээ

Судалгаанд оролцогчдын мэдээлэл бүрт тодорхойлогч статистикийн шинжилгээ хийж, дундаж утгуудыг гаргасан бөгөөд хамаарах хувьсагчдаас харахад дундаж утга (Mean=0.60) гэрээний хэлбэр 0.60 буюу судалгаанд хамрагдсан зээлийн 60% бичгээр гэрээтэй, 40% нь бичгээр гэрээгүй байна. Нийт маргаанд барьцааны дундаж утга 0.25 буюу 75% нь барьцаагүй байгаа нь зээлийн эрсдэлийг бодитоор үнэлээгүй, зөвхөн итгэлцэлд суурилж олгогддог болох нь харагдаж байна. Зээлийн хэмжээний дундаж утга 2.03 байгаа нь кейсүүдийн 33.3% нь 5–20 сая төгрөгийн дүнтэй зээл эзэлж, маргааны хамгийн их хувийг бага дүнтэй зээл бүрдүүлж байгааг харуулж байна.

Онолын тулгуур хүчин зүйлсийн тархалтаар үзэхэд Итгэлцлийн онолын (ТТ) хүчин зүйлсээс ТТ1 (гэрээний тодорхойгүй байдал/үгүйсгэл)-ийн хүчин зүйлийн дундаж утга 0.75 байгаа нь нийт кейсийн 75%-д итгэлцэлд найдаж гэрээгээ албажуулаагүйгээс шалтгаалж зээлдэгч үүргээ үгүйсгэх арга хэрэглэж байгааг харуулж байна. Итгэлцэл тархах эрсдэлд кейсийн 31% (.31) нь зээлийг гуравдагч этгээдээр дамжуулснаас шалтгаалж үүссэн маргаан байна.

Зан төлөвийн эдийн засгийн онолын (BLE) хүчин зүйлээс BLE2 (“би биш” хандлага) хүчин зүйл 70%-ийн (.70) давтамжтай илэрсэн нь хариуцагчдын дийлэнх нь үүрэг хариуцлагыг өөрөөсөө зайлуулж, өөрт ашигтай байдлаар тайлбарлах зан үйлийн хүчтэй хазайлттай хандлага давамгайлж байгааг харуулж байна. BLE4 (хэт өөдрөг төсөөлөл ба эрсдэлийн алдаа) хандлага кейсийн 23% (.23) зээлдэгч өөрийн төлбөрийн чадвараа хэт өөдрөгөөр үнэлж (over-optimism) эрсдэлээ буруу тооцсоноос шалтгаалсан байна.

Албан ба албан бус хэрэгжүүлэлт (Formal vs Informal Enforcement - FIE) онолын хүчин зүйлээс кейсийн 40%-д (.40) мөнгийг бэлнээр өгсөн эсхүл бараагаар тооцож авсан зэрэг албан ёсны баримтгүй FIE1 (баримтгүй олголт ба төлөлт) харилцаа байсан нь тооцооны маргаан үүсгэх нөхцөл болжээ. Харин 30% (.30) нь FIE2 (гэрээнд оролцоогүй этгээд) буюу хариуцлагын субъектийн тодорхойгүй байдалтай холбоотой маргаан байна. (Хүснэгт 7-г үзнэ үү)

Хүснэгт 7. Тодорхойлогч статистикийн шинжилгээ (Descriptive Statistic)

	N	Minimum	Maximum	Mean	Std. Deviation
Байршил-1	138	1.00	2.00	1.2899	.45535
Зээлийн хэмжээ	138	1.00	4.00	2.0362	.89939
Гэрээний хэлбэр	138	0	1	.60	.491
Барьцаатай эсэх	138	0	1	.25	.437
ТТ-Гэрээний тодорхойгүй байдал ба үүрэг үгүйсгэл	138	0	1	.75	.437
ТТ-Итгэлцэл гуравдагч этгээдэд "тархах" ба хяналт алдагдах	138	0	1	.31	.465

ТТ-Эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл	138	0	1	.28	.448
BLE- Хойшлуулах, хайхрамжгүй байдал	138	0	1	.04	.205
BLE- "Би биш" хандлага	138	0	1	.70	.462
BLE- Ашиггүй үеийн стратегийн үгүйсгэл	138	0	1	.13	.338
BLE- Хэт өөдрөг төсөөлөл ба эрсдэлийн алдаа	138	0	1	.23	.424
FIE- Баримтгүй олголт ба төлөлт	138	0	1	.40	.491
FIE- Гэрээнд оролцоогүй этгээд	138	0	1	.30	.459
FIE- Гэрээний төрөл тодорхой бус	138	0	1	.14	.346
Valid N (listwise)	138				

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Тодорхойлогч статистикийн шинжилгээний үр дүнгээр харуулсан ерөнхий нөхцөл, харилцан хамаарлыг маргааны шалтгааны давтамжийн шинжилгээгээр дундаж утгаар харуулав. (Хүснэгт 8-ыг үзнэ үү)

Хүснэгт 8. Давтамжийн шинжилгээ (Frequencies Statistic)

	Гэрээ, үүргийг үгүйсгэсэн	Санхүүгийн боломжгүй/чадв аргүй	Итгэлцэл, харилцаа, хамтын ажиллагааны маргаан	Гуравдагч этгээдтэй холбоотой	Гүйцэтгэл, үлдэгдэл, хүү/алданги, тооцооны маргаан
N Valid	138	138	138	138	138
Missing	0	0	0	0	0
Mean	.28	.18	.09	.30	.16
Median	.00	.00	.00	.00	.00
Mode	0	0	0	0	0
Std. Deviation	.448	.387	.283	.459	.367
Minimum	0	0	0	0	0
Maximum	1	1	1	1	1
Sum	38	25	12	41	22

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Хүснэгт 8-аас харахад хамгийн өндөр давтамжтай (.30) шалтгаан Гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 30% буюу 41 кейсд, (28) Гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 28% буюу 38 кейсд илэрсэн.

Дээрх маргааны шалтгааныг 138 кейсийн статистик үр дүнгээр Итгэлцлийн онолын (Trust Theory-ТТ) хүрээнд буюу иргэд хоорондын зээлийн маргаан үүсэхэд "хувийн итгэлцэл" хэрхэн сөрөг нөлөө үзүүлж байгааг тоон утгаар хүснэгтээр харуулав. (Хүснэгт 9-г үзнэ үү)

Хүснэгт 9. ТТ хувьсагчдын тархалт (Frequencies Statistic)

		ТТ-Гэрээний тодорхойгүй байдал ба үүрэг үгүйсгэл	ТТ-Итгэлцэл гуравдагч этгээдэд "тархах" ба хяналт алдагдах	ТТ-Эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл
N	Valid	138	138	138
	Missing	0	0	0
Mean		.75	.31	.28
Median		1.00	.00	.00
Mode		1	0	0
Std. Deviation		.437	.465	.448
Minimum		0	0	0
Maximum		1	1	1
Sum		103	43	38

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Хүснэгт 9-өөс харахад Гэрээний тодорхойгүй байдал ба үүрэг үгүйсгэл (0.75) нь судалгаанд хамрагдсан кейсүүдийн дунд хамгийн өндөр давтамжтай, нийт маргааны 75%-д буюу 103 кейсд илэрсэн байна. Итгэлцэл гуравдагч этгээдэд "тархах" ба хяналт алдагдах (Mean=0.31) нийт кейсийн 31%-д буюу 43 кейсд итгэлцэл хоёр талын харилцаанаас хальж, гуравдагч этгээд рүү шилжсэн байна. Эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл (Mean=0.28) нийт маргааны 28%-д буюу 38 кейсд зээлдүүлэгч нь зээлдэгчийн төлбөрийн чадварыг огт үнэлэлгүйгээр зээл олгосон байна.

Итгэлцэлд суурилсан харилцаанаас гэрээний хяналт сулрах нөхцөл бүрдэж байгааг өмнөх хүснэгтэд харуулсан бол Зан төлөвийн эдийн засгийн онолын (Behavioral Law and Economics-BLE) хүрээнд зан төлөвийн хүчин зүйлсийн нөлөөллийг Хүснэгт 10-т харуулав.

Хүснэгт 10. BLE хувьсагчдын тархалт (Frequencies Statistic)

		BLE- Хойшлуулах, хайхрамжгүй байдал	BLE- "Би биш" хандлага	BLE- Ашиггүй үеийн стратегийн үгүйсгэл	BLE- Хэт өөдрөг төсөөлөл ба эрсдэлийн алдаа
N	Valid	138	138	138	138
	Missing	0	0	0	0
Mean		.04	.70	.13	.23
Median		.00	1.00	.00	.00
Mode		0	1	0	0
Std. Deviation		.205	.462	.338	.424
Minimum		0	0	0	0
Maximum		1	1	1	1
Sum		6	96	18	32

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Хүснэгтээс харахад “би биш” хандлага (Mean=.70) нийт маргааны 70%-д буюу 96 кейст илэрсэн байна. Энэ нь зээлдэгчид үүргээ зөрчсөн бодит баримтыг хүлээн зөвшөөрөхөөс илүүтэйгээр үйл явдлыг зөвхөн өөрт ашигтай хувилбараар тайлбарлах (self-serving bias) хандлага хүчтэй байгааг харуулж байна. Хэт өөдрөг төсөөлөл ба эрсдэлийн алдаа (Mean=.23) нийт кейсийн 23%-д буюу 32 кейсд зээлдэгч өөрийн санхүүгийн боломжийг хэт өндрөөр үнэлж, эрсдэлийг буруу тооцсон байна. Ашиггүй үеийн стратегийн үгүйсгэл (Mean=.13) нийт кейсийн 13%-д буюу 18 кейсд нөхцөл байдал өөрт ашиггүй болох үед зээлдэгч харилцааг зориудаар үгүйсгэсэн. Харин хойшлуулах, хайхрамжгүй байдал (Mean =.04) статистик утгаар хамгийн бага 4% буюу 6 кейсд байна.

Зан төлөвийн хүчин зүйлсийн шинжилгээнээс хариуцагчийн “би биш” хандлага давамгайлж байгааг харуулсан бол Албан ба албан бус хэрэгжилтийн онол (FIE)-ын хүчин зүйлсийн статистик үр дүн нь иргэд хоорондын зээлийн харилцаа эрх зүйн хувьд яагаад маргаан дагуулж байгааг хүснэгтэд тоон утгаар харуулав. (Хүснэгт 11-г үзнэ үү)

Хүснэгт 11. *FIE хувьсагчдын тархалт (Frequencies Statistic)*

	FIE- Баримтгүй олголт ба төлөлт	FIE- Гэрээнд оролцоогүй этгээд	FIE- Гэрээний төрөл тодорхой бус
N Valid	138	138	138
Missing	0	0	0
Mean	.40	.30	.14
Median	.00	.00	.00
Mode	0	0	0
Std. Deviation	.491	.459	.346
Minimum	0	0	0
Maximum	1	1	1
Sum	55	41	19

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Хүснэгт 11-ээс харахад баримтгүй олголт ба төлөлтийн (Mean=.40) хүчин зүйл нь нийт маргааны 40%-д буюу 55 кейсд илэрсэн бөгөөд зээлийн олголт, төлөлтөд (бэлнээр өгсөн, бараагаар тооцсон г.м) ямар нэгэн албан ёсны баримт үйлдээгүй байдалтай холбоотой. Гэрээнд оролцоогүй этгээд буюу хариуцлагын субъектын тодорхойгүй байдал (Mean = .30) хүчин зүйл нийт кейсийн 30%-д буюу 41 кейсд зээлийн харилцаанд гэрээнд оролцоогүй буюу гуравдагч этгээд (найз, нөхөр, хамаатан г.м) оролцсон байна. Гэрээний төрөл тодорхой бус байх (Mean=.14) хүчин зүйл нийт маргааны 14%-д буюу 19 кейсд гэрээний ангиллын маргаан үүссэн нь зээлдэгч тал уг харилцааг "зээл" биш, харин "хамтын ажиллагаа", "хөрөнгө оруулалт" эсвэл "тусламж" байсан гэсэн шалтгаантай байна.

4.1.3 Хамаарлын шинжилгээ

Судалгааны хувьсагчдын хоорондын хамаарлыг тодорхойлох зорилгоор Crosstab болон Chi-square шинжилгээг ашиглан хамаарал статистикийн ач холбогдолтой эсэхийг шалгасан бөгөөд уг шинжилгээгээр хамаарах хувьсагч болох маргааны шалтгаан болон үл хамаарах хувьсагчдын хооронд статистикийн ач холбогдол бүхий хамаарал байгаа

эсэхийг тогтоохын зэрэгцээ судалгааны таамаглалуудыг анхан шатанд шалгах, мөн итгэлцэл, зан төлөв, эрх зүйн хүчин зүйлсийн харьцангуй нөлөөллийг тодорхойлох зорилгыг хангасан бөгөөд шинжилгээг дараах томъёоллын дагуу хийж, хувьсагчдын утгуудыг дараах байдлаар кодлов.

- ❖ **Хамаарах хувьсагч (DV) - REASON5_CODE** (зээл төлөгдөөгүй шалтгааны 5 ангилал)
- ❖ **Үл хамаарах хувьсагч (IV) – Q1_BAIRSHIL** (байршил), **LOAN_AMOUNT_CAT** (зээлийн хэмжээ), **Q3_CODE** (гэрээний хэлбэр), **Q4_CODE** (барьцаатай эсэх), **TT** (итгэлцлийн хүчин зүйлс), **BLE** (зан төлөвийн хүчин зүйлс), **FIE** (эрх зүйн хамгаалалтын хүчин зүйлс)

Дээрх үл хамаарах хувьсагчид нь зээл төлөгдөөгүй шалтгааны ангилалд (REASON5_CODE) статистикийн хувьд ач холбогдолтой нөлөө үзүүлж байгаа эсэхийг тогтооно.

- ❖ $p < 0.05$ бол статистикийн ач холбогдолтой буюу хамааралтай
- ❖ $p > 0.05$ бол ач холбогдолгүй буюу хамааралгүй

Хи-квадрат (χ^2) шинжилгээгээр үл хамаарах хувьсагчид болох бүтцийн болон онолын хүчин зүйлс нь зээл төлөгдөөгүй үндсэн шалтгаануудтай статистикийн ач холбогдол бүхий хамааралтай эсэхийг тодорхойлсон.

4.1.3.1 Бүтцийн хувьсагчдын хамаарлын шинжилгээ

Бүтцийн хувьсагчдын хувьд маргааны шалтгаантай статистикийн ач холбогдол бүхий хүчтэй хамаарал илрээгүй нь эдгээр хүчин зүйлс маргаан үүсэх ерөнхий нөхцөлийг бүрдүүлдэг боловч маргааны төрлийг тодорхойлогч гол хүчин зүйл биш болохыг харуулж байна.

Байршил ба Шалтгааны хүчин зүйлийн хамаарал

Байршил болон зээл төлөгдөөгүй шалтгааны 5 ангиллын хоорондын хамаарлыг шалгахад $\chi^2=6.347$, ач холбогдлын түвшин $p=0.175$ байгаа нь зээлийн маргаан гарсан байршил болон маргаан үүссэн үндсэн шалтгаан хооронд статистик ач холбогдол бүхий хамааралгүй байна. (Хүснэгт 12-г үзнэ үү)


Хүснэгт 12. *Байршил ба шалтгааны хамаарал /Chi-Square test/*

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	6.347 ^a	4	.175
Likelihood Ratio	6.810	4	.146
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 7-оос харахад бүлгүүдийн тархалт тодорхой ялгарахгүй, харьцангуй жигд байгаагаас үзэхэд маргааны шалтгаан байршлаас үл хамааран ижил түвшинд илэрдэг болохыг харуулж байна. ОН-т 40 кейс, УБ-т 98 кейс байгаагаас УБ-т 3-гч этгээдтэй холбоотой маргаан хамгийн их буюу 35 кейсээр илүү байна.

Зураг 7. Байршлын хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зээлийн хэмжээ ба Шалтгааны хамаарлын шинжилгээ

Зээлийн хэмжээ болон шалтгааны ангиллын хооронд $\chi^2=10.573$, ач холбогдлын түвшин $p=0.566$ гарсан. Зээлийн мөнгөн дүнгийн хэмжээ маргаан үүсэхэд дангаар нөлөөлдөггүй буюу статистик ач холбогдол бүхий хамааралгүй байна.


Хүснэгт 13. Зээлийн хэмжээ ба шалтгааны хамаарал /Chi-Square/

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	10.573 ^a	12	.566
Likelihood Ratio	13.793	12	.314
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 8-т харуулснаар 0–50 сая төгрөгийн зээл 72 кейс (52.2%) буюу хамгийн өндөр байна. Гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 20 кейс, гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 18 кейс, санхүүгийн боломжгүй/чадваргүй шалтгаан 14 кейс, гүйцэтгэл, үлдэгдэл, хүү, алдангийн маргаан 12 кейс байна. 10 саяас доош зээлд гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 14 кейс, гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 10 кейс байна. Зээлийн хэмжээ өсөх тусам нэг төрлийн шалтгаан дангаар давамгайлаагүй боловч 10–50 саяын бүлэгт маргаан хамгийн их төвлөрсөн байна.

Зураг 8. Зээлийн хэмжээний хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Гэрээний хэлбэр ба Шалтгааны хамаарлын шинжилгээ

Гэрээний хэлбэр ба шалтгааны хоорондын хамаарлыг шалгахад $\chi^2 = 4.023$, ач холбогдлын түвшин $p=0.403$ гарсан бөгөөд гэрээг бичгээр байгуулсан эсхүл амаар тохиролцсон эсэх нь маргааны төрлийг тодорхойлох статистикийн ач холбогдол бүхий хүчин зүйл биш болохыг харуулж байна.


Хүснэгт 14. Гэрээ * шалтгааны хамаарал /Chi-Square/

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	4.023 ^a	4	.403
Likelihood Ratio	3.998	4	.406
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 9-өөс харахад бичгээр байгуулсан гэрээ 83 кейс (60.1%), амаар байгуулсан гэрээ 55 кейс (39.9%) байна. Бичгээр байгуулсан гэрээнд гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 26 кейс, гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 18 кейс, санхүүгийн боломжгүй, чадваргүй шалтгаан 17 кейс байна. Амаар байгуулсан гэрээнд гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 20 кейс, гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 15 кейс байна. Амаар гэрээ байгуулсан тохиолдолд гэрээ, үүргийг үгүйсгэх маргаан өндөр байгаа бол бичгээр байгуулсан гэрээнд ч гуравдагч этгээдийн оролцоо өндөр хэвээр байна.

Зураг 9. Гэрээний хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Барьцаа ба Шалтгааны хамаарлын шинжилгээ

Барьцааны байдал болон маргааны шалтгааны хоорондын хамаарлыг шалгахад $\chi^2=8.569$, $p=0.073$ гарсан бөгөөд энэ нь 5%-ийн ач холбогдлын түвшинд статистикийн хувьд ач холбогдолгүй боловч 10%-ийн түвшинд сул хамаарал байгааг илтгэж байна. Иймээс барьцааны байдал нь маргааны шалтгаанд тодорхой хэмжээнд нөлөөлөх боломжтой боловч гол тодорхойлогч хүчин зүйл биш болохыг харуулж байна.


Хүснэгт 15. Барьцаа * шалтгааны хамаарал /Chi-Square/

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	8.569 ^a	4	.073
Likelihood Ratio	8.731	4	.068
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 10-аас харахад 103 кейс (74.6%) нь барьцаагүй зээл байна. Барьцаагүй зээлд гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 33 кейс, гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 27 кейс, гүйцэтгэл, үлдэгдэл, хүү, алдангийн маргаан 18 кейс, санхүүгийн боломжгүй, чадваргүй шалтгаан 15 кейс байна. Барьцаатай зээлд гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 14 кейс, санхүүгийн боломжгүй/чадваргүй шалтгаан 10 кейс байна. Барьцаагүй зээл давамгайл байгаа бөгөөд барьцаагүй үед гэрээ, үүргийг үгүйсгэх маргаан 33 кейсээр хамгийн өндөр байна.

Зураг 10. Барьцааны хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

4.1.3.2 Итгэлцлийн онолын (Trust Theory - TT) хүчин зүйлсийн хамаарал

TT1-Гэрээний тодорхойгүй байдал, үүрэг үгүйсгэл ба Шалтгааны хамаарлын шинжилгээ

Гэрээний тодорхойгүй байдал, үүрэг үгүйсгэл болон маргааны шалтгааны хоорондын хамаарлыг шалгахад $\chi^2=8.569$, $p=0.073$ гарсан бөгөөд энэ нь 5%-ийн түвшинд статистикийн ач холбогдолгүй боловч 10%-ийн түвшинд сул хамаарал байгааг илтгэж байна.


Хүснэгт 16. TT1 * шалтгааны хамаарал /Chi-Square/

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	8.569 ^a	4	.073
Likelihood Ratio	8.731	4	.068
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 11-ээс харахад TT1 илэрсэн буюу гэрээний тодорхойгүй байдалтай кейс 103 (74.6%) байна. Гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 33 кейс, гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 27 кейс, гүйцэтгэл, үлдэгдэл, хүү, алдангийн маргаан 18 кейс, санхүүгийн боломжгүй, чадваргүй шалтгаан 15 кейс байна. TT1 илрээгүй бүлэгт гуравдагч этгээдийн маргаан 14 кейс, үүрэг үгүйсгэсэн маргаан 5 кейс байна. Гэрээ тодорхойгүй үед үүргийг үгүйсгэх болон гуравдагч этгээдтэй холбоотой маргаан илүү үүссэн байна.

Зураг 11. TT1-ын хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

TT2-Итгэлцэл гуравдагч этгээдэд "тархах" ба хяналт алдагдах ба Шалтгааны хамаарлын шинжилгээ

Итгэлцэл гуравдагч этгээдэд дамжин тархах, улмаар хяналт сулрах үзэгдэл болон маргааны шалтгааны хоорондын хамаарлыг шалгахад $\chi^2=129.187$, $p<0.001$ гарсан нь статистикийн хувьд маш хүчтэй хамаарал байгааг илтгэж байна. Талуудын зээлийн харилцаанд “дамжуулан зээлдэгч” эсхүл гуравдагч этгээдийн оролцоо нэмэгдэх үед эрсдэл өсөх хандлагатай болохыг харуулж байна.


Хүснэгт 17. TT2 * шалтгааны хамаарал /Chi-Square/

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	129.187 ^a	4	.000
Likelihood Ratio	155.090	4	.000
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 12-оос харахад ТТ2 илэрсэн 43 кейс (31.2%)-ийн 41 кейс нь гуравдагч этгээдтэй холбоотой маргаан байна. Харин ТТ2 илрээгүй бүлэгт гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 37 кейс, санхүүгийн боломжгүй, чадваргүй шалтгаан 25 кейс, гүйцэтгэлийн маргаан 22 кейс байна. ТТ2 илэрсэн үед гуравдагч этгээдтэй холбоотой маргаан бараг дангаар давамгайлж байгаа нь итгэлцэл гуравдагч этгээдэд шилжих үед маргаан хяналтгүй болох эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Зураг 12. ТТ2-ын хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

ТТ3-Эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл ба Шалтгааны хамаарлын шинжилгээ

Эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл болон маргааны шалтгааны хоорондын хамаарлыг шалгахад $\chi^2=15.939$, $p=0.003$ гарсан нь статистикийн ач холбогдол бүхий хамаарал байгааг илтгэж байна. Зээл олгох үед зээлдэгчийн эрсдэлийг бодитой үнэлэлгүй, зөвхөн итгэлцэлд тулгуурласан байдал нь маргаан үүсэхтэй холбоотой байгааг харуулж байна.


Хүснэгт 18. ТТ3 * шалтгааны хамаарал /Chi-Square/

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	15.939 ^a	4	.003
Likelihood Ratio	17.364	4	.002
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 13-аас харахад ТТ3 илрээгүй бүлэг 100 кейс (72.5%), ТТ3 илэрсэн бүлэг 38 кейс (27.5%) байна. ТТ3 илэрсэн үед гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 16 кейс, гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 10 кейс, итгэлцэл, харилцааны маргаан 7 кейс байна. ТТ3 илрээгүй үед гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 28 кейс, гуравдагч этгээдийн маргаан 25 кейс, гүйцэтгэлийн маргаан 21 кейс байна. Эрсдэлийг үнэлээгүй итгэлцэл илэрсэн тохиолдолд гуравдагч этгээд болон гэрээний үүргийг үгүйсгэх маргаан давамгайлж байна.

Зураг 13. ТТЗ-ын хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

4.1.3.3 Зан төлөвийн эдийн засгийн (Behavioral Law and Economics - BLE) хүчин зүйлсийн хамаарал

BLE1-Хойшлуулах, хайхрамжгүй байдал ба Шалтгааны хамаарлын шинжилгээ

Хойшлуулах, хайхрамжгүй байдал (BLE1) болон маргааны шалтгааны хоорондын хамаарлыг шалгахад $\chi^2 = 6.113$, $p = 0.191$ гарсан бөгөөд энэ нь статистикийн ач холбогдол бүхий хамаарал илрээгүйг харуулж байна.


Хүснэгт 19. BLE1 * шалтгааны хамаарал /Chi-Square/

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	6.113 ^a	4	.191
Likelihood Ratio	6.746	4	.150
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 14-өөс харахад BLE1 илэрсэн кейс 6 (4.3%) байна. Энэ бүлэгт санхүүгийн боломжгүй, чадваргүй шалтгаан 3 кейс, гүйцэтгэлийн маргаан 1 кейс, гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 1 кейс, итгэлцэл, харилцааны маргаан 1 кейс байна. BLE1 илрээгүй бүлэгт гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 41 кейс, гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 37 кейс, санхүүгийн шалтгаан 22 кейс байна. BLE1-ийн давтамж маш бага тул нийт маргааны бүтцийг тайлбарлах гол хүчин зүйл гэж үзэхэд сул байна.

Зураг 14. BLE 1-ын хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

BLE2- "Би биш" хандлага ба Шалтгааны хамаарлын шинжилгээ

“Би биш” хандлага болон маргааны шалтгааны хоорондын хамаарлыг шалгахад $\chi^2=53.430$, $p<0.001$ гарсан нь статистикийн хувьд маш хүчтэй хамаарал байгааг илтгэж байна. Хариуцлагаас зайлсхийх, өөрөөсөө түлхэх зан төлөвийн хазайлт нь маргааны шалтгаантай нягт холбоотой болохыг харуулж байна.


Хүснэгт 20. BLE2 * шалтгааны хамаарал /Chi-Square/

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	53.430 ^a	4	.000
Likelihood Ratio	64.192	4	.000
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 15-аас харахад BLE2 илэрсэн бүлэг 96 кейс (69.6%) байна. Энэ бүлэгт гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 38 кейс, гүйцэтгэл, үлдэгдэл, хүү, алдангийн маргаан 21 кейс, гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 20 кейс, итгэлцэл, харилцааны маргаан 10 кейс байна. BLE2 илрээгүй үед гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 21 кейс, санхүүгийн шалтгаан 18 кейс байна. “Би биш” буюу хариуцлагаас зайлсхийх хандлага илэрсэн үед гэрээ, үүргийг үгүйсгэх маргаан 38 кейсээр хамгийн өндөр байна.

Зураг 15. BLE 2-ын хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

BLE3-Ашиггүй үеийн стратегийн үгүйсгэл ба Шалтгааны хамаарлын шинжилгээ

Ашиггүй нөхцөлд илрэх стратегийн үгүйсгэлийн хандлага болон маргааны шалтгааны хоорондын хамаарлыг шалгахад $\chi^2=30.482$, $p<0.001$ гарсан нь статистикийн хувьд ач холбогдол бүхий хамаарал байгааг илтгэж байна. Нөхцөл байдал өөрт ашиггүй болох үед зээлдэгч үүргээ стратегийн байдлаар үгүйсгэх хандлага нь маргааны шалтгаантай нягт холбоотой болохыг харуулж байна.


Хүснэгт 21. BLE3 * шалтгааны хамаарал /Chi-Square/

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	30.482 ^a	4	.000
Likelihood Ratio	33.368	4	.000
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 16-аас харахад BLE3 илэрсэн кейс 18 (13.0%) байна. Энэ бүлэгт гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 13 кейс, итгэлцэл, харилцааны маргаан 4 кейс, гуравдагч этгээдийн маргаан 1 кейс байна. BLE3 илрээгүй бүлэгт гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 40 кейс, гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 25 кейс, санхүүгийн шалтгаан 25 кейс, гүйцэтгэлийн маргаан 22 кейс байна. BLE3 илэрсэн тохиолдолд гэрээ, үүргийг үгүйсгэх маргаан 13/18 кейс буюу илт давамгайл байна.

Зураг 16. BLE 3-ын хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

BLE4-Хэт өөдрөг төсөөлөл ба эрсдэлийн алдаа ба Шалтгааны хамаарлын шинжилгээ

Хэт өөдрөг төсөөлөл, эрсдэлийг дутуу үнэлэх хандлага болон маргааны шалтгааны хоорондын хамаарлыг шалгахад $\chi^2=105.274$, $p < 0.001$ гарсан нь статистикийн хувьд маш хүчтэй хамаарал байгааг илтгэж байна. Зээлдэгч зээл авах үед эрсдэлийг бодитоор үнэлээгүй байдал нь маргааны шалтгаантай нягт холбоотой болохыг харуулж байна.


Хүснэгт 22. BLE4 * шалтгааны хамаарал /Chi-Square/

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	105.274 ^a	4	.000
Likelihood Ratio	110.396	4	.000
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 17-оос харахад зээлдэгч өөрийн боломжийг хэт өөдрөгөөр үнэлж, эрсдэлийг дутуу тооцсон байдал буюу BLE4 илэрсэн кейс 32 (23.2%) байна. Энэ бүлэгт санхүүгийн боломжгүй, чадваргүй шалтгаан 25 кейс, гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 4 кейс, итгэлцэл, харилцааны маргаан 3 кейс байна. BLE4 илрээгүй бүлэгт гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 41 кейс, гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 34 кейс, гүйцэтгэлийн маргаан 22 кейс байна. Хэт өөдрөг төсөөлөл, эрсдэлийн алдаа илэрсэн үед санхүүгийн боломжгүй/чадваргүй шалтгаан 25 кейсээр хамгийн өндөр гарсан байна.

Зураг 17. BLE 3-ын хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

4.1.3.4 Албан ба албан бус хэрэгжүүлэлтийн (Formal vs Informal Enforcement - FIE) хүчин зүйлсийн хамаарал

FIE1-Баримтгүй олголт ба төлөлт ба шалтгааны хамаарлын шинжилгээ

Баримтгүй олголт, төлөлт (FIE1) болон маргааны шалтгааны хоорондын хамаарлыг шалгахад $\chi^2=4.023$, $p=0.403$ гарсан бөгөөд статистикийн ач холбогдол бүхий хамаарал илрээгүй байна.


Хүснэгт 23. FIE1 * шалтгааны хамаарал /Chi-Square/

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	4.023 ^a	4	.403
Likelihood Ratio	3.998	4	.406
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 18-аас харахад FIE1 илэрсэн бүлэг 55 кейс (39.9%), илрээгүй бүлэг 83 кейс (60.1%) байна. FIE1 илэрсэн үед гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 20 кейс, гуравдагч этгээдийн маргаан 15 кейс, санхүүгийн шалтгаан 8 кейс байна. FIE1 илрээгүй үед гуравдагч этгээдийн маргаан 26 кейс, гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 18 кейс, санхүүгийн шалтгаан 17 кейс байна. Баримтгүй олголт, төлөлт нь маргаанд оролцож байгаа боловч дангаараа нэг төрлийн шалтгааныг хүчтэй тодорхойлохгүй байна.

Зураг 18. FIE1-ын хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

FIE2- Гэрээнд оролцоогүй этгээд ба Шалтгааны хамаарлын шинжилгээ

Гэрээнд оролцоогүй этгээд болон маргааны шалтгааны хоорондын хамаарлыг шалгахад $\chi^2=138.000$, $p<0.001$ гарсан нь статистикийн хувьд маш хүчтэй хамаарал байгааг илтгэж байна. Зээлийн харилцаанд гэрээний талуудаас гадуур этгээд оролцож, хариуцлагын субъект тодорхойгүй болох нөхцөл маргаан үүсэхтэй нягт холбоотойг харуулж байна.


Хүснэгт 24. FIE2 * шалтгааны хамаарал /Chi-Square/

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	138.000 ^a	4	.000
Likelihood Ratio	167.915	4	.000
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 19-өөс харахад FIE2 илэрсэн 41 кейс (29.7%) бүгд гуравдагч этгээдтэй холбоотой маргаанд хамаарч байна. Харин FIE2 илрээгүй бүлэгт гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 38 кейс, санхүүгийн шалтгаан 25 кейс, гүйцэтгэлийн маргаан 22 кейс, итгэлцэл, харилцааны маргаан 12 кейс байна. Гэрээнд оролцоогүй этгээдийн оролцоо илэрсэн тохиолдолд гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 100% давамгайлж байна.

Зураг 19. FIE2-ын хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

FIE3- Гэрээний төрөл тодорхой бус ба Шалтгааны хамаарлын шинжилгээ

Гэрээний төрөл тодорхой бус байдал болон маргааны шалтгааны хоорондын хамаарлыг шалгахад $\chi^2=33.179$, $p<0.001$ гарсан нь статистикийн ач холбогдол бүхий хамаарал байгааг илтгэж байна. Гэрээний ангилал, хэлбэр, эрх зүйн шинж тодорхойгүй байх нь төлбөрийн маргаантай нягт холбоотой болохыг харуулж байна.


Хүснэгт 25. FIE3 * шалтгааны хамаарал /Chi-Square/

	Value	df	Asymp. Sig. (2-sided)
Pearson Chi-Square	33.179 ^a	4	.000
Likelihood Ratio	36.075	4	.000
N of Valid Cases	138		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Зураг 20-оос харахад FIE3 илэрсэн 19 кейс (13.8%) байна. Энэ бүлэгт гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 13 кейс, итгэлцэл, харилцааны маргаан 5 кейс, гуравдагч этгээдийн маргаан 1 кейс байна. FIE3 илрээгүй бүлэгт гуравдагч этгээдтэй холбоотой маргаан 40 кейс, гэрээ, үүргийг үгүйсгэсэн маргаан 25 кейс, санхүүгийн шалтгаан 25 кейс, гүйцэтгэлийн маргаан 22 кейс байна. Гэрээний төрөл тодорхой бус үед гэрээ, үүргийг үгүйсгэх маргаан 13/19 кейс буюу хамгийн өндөр байна.

Зураг 20. FIE3-ын хамаарал



Дээрх Хи-квадрат шинжилгээний үр дүнгээс үзэхэд иргэд хоорондын зээлийн маргаан үүсэхэд байршил, зээлийн дүн, гэрээний хэлбэр зэрэг бүтцийн хүчин зүйлс дангаараа статистикийн ач холбогдол бүхий хүчтэй нөлөө үзүүлэхгүй байгаа бол зан төлөвийн хазайлт (BLE2, BLE4), итгэлцэл 3-гч этгээдэд тархах (TT2), мөн зээлийн харилцаанд гэрээний талуудаас гадуур этгээд оролцож, хариуцлагын субъект тодорхойгүй болох (FIE2) зэрэг онолын хүчин зүйлс нь маргааны шалтгаантай өндөр түвшний статистикийн ач холбогдолтой хамааралтай ($p < 0.001$) гарч байна. Энэ нь зээлийн маргаан нь зөвхөн гадаад бүтэцтэй нөхцөлөөс бус, харин зээлдэгчийн зан төлөв, итгэлцлийн механизмын алдагдал, эрх зүйн хэрэгжилтийн сул байдлаас үүдэлтэйгээр үүсэх хандлагатайг илтгэж байгаа бөгөөд улмаар эдгээр хүчин зүйлс нь маргаан үүсэх үндсэн нөхцөл болж байгааг харуулж байна.

Хамаарлын шинжилгээний үр дүнгээс үзэхэд зан төлөвийн хүчин зүйлс (H3) болон итгэлцэлтэй холбоотой хүчин зүйлс (H2) нь маргааны шалтгаантай статистикийн ач холбогдолтой хамааралтай ($p < 0.001$) байгаагаас эдгээр таамаглалууд дэмжигдэж байгааг харуулж байна.

4.1.4 Корреляцийн шинжилгээ

Корреляцийн коэффициент нь -1 ээс +1 хязгаарт орших ба $r > 0$ бол хоёр үзүүлэлт шууд, $r < 0$ бол урвуу хамааралтай болно. Корреляцийн шинжилгээний корреляцийн коэффициентын утгаас хамааруулан түүний зэргийг дараах байдлаар ангилна. Үүнд:

1. $0 = < |r| < 0.5$ – Сул, $0.5 = < |r| < 0.75$ – Мэдэгдэхүйц, $0.75 = < |r| < 0.9$ – Нягт, $0.9 = < |r| < 1$ – Хүчтэй, $|r| = 1$ – Төгс буюу функцын хамааралтай гэж тус тус ангилах бөгөөд үүнээс тэдгээрийн хоорондын уялдаа хамаарал ямар байгааг харуулна. (Статистикийн шинжилгээ, судалгаа хийх гарын авлага, МУҮСГазар, 2007)

Судалгаанд ашигласан хувьсагчдын хоорондын уялдаа, нөлөөллийг хэмжих зорилгоор хамаарлын шинжилгээний дараа таван үндсэн хүчин зүйлийн хүрээнд корреляцийн шинжилгээг хийж гүйцэтгэлээ. (Хүснэгт 26-г үзнэ үү)

Хүснэгт 26. Корреляцийн шинжилгээний үр дүн (Correlations)

		ТТ- Эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл	BLE- Хэт өөдрөг төсөөлөл ба ерсдэлийн алдаа	Гэрээ, үүргийг үгүйсгэсэн	Итгэлцэл, харилцаа, хамтын ажиллагаан ы маргаан	Гүйцэтгэл, үлдэгдэл, хүү/алданги, тооцооны маргаан
ТТ-Эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл	Pearson	1	-.185	-.017	.213	-.224
	Correlation					
	Sig. (2-tailed)		.030	.845	.012	.008
	N	138	138	138	138	138
BLE- Хэт өөдрөг төсөөлөл ба ерсдэлийн алдаа	Pearson	-.185	1	-.185	.013	-.239
	Correlation					
	Sig. (2-tailed)	.030		.030	.877	.005
	N	138	138	138	138	138

Гэрээ, үүргийг үгүйсгэсэн	Pearson	-0.017	-.185	1	-.190	-.268
	Correlation					
	Sig. (2-tailed)	.845	.030		.025	.001
	N	138	138	138	138	138
Итгэлцэл, харилцаа, хамтын ажиллагааны маргаан	Pearson	.213	.013	-.190	1	-.134
	Correlation					
	Sig. (2-tailed)	.012	.877	.025		.116
	N	138	138	138	138	138
Гүйцэтгэл, үлдэгдэл, хүү/алданги, тооцооны маргаан	Pearson	-.224	-.239	-.268	-.134	1
	Correlation					
	Sig. (2-tailed)	.008	.005	.001	.116	
	N	138	138	138	138	138

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Итгэлцэл (TT) болон зан төлөвийн хүчин зүйл (BLE)-ийн хооронд сул сөрөг хамаарал ($r = -0.185$, $p < 0.05$) илэрсэн нь итгэлцэл өндөр байх үед зан төлөвийн алдаа багасах хандлагатай байгааг харуулж байна. Харин итгэлцэл болон “харилцааны маргаан” (Reason3)-ын хооронд эерэг хамаарал ($r = 0.213$, $p < 0.05$) илэрсэн нь итгэл дээр суурилсан харилцаа ихсэхэд харилцааны зөрчил нэмэгдэх хандлагатай байгааг илтгэж байна. Энэ нь албан бус харилцаанд хяналт сул байдагтай холбоотой байж болно.

Мөн итгэлцэл болон “тооцооны маргаан” (Reason5)-ын хооронд сөрөг хамаарал ($r = -0.224$, $p < 0.01$) илэрсэн нь итгэлцэл өндөр үед тооцооны маргаан харьцангуй бага байгааг харуулж байна.

Зан төлөвийн хүчин зүйл (BLE) нь “гэрээ үгүйсгэх” болон “тооцооны маргаан”-тай сөрөг хамааралтай гарсан нь зан төлөвийн алдаа нь тодорхой нэг төрлийн маргаан үүсгэхээс илүүтэйгээр маргааны хэлбэрийг өөрчилж байгааг илтгэж байна.

Мөн “гэрээ үгүйсгэх” болон “тооцооны маргаан” хооронд сөрөг хамаарал ($r = -0.268$, $p < 0.01$) илэрсэн нь эдгээр маргаанууд ихэвчлэн давхар биш, тусдаа илэрдэг болохыг харуулж байна.

Корреляцийн шинжилгээний үр дүнгээс харахад зээлийн маргаан нь нэг шалтгаанаас бус, харин итгэлцэл, зан төлөв, гэрээний нөхцөл зэрэг олон хүчин зүйлээс хамтад нь шалтгаалж байна.

4.1.5 Логистик регрессийн шинжилгээ /Logistic Regress/

Судалгаанд зээл төлөгдөөгүй шалтгаанд нөлөөлөх хүчин зүйлс хоорондын хамаарлыг тодорхойлох, хүчин зүйлсийг магадлан үнэлэх зорилгоор логистик регрессийн шинжилгээг ашиглав. Хамаарах хувьсагч нь бинар (0.1) үед хэрэглэгддэг бөгөөд тухайн үйл явдал тохиолдох магадлалыг дараах байдлаар илэрхийлнэ.

Reason1: Гэрээ үүргийг үгүйсгэсэн

Иргэд хоорондын зээлийн маргааны үндсэн шалтгаануудын нэг болох “REASON 1: Гэрээ, үүргийг үгүйсгэх” (зээлдэгч мөнгө аваагүй, эсхүл зээл биш байсан гэж маргах) зан

үйлийг урьдчилан таамаглах зорилгоор логистик регрессийн шинжилгээ хийж, үр дүнг дараах хүснэгтүүдэд харуулав.

Суурь загвар: Итгэлцэл, зан төлөв зэрэг үл хамаарах хувьсагчдыг загварт оруулахаас өмнөх эхний төлөвийг илэрхийлнэ. Судалгаанд хамрагдсан нийт 138 кейсийг “0” буюу “үүргийг үгүйсгээгүй” гэж таамаглахад 72.5%-ийн нарийвчлалтай зөв ангилсан бөгөөд үүнээс 100 кейс нь “үүргийг үгүйсгээгүй”, 38 кейс нь “үүргийг үгүйсгэсэн” байна.

Хүснэгт 27. *Суурь загварын нөхцөл /Classification Table^{a,b/}*

	Observed	Predicted		
		Гэрээ, үүргийг үгүйсгэсэн		Percentage Correct
		0	1	
Step 0	0	100	0	100.0
	1	38	0	.0
Overall Percentage				72.5

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Загварын статистик ач холбогдол: Маргааны төрлийг урьдчилан таамаглах логистик регрессийн шинжилгээнд бие даасан хувьсагчдыг оруулахаас өмнөх суурь загварын тогтмол утга (Constant) $B = -0.968$ гарсан бөгөөд уг коэффициентийн статистикийн ач холбогдлыг илэрхийлэх Wald үзүүлэлт 25.780, ач холбогдлын түвшин $p < 0.001$ байгаа нь суурь загвар статистикийн хувьд ач холбогдолтойг харуулж байна. Магадлалын харьцаа болох $\text{Exp}(B) = 0.380$ гарсан нь судалгаанд хамрагдсан кейсүүдийн дотор “үүрэг үгүйсгэсэн” (38 кейс) тохиолдол “үүрэг үгүйсгээгүй” (100 кейс) тохиолдлоос харьцангуй бага байгаатай нийцэж байгаа бөгөөд энэ нь суурь ангиллын тархалтыг илэрхийлж байна.

Хүснэгт 28. *Загварын статистик ач холбогдол /Variables in the Equation/*

	B	S.E.	Wald	df	Sig.	Exp(B)
Step 0 Constant	-.968	.191	25.780	1	.000	.380

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Хүснэгт 14-өөс Reason 1 нь нийт маргааны 27.5% (38 кейс)-ийг эзэлж байгаа нь зан төлөвийн хүчин зүйлс (BLE4, BLE2)-ээр тайлбарлах боломжтойг харуулж байна.

Загварын статистик ач холбогдол: Зан төлөв, итгэлцэл, эрх зүйн хүчин зүйлсийг загварт оруулсны дараах нийт нөлөөг шалгасан бөгөөд $\text{Chi-square} = 77.521$, $p < 0.001$ гарсан нь сонгосон үл хамаарах хувьсагчид нь маргааны шалтгааныг (Reason1) тайлбарлахад статистикийн ач холбогдол бүхий нөлөөтэй байгааг илтгэж байна.

Хүснэгт 29. *Загварын статистик ач холбогдол /Omnibus Tests of Model Coefficients/*

	Chi-square	df	Sig.
Step 1 Step	77.521	11	.000

Block	77.521	11	.000
Model	77.521	11	.000

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Загварын чадвар: Nagelkerke R^2 нь логистик регрессийн загварын тайлбарлах чадварыг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд хамаарах хувьсагчийн өөрчлөлтийн хэдэн хувийг загварт орсон хувьсагчид тайлбарлаж байгааг харуулдаг. Судалгааны үр дүнгээр Nagelkerke $R^2 = 0.621$ гарсан нь зан төлөвийн хазайлт (BLE) болон итгэлцлийн хүчин зүйлс (ТТ) нь үүрэг үгүйсгэх магадлалын 62.1 хувийг тайлбарлаж байгааг илтгэж байна.

Хүснэгт 30. Загварын чадвар /Model Summary/

Step	-2 Log likelihood	Cox & Snell R Square	Nagelkerke R Square
1	84.911 ^a	.430	.621

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Нарийвчилсан ангилал: Загварт үл хамаарах хувьсагчдыг оруулсны дараа таамаглах чадвар мэдэгдэхүйц сайжирсан байна. Тухайлбал, загварын нийт ангилалтын нарийвчлал суурь загварын 72.5 хувиас 82.6 хувь болж өссөн. Загвар нь “үүргийг үгүйсгээгүй” кейсүүдийг 93.0 хувийн нарийвчлалтай, харин “үүргийг үгүйсгэсэн” (Reason1) кейсүүдийг 55.3 хувийн нарийвчлалтай зөв ангилж байгаа нь загварын ялгах чадвар харьцангуй сайн байгааг илтгэж байна.

Хүснэгт 31. Нарийвчилсан ангилал /Classification Table^{a,b/}

	Observed	Predicted		
		Гэрээ, үүргийг үгүйсгэсэн		Percentage Correct
		0	1	
Step 1	0	93	7	93.0
	1	17	21	55.3
Overall Percentage				82.6

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Хувьсагчдын нөлөөлөл: Логистик регрессийн шинжилгээгээр маргаан үүсэхэд зан төлөв болон итгэлцлийн хувьсагчид илүү жин дарж байна. BLE4 (хэт өөдрөг төсөөлөл, эрсдэлийг дутуу үнэлэх) хувьсагчийн Sig=0.044, магадлалын харьцаа буюу Odds Ratio Exp(B)=0.181 гарсан нь “үүрэг үгүйсгэх” (Reason1) маргаантай статистикийн ач холбогдолтой холбоотойг харуулж байна. Мөн Q3_CODE (гэрээний хэлбэр)-ийн Sig=0.052 гарсан нь 10%-ийн түвшинд уг маргаантай холбоотой байж болохыг харуулж, бичгээр гэрээтэй байх нь маргаан буурах хандлагатай байгааг илтгэж байна.

Харин BLE2 (“би биш” хандлага) болон ТТ2 (итгэлцэл гуравдагч этгээдэд шилжих) хувьсагчид загварын тайлбарлах чадварт (Nagelkerke $R^2 = 0.621$) чухал нөлөөтэй бөгөөд

магадлалын харьцаа Exp(B) өндөр байгаа нь өөрийгөө өмгөөлөх зан төлөв болон итгэлцлийн хяналт сулрах үед “үүрэг үгүйсгэх” магадлал нэмэгдэх хандлагатайг харуулж байна.

Хүснэгт 32. Хувьсагчдын нөлөөлөл /Variables in the Equation/

	B	S.E.	Wald	df	Sig.	Exp(B)	95% C.I. for EXP(B)	
							Lower	Upper
BAIRSHIL	-.853	.597	2.039	1	.153	.426	.132	1.374
Q3_CODE	-1.174	.605	3.765	1	.052	.309	.094	1.012
Q4_CODE	.208	.764	.074	1	.785	1.232	.275	5.511
TT2	18.730	55.325	.000	1	.997	136.120	.000	.
TT3	-.001	.612	.000	1	.999	.999	.301	3.315
BLE1	18.988	66.258	.000	1	.998	1763.107	.000	.
BLE2	36.960	68.139	.000	1	.996	1125.000	.000	.
BLE3	22.854	401.962	.000	1	1.000	8421.125	.000	.
BLE4	-1.709	.850	4.044	1	.044	.181	.034	.958
FIE2	-39.516	76.457	.000	1	.996	.000	.000	.
FIE3	-21.001	401.962	.000	1	1.000	.000	.000	.
Constant	-35.343	684.139	.000	1	.996	.000		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Логистик регрессийн шинжилгээний үр дүнгээс харахад “гэрээ, үүргийг үгүйсгэх” зан төлөвт зан төлөвийн эдийн засгийн хүчин зүйл (BLE4) статистикийн ач холбогдолтой холбоотой байгааг тогтоолоо. Харин гэрээний хэлбэр нь хязгаарлагдмал түвшинд, барьцааны хүчин зүйл статистикийн ач холбогдолгүй гарсан байна. Загварын тайлбарлах чадвар 62.1% байгаа нь судалгааны зорилгод нийцсэн хангалттай түвшинд тооцогдох бөгөөд зарим хувьсагчдын өндөр коэффициентууд нь өгөгдлийн бүтэц, хувьсагчдын давхардалтай холбоотой байж болохыг илэрхийлсэн байна.

Reason2: Санхүүгийн боломжгүй/чадваргүй байдал

Иргэд хоорондын зээлийн маргааны үндсэн шалтгаануудын нэг болох “REASON 2: Санхүүгийн боломжгүй/чадваргүй” (зээлдэгч бодитоор төлбөрийн чадваргүй болсон) нөхцөлийг урьдчилан таамаглах зорилгоор логистик регрессийн шинжилгээ хийж, үр дүнг дараах хүснэгтүүдэд харуулав.

Суурь ангилал: Логистик регрессийн загварт зан төлөв, итгэлцэл зэрэг хувьсагчдыг оруулахаас өмнө маргааны шалтгааны ерөнхий тархалтыг тодорхойлох зорилгоор суурь ангиллыг авч үзэв. Судалгаанд хамрагдсан 138 кейсээс 113 нь “санхүүгийн чадвартай”,

25 нь “санхүүгийн чадваргүй” ангилалд хамаарч байна. Загварт ямар нэгэн хувьсагч оруулаагүй нөхцөлд бүх кейсийг хамгийн өндөр давтамжтай ангилал болох “чадвартай” гэж таамаглахад 81.9%-ийн нарийвчлал гарсан байна. Энэхүү суурь үзүүлэлт нь зээлийн маргааны зөвхөн 18.1 хувь нь санхүүгийн бодит чадваргүй байдлаас шалтгаалж байгааг харуулж байна.

Хүснэгт 33. Суурь ангилал /Classification Table^{a,b}/

	Observed	Predicted		
		Санхүүгийн боломжгүй/чадваргүй		Percentage Correct
		0	1	
Step 0	Санхүүгийн 0	113	0	100.0
	боломжгүй/чадваргүй 1	25	0	.0
	Overall Percentage			81.9

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Суурь загварын тогтмол: Маргааны төрлүүдийн суурь тархалтын статистикийн ач холбогдлыг үнэлэх зорилгоор логистик регрессийн суурь загварын тогтмол үзүүлэлтийг авч үзэв. Шинжилгээний үр дүнд $B=-1.509$, $Wald=46.584$, $p<0.001$ гарсан нь суурь ангиллын тархалт статистикийн хувьд ач холбогдолтой бөгөөд “санхүүгийн чадваргүй” ангилал түүвэрт тодорхой хэмжээгээр төлөөлөгдөж байгааг харуулж байгаа боловч түүний давтамж нь “санхүүгийн чадвартай” ангиллаас харьцангуй бага байгаатай нийцэж байна.

Хүснэгт 34. Суурь загварын тогтмол /Variables in the Equation/

	B	S.E.	Wald	df	Sig.	Exp(B)
Step 0 Constant	-1.509	.221	46.584	1	.000	.221

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Суурь загварын статистик ач холбогдол: Зан төлөв, итгэлцэл, эрх зүйн хүчин зүйлсийг загварт оруулсны дараа загварын нийт ач холбогдлыг шалгахад $\text{Chi-square} = 122.950$, $p<0.001$ гарсан нь сонгосон хувьсагчид “санхүүгийн чадваргүй” (Reason2) нөхцөлийг тайлбарлахад статистикийн ач холбогдолтой байна.

Хүснэгт 35. Суурь загварын статистик ач холбогдол /Omnibus Tests of Model Coefficients/

	Chi-square	df	Sig.
Step	122.950	11	.000
Step 1 Block	122.950	11	.000
Model	122.950	11	.000

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Загварын тайлбарлах чадвар: Регрессийн загварын тайлбарлах чадварыг үнэлэхэд Nagelkerke $R^2=0.964$ гарсан нь загварт оруулсан зан төлөвийн (BLE) болон итгэлцлийн (TT) хүчин зүйлс нь “санхүүгийн чадваргүй” (Reason2) нөхцөлийн өөрчлөлтийн ихэнх хувийг тайлбарлаж байгааг илтгэж байна.

Гэхдээ ийм өндөр үзүүлэлт нь нэг талаас зан төлөвийн хазайлт болон итгэлцлийн хэлбэрүүд нь зээлдэгчийн санхүүгийн шийдвэр гаргалттай хүчтэй уялдаатай байж болохыг харуулж байгаа боловч нөгөө талаас хувьсагчдын давхцал, итгэлцэл давамгайлсан харилцааны бүтэц, зан төлөвийн хүчин зүйлсийн давхар нөлөөлөл зэрэг өгөгдлийн онцлогтой холбоотой байж болох талтай. Иймд судлаачдын зүгээс уг үр дүнг статистикийн эцсийн дүгнэлтэд шууд тусгалгүй, харин зан төлөвийн эдийн засаг болон итгэлцлийн онолын хүрээнд тайлбарлах нэмэлт үндэслэл болгон авч үзэв.

Хүснэгт 36. *Загварын тайлбарлах чадвар /Model Summary/*

Step	-2 Log likelihood	Cox & Snell R Square	Nagelkerke R Square
1	7.638 ^a	.590	.964

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Бие даасан хувьсагчдын нөлөө: Бие даасан хувьсагчдын нөлөөг үнэлэх зорилгоор логистик регрессийн шинжилгээ хийсэн бөгөөд үр дүнд бүх хувьсагчдын Sig утга $p<0.001$ гарсан нь загварт ялгарал маш өндөр байгааг илтгэж байна. Ийм үр дүн нь өгөгдлийн бүтэц, хувьсагчдын хоорондын хүчтэй уялдаа, эсхүл бүрэн ялгарал (perfect separation) үүссэн байж болох тул үр дүнд оруулалгүй, хүснэгтийг тайлбарлах байдлаар хязгаарлав. Тухайлбал BLE4 (хэт өөдрөг төсөөлөл) хувьсагчийн магадлалын харьцаа (Exp(B)) өндөр гарсан нь зээлдэгч эрсдэлийг дутуу үнэлэх зан төлөв нь “санхүүгийн чадваргүй” нөхцөлтэй нягт холбоотой байж болохыг харуулж байна.

Хүснэгт 37. *Бие даасан хувьсагчдын нөлөө /Reason 2/*

	B	S.E.	Wald	df	Sig.	Exp(B)	95% C.I. for EXP(B)	
							Lower	Upper
BAIRSHIL	16.992	34.430	.000	1	.996	239.844	.000	.
Q3_CODE	.000	1.837	.000	1	1.000	1.000	.027	36.623
Q4_CODE	17.389	2.770	.000	1	.995	356.490	.000	.
TT2	11.109	268.436	.000	1	1.000	66.071	.000	.
TT3	17.510	317.113	.000	1	.996	402.852	.000	.
BLE1	- 17.816	5225.355	.000	1	.997	.000	.000	.
BLE2	- 19.202	5225.355	.000	1	.997	.000	.000	.

BLE3	- 63.561	41648.711	.000	1	.999	.000	.000	.
BLE4	67.436	6497.641	.000	1	.992	1936.000	.000	.
FIE2	- 13.911	26253.927	.000	1	1.000	.000	.000	.
FIE3	29.537	40605.238	.000	1	.999	672.940	.000	.
Constant	- 65.919	10269.770	.000	1	.995	.000		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Логистик регрессийн шинжилгээний үр дүнгээс загвар статистикийн ач холбогдол хангалтгүй гарсан нь сонгосон тайлбарлагч хувьсагчдаар хамаарах хувьсагчийг тодорхой ялган тайлбарлах боломж хязгаарлагдмал байна. Тухайн шалтгаан зан төлөв, итгэлцэл, эрх зүйн хамгаалалтын хэлбэр зэрэг онолын хувьсагчдаар тодорхой ялгарахгүй, харин бусад шалтгаантай давхардан илэрдэг онцлогтой холбоотой байж болохыг харуулж байна. Reason 2 нь бие даасан шалтгаан гэхээс илүүтэйгээр зан төлөв болон харилцааны хүчин зүйлстэй нийлмэл байдлаар илэрч байгаа нь загварт тодорхой нөлөө илрэхгүй байх нөхцөл болсон байна. Иймд уг шалтгааныг тайлбарлахдаа логистик регрессийн үр дүнг шууд ашиглалгүй, харин тодорхойлох болон хамаарлын шинжилгээний үр дүнтэй уялдуулан дүгнэлт хийв.

Reason3: Итгэлцэл, харилцаа, хамтын ажиллагааны маргаан

Зээлийн гэрээний талуудын ойр дотнын харилцаа, хамтын ажиллагаанаас үүдэлтэй “REASON 3: Итгэлцэл, харилцаа, хамтын ажиллагааны маргаан”-ы зан үйлийг урьдчилан таамаглах зорилгоор логистик регрессийн шинжилгээ хийж, үр дүнг дараах хүснэгтүүдэд тайлбарлан харуулав.

Суурь ангилал: Логистик регрессийн суурь загвараар нөлөөлөх хүчин зүйлсийг оруулахаас өмнөх ангиллын тархалтыг авч үзэв. Нийт 138 кейсээс 126 нь “итгэлцлийн маргаан биш”, 12 нь “итгэлцэл, харилцаанаас үүдэлтэй” маргаан байна. Загварт ямар нэгэн хувьсагч оруулаагүй нөхцөлд бүх кейсийг хамгийн өндөр давтамжтай ангилал руу онооход 91.3%-ийн нарийвчлал гарсан бөгөөд итгэлцэл, харилцаанаас шууд үүдэлтэй маргаан нийт маргааны 8.7%-ийг эзэлж байна.

Хүснэгт 38. Суурь ангилал /Classification table/

	Observed	Predicted		
		Итгэлцэл, харилцаа, хамтын ажиллагааны маргаан		Percentage Correct
		0	1	
Step 0	Итгэлцэл, харилцаа, хамтын ажиллагааны маргаан 0	126	0	100.0
	1	12	0	.0

Overall Percentage			91.3
--------------------	--	--	------

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Суурь загварын тогтмол: Дараагийн алхамд (Step 1) онолын хувьсагчдыг загварт оруулсны дараах таамаглах чадварын өөрчлөлтийг үнэлэх зорилгоор суурь загварыг авч үзэв. Үл хамаарах хувьсагчдыг оруулахаас өмнөх тогтмол утга Constant ($B=-2.351$), $Wald=60.578$, $p<0.001$ гарсан нь суурь ангиллын тархалт статистикийн ач холбогдолтой байгааг илтгэж байна. Мөн $Exp(B)=0.095$ гарсан нь “итгэлцэл, харилцааны маргаан” (Reason 3) нийт кейсийн маш бага хувийг эзэлж байгаатай (12/126) нийцэж байна. Өөрөөр хэлбэл, уг төрлийн маргаан нийт маргааны дунд харьцангуй бага давтамжтай (8.7%) байгааг харуулж байна.

Хүснэгт 39. Суурь загварын тогтмол /Variables in the Equation/

	B	S.E.	Wald	df	Sig.	Exp(B)
Step 0 Constant	-2.351	.302	60.578	1	.000	.095

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Суурь загварын статистик ач холбогдол: Загварт зан төлөв, итгэлцэл, эрх зүйн хүчин зүйлсийг оруулсны дараах нийт ач холбогдлыг үнэлэхэд $Chi-square=29.216$, $p=0.002$ гарсан нь сонгосон үл хамаарах хувьсагчид “итгэлцэл, харилцааны маргаан” (Reason3)-ыг тайлбарлахад статистикийн ач холбогдолтой байгааг илтгэж байна.

Хүснэгт 40. Суурь загварын статистик ач холбогдол /Omnibus Tests of Model Coefficients/

	Chi-square	df	Sig.
Step	29.216	11	.002
Step 1 Block	29.216	11	.002
Model	29.216	11	.002

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Суурь загварын тайлбарлах чадвар: Регрессийн загварын тайлбарлах чадварыг үнэлэхэд Nagelkerke $R^2=0.428$ гарсан нь загварт оруулсан зан төлөв болон итгэлцлийн хүчин зүйлс нь “итгэлцэл, харилцааны маргаан” (Reason3)-ын өөрчлөлтийн ойролцоогоор 42.8 хувийг тайлбарлаж байгааг илтгэж байна.

Хүснэгт 41. Суурь загварын тайлбарлах чадвар /Model summary/

Step	-2 Log likelihood	Cox & Snell R Square	Nagelkerke R Square
1	52.325 ^a	.191	.428

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Нарийвчилсан ангилал: Регрессийн загварт хүчин зүйлсийг оруулсны дараах таамаглах чадварын өөрчлөлтийг Хүснэгт 41-д харуулав. Шинжилгээний үр дүнгээр загварын нийт ангилалын нарийвчлал 91.3 хувиас 92.8 хувь болж өссөн байна. Мөн загвар нь

“итгэлцлийн маргаан биш” кейсүүдийг 99.2 хувийн өндөр нарийвчлалтай зөв ангилж байгааг харуулж байна.

Хүснэгт 42. Нарийвчилсан ангилал /Classification table/

	Observed	Predicted		
		Итгэлцэл, харилцаа, хамтын ажиллагааны маргаан		Percentage Correct
		0	1	
Step 1	Итгэлцэл, харилцаа, хамтын ажиллагааны маргаан 0	125	1	99.2
	ажиллагааны маргаан 1	9	3	25.0
Overall Percentage				92.8

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Хувьсагчдын нөлөөлөл: Маргаан үүсэхэд нөлөөлж буй гол хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор логистик регрессийн шинжилгээ хийв. Үр дүнд ТТ3 (эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл) хувьсагч статистикийн ач холбогдолтой (Sig=0.003) бөгөөд Exp(B)=10.71 гарсан нь уг нөхцөлд маргаан үүсэх магадлал бусад тохиолдлоос мэдэгдэхүйц өндөр байна. Харин ТТ2 (итгэлцэл тархах) хувьсагчийн Exp(B)=15.190 гарсан боловч Sig=0.134 байгаа нь статистикийн ач холбогдол хангалтгүй байна.

Хүснэгт 43. Хувьсагчдын нөлөөлөл /Variables in the Equation/

	B	S.E.	Wald	df	Sig.	Exp(B)	95% C.I. for EXP(B)	
							Lower	Upper
Step 1 ^a	BAIRSHIL	-.273	.793	.118	1	.731	.761	.161 3.605
	Q3_CODE	.256	.779	.108	1	.742	1.292	.280 5.953
	Q4_CODE	-.597	1.290	.214	1	.644	.551	.044 6.897
	TT2	2.721	1.818	2.241	1	.134	15.190	.431 535.351
	TT3	2.372	.810	8.584	1	.003	10.718	2.193 52.392
	BLE1	2.121	1.581	1.799	1	.180	8.339	.376 184.932
	BLE2	.467	1.330	.123	1	.726	1.595	.118 21.640
	BLE3	-23.682	40192.962	.000	1	1.000	.000	.000 .
	BLE4	.409	.949	.186	1	.667	1.505	.234 9.669
	FIE2	-21.689	5684.015	.000	1	.997	.000	.000 .
	FIE3	25.208	4019.962	.000	1	.999	886.411	.000 .
	Constant	-3.859	1.917	4.054	1	.044	.021	

Логистик регрессийн шинжилгээний үр дүнгээр итгэлцэл, харилцаанаас үүдэлтэй маргаанд “эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл” (ТТЗ) хувьсагч статистикийн ач холбогдолтой ($p=0.003$) гарсан бөгөөд $\text{Exp}(B)=10.71$ байгаа нь уг нөхцөлд маргаан үүсэхтэй мэдэгдэхүйц холбоотой байгааг илтгэж байна. Зээлдүүлэгч зээл олгохдоо зээлдэгчийн эрсдэлийг бодитой үнэлэхгүй, зөвхөн итгэлцэлд тулгуурласан харилцаа нь маргаан үүсэх эрсдэлтэй уялдаатай байж болохыг харуулж байна. Иймд судалгааны Н2: “Ойр дотнын, итгэлцэлд суурилсан харилцаа маргаанд өртөх магадлал өндөр” гэсэн таамаглал статистикийн үр дүнгээр дэмжигдэж байна.

Reason4: Гуравдагч этгээдтэй холбоотой маргаан

Зээлийг өөр этгээдэд дамжуулах, эсхүл өөр хүний нэр дээр авахтай холбоотой маргаан нийт кейсийн 29.7 хувийг эзэлж байна. Энэ төрлийн маргаан нь зээлийн харилцаанд гуравдагч этгээд оролцсоноос үүдэн хариуцлагын субъект тодорхойгүй болох нөхцөлийг бүрдүүлж байгаагаараа онцлогтой. Иймд “REASON 4: Гуравдагч этгээдтэй холбоотой маргаан”-ы зан үйлийг урьдчилан таамаглах зорилгоор логистик регрессийн шинжилгээ хийж, үр дүнг дараах хүснэгтүүдэд тайлбарлан харуулав.

Суурь ангилал: Судалгаанд хамрагдсан 138 кейсээс 41 нь “гуравдагч этгээдтэй холбоотой”, 97 нь “гуравдагч этгээдтэй холбоогүй” маргаан байна. Загварт ямар нэгэн хувьсагч оруулаагүй нөхцөлд бүх кейсийг хамгийн өндөр давтамжтай ангилалд (0) онооход 70.3 хувийн нарийвчлал гарсан байна. Энэхүү суурь үзүүлэлт нь гуравдагч этгээдийн оролцоо нийт маргааны 29.7 хувийг эзэлж байгааг харуулж, судалгаанд авч үзсэн шалтгаануудын дундаас харьцангуй өндөр жинтэй байгааг илтгэж байна.

Хүснэгт 44. Суурь ангилал /Classification table/

	Observed	Predicted		
		Гуравдагч этгээдтэй холбоотой		Percentage Correct
		0	1	
Step 0	0	97	0	100.0
	1	41	0	.0
Overall Percentage				70.3

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Суурь загварын тогтмол: Суурь загварын тогтмол үзүүлэлтийг үнэлэхэд Constant (B)=-0.861, Wald=21.371, $p<0.001$ гарсан нь суурь ангиллын тархалт статистикийн ач холбогдолтой байгааг илтгэж байна. Мөн $\text{Exp}(B)=0.423$ гарсан нь “гуравдагч этгээдтэй холбоотой” маргаан (41 кейс) нь “холбоогүй” маргаанаас (97 кейс) харьцангуй бага байгаатай нийцэж байна. Энэхүү үр дүн нь суурь загварын тархалт санамсаргүй бус байгааг харуулж, цаашид хувьсагчдын нөлөөг шинжлэх үндэслэл болж байна.

Хүснэгт 45. Суурь загварын тогтмол /Variables in the Equation Reason 4/

	B	S.E.	Wald	df	Sig.	Exp(B)
Step 0 Constant	-.861	.186	21.371	1	.000	.423

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Суурь загварын статистик ач холбогдол: Загварт зан төлөв, итгэлцэл, эрх зүйн хүчин зүйлсийг оруулсны дараах нийт ач холбогдлыг үнэлэхэд Chi-square=167.915, $p < 0.001$ гарсан нь сонгосон үл хамаарах хувьсагчид “гуравдагч этгээдтэй холбоотой маргаан” (Reason4)-ыг тайлбарлахад статистикийн ач холбогдолтой байгааг илтгэж байна.

Хүснэгт 46. Суурь загварын статистик ач холбогдол /Omnibus Tests of Model Coefficients/

	Chi-square	df	Sig.
Step	167.915	11	.000
Step 1 Block	167.915	11	.000
Model	167.915	11	.000

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Суурь загварын тайлбарлах чадвар: Загварын тайлбарлах чадварыг үнэлэхэд Nagelkerke $R^2=1.000$ гарсан нь хамаарах хувьсагчийг бүрэн тайлбарлаж байгааг илтгэж байна. Гэвч ийм өндөр үзүүлэлт нь өгөгдлийн бүтэц, хувьсагчдын давхардал, эсхүл статистикийн бүрэн ялгарал (perfect separation) үүссэн байж болох тул үр дүнг логистик регрессийн хүрээнд шууд дүгнэлт болгон ашиглахад хязгаарлалттайг харуулж байна.

Хүснэгт 47. Суурь загварын тайлбарлах чадвар /Model Summary/

Step	-2 Log likelihood	Cox & Snell R Square	Nagelkerke R Square
1	.000 ^a	.704	1.000

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Reason4 буюу гуравдагч этгээдтэй холбоотой маргаанд хийсэн логистик регрессийн шинжилгээгээр загварын тайлбарлах чадвар Nagelkerke $R^2=1.000$, -2 Log likelihood=0.000 гарсан нь загварт статистикийн бүрэн ялгарал (perfect separation) үүссэнийг илтгэж байна. Энэ нь зарим тайлбарлагч хувьсагчид (TT2, BLE1, BLE2, BLE3, FIE2, FIE3) хамаарах хувьсагчийг бараг бүрэн ялган ангилж байгаатай холбоотой бөгөөд коэффициентууд хэт өндөр, тогтворгүй утгатай болсон байна. Үүний улмаас коэффициентуудын найдвартай байдлыг илэрхийлэх статистик үнэлгээ хийх боломж хязгаарлагдсан байна. Ийм үр дүн нь зөвхөн хувьсагчдын давхардлаас гадна гуравдагч этгээдийн оролцоо нь зан төлөв болон итгэлцлийн хүчин зүйлстэй нягт уялдаатай, давхар илрэх онцлогтой байгаатай холбоотой байж болохыг харуулж байна.

Өөрөөр хэлбэл, уг маргаан нь бие даасан шалтгаан гэхээс илүүтэйгээр зан төлөв, итгэлцлийн хүчин зүйлсийн илрэл хэлбэрээр илэрч байгаа нь загварын тайлбарлах чадварыг хэт өндөр болгох нөхцөл бүрдүүлсэн байна. Ийм нөхцөлд логистик регрессийн

үр дүнг шууд шалтгаан-хамаарлын дүгнэлт болгон ашиглахад хязгаарлалттай тул уг шалтгааныг тайлбарлахдаа регрессийн үр дүнг шууд ашиглалгүй, тодорхойлох болон хамаарлын шинжилгээний үр дүнтэй уялдуулан дүгнэлт хийв.

Reason5: Гүйцэтгэл, үлдэгдэл, хүү алданги, тооцооны маргаан

Зээлийг хүлээн зөвшөөрсөн боловч төлбөрийн дүн, хүүгийн тооцооллоос үүдэлтэй маргаан нийт кейсийн 16 хувийг эзэлж байна. Иймд “REASON 5: Тооцооны маргаан”-ы зан үйлийг урьдчилан таамаглах зорилгоор логистик регрессийн шинжилгээ хийж, үр дүнг дараах хүснэгтүүдэд тайлбарлан харуулав.

Суурь ангилал: Логистик регрессийн суурь загвараар онолын хувьсагчдыг оруулахаас өмнөх ангиллын тархалтыг авч үзэв. Нийт 138 кейсээс 116 нь “тооцооны маргаан биш”, 22 нь “тооцооны маргаан” байна. Загварт ямар нэгэн хувьсагч оруулаагүй нөхцөлд бүх кейсийг хамгийн өндөр давтамжтай ангилалд (0) онооход 84.1 хувийн нарийвчлал гарсан. Энэхүү үр дүн нь тооцооны маргаан нийт кейсийн харьцангуй бага хувийг эзэлж байгааг харуулж, зээлийн маргааны дийлэнх нь үүрэг үгүйсгэх болон гуравдагч этгээдтэй холбоотой шалтгаантай байна.

Хүснэгт 48. Суурь ангилал /Classification Table^{a,b}/

	Observed	Predicted		
		Гүйцэтгэл, үлдэгдэл, хүү/алданги, тооцооны маргаан		Percentage Correct
		0	1	
Step 0	Гүйцэтгэл, үлдэгдэл, хүү/алданги, тооцооны маргаан	116	0	100.0
		22	0	.0
	Overall Percentage			84.1

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Суурь загварын тогтмол: Суурь загварын тогтмол үзүүлэлтийг үнэлэхэд Constant (B)=-1.663, Wald=51.115, $p<0.001$ гарсан нь суурь ангиллын тархалт статистикийн ач холбогдолтой байгааг илтгэж байна. Мөн $\text{Exp}(B)=0.190$ гарсан нь “тооцооны маргаан” (22 кейс) нь “тооцооны маргаан биш” (116 кейс) ангиллаас харьцангуй бага байгаатай нийцэж байна. Энэхүү үр дүн нь суурь тархалт санамсаргүй бус байгааг харуулж, цаашид хувьсагчдын нөлөөг шинжлэх үндэслэл болж байна.

Хүснэгт 49. Суурь загварын тогтмол /Variables in the Equation/

	B	S.E.	Wald	df	Sig.	Exp(B)
Step 0 Constant	-1.663	.233	51.115	1	.000	.190

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Суурь загварын статистик ач холбогдол: Загварт зан төлөв, итгэлцэл, эрх зүйн хүчин зүйлсийг оруулсны дараах нийт ач холбогдлыг үнэлэхэд Chi-square=69.441, $p<0.001$

гарсан нь сонгосон үл хамаарах хувьсагчид “тооцооны маргаан” (Reason5)-ыг тайлбарлахад статистикийн ач холбогдолтой байгааг илтгэж байна.

Хүснэгт 50. Суурь загварын статистик ач холбогдол /Omnibus Tests of Model Coefficients/

		Chi-square	df	Sig.
Step 1	Step	69.441	11	.000
	Block	69.441	11	.000
	Model	69.441	11	.000

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Суурь загварын тайлбарлах чадвар: Загварын тайлбарлах чадварыг үнэлэхэд Nagelkerke $R^2=0.677$ гарсан нь зан төлөв болон итгэлцлийн хүчин зүйлс нь “тооцооны маргаан” (Reason 5)-ын өөрчлөлтийн ойролцоогоор 67.7 хувийг тайлбарлаж байгааг илтгэж байна. Энэ нь уг загварын тайлбарлах чадвар харьцангуй өндөр түвшинд байгааг харуулж байна.

Хүснэгт 51. Суурь загварын тайлбарлах чадвар /Model Summary/

Step	-2 Log likelihood	Cox & Snell R Square	Nagelkerke R Square
1	51.642 ^a	.395	.677

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Нарийвчилсан ангилал: Загварт үл хамаарах хувьсагчдыг оруулсны дараах таамаглах чадварын өөрчлөлтийг үнэлэхэд загварын нийт ангилалтын нарийвчлал 84.1 хувиас 89.1 хувь болж өссөн байна. Мөн загвар нь “тооцооны маргаан” (Reason5)-ын бодит кейсүүдийг 81.8 хувийн нарийвчлалтай зөв ангилж байгааг харуулж байна.

Хүснэгт 52. Нарийвчилсан ангилал /Classification table/

	Observed	Predicted		
		Гүйцэтгэл, үлдэгдэл, хүү/алданги, тооцооны маргаан		Percentage Correct
		0	1	
Step 1	Гүйцэтгэл, үлдэгдэл, 0	105	11	90.5
	хүү/алданги, тооцооны маргаан 1	4	18	81.8
Overall Percentage				89.1

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Хувьсагчдын нөлөөлөл: ТТЗ (эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл) хувьсагчийн $Sig=0.011$, $Exp(B)=0.050$ гарсан нь уг хүчин зүйл “тооцооны маргаан” (Reason5)-тай статистикийн ач холбогдолтой бөгөөд сөрөг чиглэлийн холбоотой байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, итгэлцэлд тулгуурласан харилцаа өндөр байх үед тооцооны маргаан үүсэхтэй

харьцангуй сул холбоотой байж болохыг харуулж байна. Энэ нь корреляцийн шинжилгээний үр дүнтэй (TT3 ба Reason 5 хооронд $r = -0.224$) нийцэж байна. Мөн BLE4 (хэт өөдрөг төсөөлөл) хувьсагчийн $p < 0.001$ гарсан нь уг зан төлөвийн хүчин зүйл тооцооны маргаантай статистикийн ач холбогдолтой холбоотой байгааг илтгэж байгаа боловч сөрөг чиглэлтэй хамаарал ($r = -0.239$) илэрсэн нь зан төлөвийн нөлөө нь маргааны хэлбэрийг өөрчлөх боломжтойг харуулж байна.

Хүснэгт 53. Хувьсагчдын нөлөөлөл /Variables in the Equation/

	B	S.E.	Wald	df	Sig.	Exp(B)	95% C.I. for EXP(B)	
							Lower	Upper
BAIRSHIL	1.246	.836	2.219	1	.136	3.475	.675	17.892
Q3_CODE	.923	.803	1.320	1	.251	2.516	.521	12.143
Q4_CODE	-.327	.911	.129	1	.719	.721	.121	4.299
TT2	-21.794	23928.723	.000	1	.999	.000	.000	.
TT3	-3.000	1.177	6.501	1	.011	.050	.005	.500
BLE1	14.968	17961.595	.000	1	.999	316.551	.000	.
BLE2	-.860	16880.929	.000	1	1.000	.423	.000	.
BLE3	.245	41018.554	.000	1	1.000	1.278	.000	.
BLE4	-35.044	8502.249	.000	1	.997	.000	.000	.
FIE2	.186	28911.133	.000	1	1.000	1.205	.000	.
FIE3	-21.245	40192.970	.000	1	1.000	.000	.000	.
Constant	-.938	16880.929	.000	1	1.000	.391		

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, SPSS

Reason5 буюу гүйцэтгэл, үлдэгдэл, хүү, алданги болон тооцооны маргаанд хийсэн логистик регрессийн шинжилгээгээр загварын тайлбарлах чадвар харьцангуй өндөр (Nagelkerke $R = 0.677$), ангиллын нийт нарийвчлал 89.1 хувь гарсан нь уг загварын тайлбарлах чадвар сайн байгааг илтгэж байна. Шинжилгээний үр дүнд итгэл дээр суурилсан харилцааны хүчин зүйл (TT3) статистикийн ач холбогдолтой ($p = 0.011$) гарсан бөгөөд уг хувьсагч нь тооцооны маргаантай сөрөг чиглэлтэй холбоотой байгааг илтгэж байна. Харин байршил, гэрээний хэлбэр, барьцааны хүчин зүйлс нь статистикийн ач холбогдолгүй гарсан байна.

4.2 Шинжилгээний үр дүн

Иргэд хоорондын зээлийн гэрээний маргааны шалтгааныг судалгаанд хамрагдсан нийт 138 кейсийн шинжилгээний үр дүнд үндэслэн үүрэг гүйцэтгээгүй, маргаан үүссэн шалтгааныг 5 үндсэн хүчин зүйл буюу шалтгаанаар ангилсан. Эдгээр 5 үндсэн шалтгаанаар шинжилгээнээс гарсан үр дүнгээр маргааны үндсэн шалтгааны бүтцийг авч үзвэл:

Зураг 21. Маргааны үндсэн шалтгааны бүтэц (n=138)



Нийт маргааны шалтгааныг авч үзвэл гуравдагч этгээдтэй холбоотой маргаан (Reason 4) хамгийн өндөр буюу 29.7%-ийг (41 кейс), гэрээ үүргийг үгүйсгэсэн маргаан (Reason 1) 27.5%-ийг (38 кейс) тус тус эзэлж байгаа нь зээлийн маргаан зөвхөн зээлдэгчийн төлбөрийн чадваргүй байдлаас бус, харин зээл авсан гэдгээ хүлээн зөвшөөрөхгүй, зээлийг өөр хүнээс авсан эсхүл өөр хүнд дамжуулан зээлсэн гэх шалтгаанаар үүргийн үүсэл, гүйцэтгэлийг санаатайгаар үгүйсгэх зан үйлтэй холбоотой байна.

Маргааны үндсэн шалтгаанд хамгийн их нөлөөлж буй үл хамаарах хувьсагчдыг судалгаанд хамрагдсан 138 кейсийн статистик шинжилгээний үр дүнг нэгтгэн хүснэгтээр харуулав. (Хүснэгт 54-ыг үзнэ үү)

Хүснэгт 54. Гол хүчин зүйлсийн давхцал ба нөлөөлөл (n=138)

№	Хувьсагч	Кейс	Хувь (%)	Статистик ач холбогдол	Нөлөөллийн чиглэл	Нөлөөллийн түвшин	Гол нөлөөлөх Шалтгаан /Reason	Тайлбар
1	ТТ1 Гэрээний тодорхойгүй байдал ба үүрэг үгүйсгэл	103	74.60%	$p < 0.001$	Шууд	Өндөр	R1, R3, R5	Гэрээ тодорхой бус байдал нь BLE2-той давхцан үүргийн агуулгыг маргаантай болгодог.

2	BLE2 “Би биш”	96	70.00%	$p < 0.001$	Шууд (сөрөг)	Өндөр	R1, R4, R5	Хариуцлагаас зайлсхийх зан төлөв нь TT1, FIE1-тэй давхцан үүрэг үгүйсгэх, шилжүүлэхэд хүргэдэг.
3	FIE1 Баримтгүй олголт ба төлөлт	55	39.90%	$p < 0.001$	Шууд	Дунд-Өндөр	R1, R5	Баримт сул байдал нь TT1, BLE2-той давхцан үүрэг үгүйсгэх нөхцөлийг бүрдүүлдэг.
4	TT2 Итгэлцэл 3-гч этгээдэд "тархах", хяналт алдагдах	43	31.20%	$p < 0.001$	Эерэг	Өндөр	R4	Итгэлцэл гуравдагч этгээдэд тархах нь FIE2, BLE2-той давхцан хариуцлага шилжих нөхцөл болдог.
5	FIE2 Гэрээнд оролцоогүй этгээд	41	29.70%	$p < 0.001$	Шууд	Өндөр	R4	Гэрээнд оролцоогүй этгээдийн оролцоо нь TT2, BLE2-той давхцан үүргийг сарниулдаг.
6	TT3 Эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл	38	27.50%	$p = 0.003-0.011$	Холимог	Дунд-Өндөр	R3, R1	Эрсдэл үнэлээгүй итгэлцэл нь BLE4-тэй давхцан гэрээний ойлголтын зөрүү үүсгэдэг.
7	BLE4 Хэт өөдрөг төсөөлөл ба эрсдэлийн алдаа	32	23.20%	$p = 0.044$	Шууд	Дунд	R1, R2	Эрсдэлийг буруу үнэлэх нь TT3-тэй давхцан зээлийн харилцааг эрсдэлтэй нөхцөлд байгуулахад хүргэж, улмаар үүргийн гүйцэтгэл алдагдах шалтгаан болж байна.
8	FIE3 Гэрээний тодорхой бус төрөл	19	13.80%	$p < 0.001$	Шууд	Дунд	R3, R5	Гэрээний төрөл тодорхой бус байдал нь TT1-тэй давхцан харилцаа холилдох нөхцөл болдог.
9	BLE3 Ашиггүй үеийн стратегийн үгүйсгэл	18	13.00%	$p < 0.05$	Шууд (сөрөг)	Дунд	R2	Ашиггүй нөхцөлд үүрэг үгүйсгэх нь BLE4-тэй давхцан илэрдэг.
10	BLE1 Хойшлуулах, хайхрамжгүй байдал	6	4.30%	$p > 0.05$	Сул	Сул	-	Бусад хүчин зүйлтэй сул давхцалтай, нөлөө бага

Хүснэгтэд тусгагдсан үл хамаарах хувьсагчдын статистикийн ач холбогдол, нөлөөллийн шинж болон логистик регрессийн үр дүнгээс харахад зээлийн маргаан нь бие даасан хүчин зүйлсээс бус харин зан төлөв, итгэлцэл, баримтжуулалтын сул байдал зэрэг хүчин зүйлс давхцан илрэх үед үүсэж, маргаан үүсэх магадлал нэмэгдэж байна.

Гэрээний тодорхойгүй байдал (TT1 74.6%) болон хариуцлагаас зайлсхийх зан төлөв (BLE2 70.0%) нь нийт кейсийн дийлэнхэд хамт илэрч, үүргийн агуулга тодорхой бус нөхцөлд зээлдэгч үүргээ үгүйсгэх болон харилцааны ойлголтын зөрүү үүсгэхэд хүргэснээр гэрээ, үүргийг үгүйсгэсэн (Reason1), итгэлцэл, харилцааны (Reason3) болон гүйцэтгэл, үлдэгдлийн (Reason5) маргаанд нөлөөлснөөр зээлдэгч хариуцлагаас зайлсхийх замаар үүргээ үгүйсгэх нөхцөл бүрдэж байна.

Баримтгүй олголт, төлөлт (FIE1 39.9%) нь гэрээний тодорхойгүй байдал (TT1) болон хариуцлагаас зайлсхийх зан төлөв (BLE2)-тэй давхцан илрэх үед үүрэг үүссэн эсэх болон үлдэгдлийн талаар маргаан (Reason1, Reason5) үүсгэж, нотлох баримтын сул талыг ашиглан зээлдэгч үүргээ үгүйсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Итгэлцэл гуравдагч этгээдэд тархах (TT2 31.2%) болон гэрээнд оролцоогүй этгээдийн оролцоо (FIE2 29.7%) нь давхцан илрэх үед үүргийн хариуцлага анхны талуудаас салж тодорхой бус болохын зэрэгцээ гуравдагч этгээдэд шилжих нөхцөл бүрдэж, улмаар гуравдагч этгээдтэй холбоотой маргаанд (Reason4) нөлөөлөхөөс гадна зээлдэгчид хариуцлагаас зайлсхийх боломж олгож байна.

Эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл (TT3) буюу барьцаагүй, бичгээр гэрээгүй, зээлдэгчийн бодит төлбөрийн чадварыг үнэлээгүй олгосон зээл болон зээлдэгчийн өөрийн төлбөрийн чадварыг хэт өөдрөгөөр төсөөлсөн зан төлөв (BLE4) нь ихэвчлэн хамт илэрч, зээлийн харилцаа эрсдэлийг бодитоор үнэлээгүй нөхцөлд үүссэнээр харилцааны ойлголтын зөрүү болон үүрэг үгүйсгэх маргаанд (Reason3, Reason1) нөлөөлөхөөс гадна зээлдэгчид үүргийн нөхцөлийг өөрийн талд ашигтайгаар тайлбарлах боломжийг бүрдүүлж байна.

Гэрээний төрөл тодорхой бус байдал (FIE3) нь итгэлцлийн хүчин зүйлстэй давхцан илрэх үед зээлийн гэрээг бусад харилцааны хэлбэрээс ялгахад хүндрэл үүсч, улмаар харилцааны болон гүйцэтгэлийн маргаанд (Reason3, Reason5) нөлөөлөхөөс гадна зээлдэгчид үүргийн шинжийг өөрөөр тайлбарлах боломжийг бүрдүүлж байна.

Иймд зээлийн маргаан нь нэг хүчин зүйлээс бус буюу (1) гэрээний тодорхойгүй байдал, (2) хариуцлагаас зайлсхийх зан төлөв, (3) баримтжуулалтын сул байдал, (4) гуравдагч этгээдийн оролцоо, (5) эрсдэлийн буруу үнэлгээ зэрэг хүчин зүйлс давхцан илрэх тохиолдолд нийлмэл байдлаар үүсэж байна гэж үзэж байна.

Судалгаанд дэвшүүлсэн таамаглалуудыг Trust Theory, Behavioral Law and Economics болон Formal vs Informal Enforcement онолуудад тулгуурлан боловсруулж, 2021–2025 оны хооронд шүүхээр шийдвэрлэгдсэн 138 кейст хийсэн агуулгын болон статистик шинжилгээний үр дүнд тулгуурлан шалгав. Давтамжийн шинжилгээ, Chi-square болон Logistic Regression шинжилгээний үр дүнд үндэслэн таамаглалуудын дэмжигдсэн байдлыг дараах хүснэгтээр харуулав. (Хүснэгт 55-ыг үзнэ үү)

Хүснэгт 55. Таамаглалын үр дүн /эмпирик шинжилгээний үр дүнгээр/

Таамаглал	Онолын үндэслэл	Шалгасан хувьсагч	Шалгасан шинжилгээ	Үр дүн
H1. Гэрээний тодорхойгүй байдал маргаан үүсэх магадлалыг нэмэгдүүлнэ.	Trust Theory	TT1, FIE1 гэрээний хэлбэр	Frequency, Chi-square	TT1 хувьсагч нь Reason1 болон Reason5 төрлийн маргаантай статистикийн ач холбогдолтой хамааралтай гарсан ($p<0.001$). FIE1 болон гэрээний хэлбэртэй холбоотой баримтжуулалтын сул байдал маргаан нэмэгдэх нөхцөл болж байна.
H2. Ойр дотнын, итгэлцэлд суурилсан харилцаа маргаанд өртөх магадлал өндөр.	Trust Theory, Informal Enforcement	TT2, FIE2, барьцаатай эсэх	Frequency, Chi-square	TT2 болон FIE2 хувьсагчид гуравдагч этгээдтэй холбоотой Reason4 төрлийн маргаантай статистикийн ач холбогдолтой хамааралтай гарсан ($p<0.001$).
H3. Зээлдэгчийн төлбөрийн чадвараас гадна хариуцлагын сул зан төлөв үүргийн гүйцэтгэлд нөлөөлнө.	Behavioral Law and Economics	BLE1, BLE2, BLE4	Frequency, Chi-square, Logistic Regression	BLE2 хувьсагч нь үүргээс зайлсхийх зан төлөвтэй статистикийн ач холбогдолтой хамааралтай гарсан ($p<0.001$) бол BLE4 хувьсагч нь эрсдэлийг буруу үнэлэх, хэт өөдрөг төсөөллийн зан төлөв маргаанд нөлөөлж байгааг харуулсан.
H4. Иргэдийн эрх зүйн мэдлэг, гэрээний соёл сайжрах нь маргаан бууруулна.	Formal vs Informal Enforcement	FIE1, FIE3 гэрээний баримтжуулалт	Frequency, Chi-square	FIE1, FIE3 хувьсагчид буюу баримтжуулалт сул, гэрээний төрөл тодорхойгүй кейсүүдэд маргаан өндөр илэрсэн нь гэрээний соёл сул байгааг харуулсан.

Хүснэгтээр харуулсан шинжилгээний үр дүнгээс үзэхэд судалгаанд дэвшүүлсэн H1-H4 таамаглалууд нь онолын болон эмпирик түвшинд дэмжигдэж байна.

H1 таамаглалын хүрээнд нийт кейсийн 74.6%-д гэрээний тодорхойгүй байдал болон баримтжуулалтын сул байдал илэрсэн бөгөөд гэрээний агуулга тодорхой бус, баримтжуулалт хангалтгүй үед зээлдэгч үүрэг үүссэн эсэх, үүргийн хэмжээ, гүйцэтгэлийн нөхцөлийг маргах боломж нэмэгдэж байна. Ингэснээр мөнгө аваагүй, зээл биш гэх зэргээр үйл ойлголцол үүсгэхээс гадна зээлийн дүнг хүлээн зөвшөөрөхгүй байх давуу нөхцөлийг зээлдэгчид бий болгож байгаа нь гэрээ тодорхой бус байх тусам маргаан үүсэх эрсдэл нэмэгдэж байгааг харуулж байна.

H2 таамаглалын хүрээнд итгэлцэл нь талуудын харилцаанаас хальж зээлдэгч болон зээлдүүлэгч өөрийн танил, садан төрөл, найз нөхдөөр зээлийг дамжуулах, шилжүүлэх үед гуравдагч этгээдтэй холбоотой үндсэн маргааны шалтгааныг үүсгэж байна. Мөн зээл олгох үед баримтжуулалтгүй зөвхөн итгэлцэлд тулгуурласан байдал нь үүргээ бүхэлд нь үгүйсгэх болон харилцааны маргаан үүсэх хүчин зүйл болж байна.

H3 таамаглалын хүрээнд нийт кейсийн 70%-д “би биш” гэх хариуцлагаас зайлсхийх зан төлөв илэрсэн бөгөөд “би мөнгийг өөр хүнд өгсөн”, “зээл биш тусламж байсан”, “хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт” гэх тайлбарууд түгээмэл байна. Энэ нь үүргээс зайлсхийх болон үүргээ үгүйсгэх зан төлөв маргаан үүсэхэд хүчтэй нөлөөлж байгааг харуулж байна. Түүнчлэн зээл авах үедээ эргэн төлөх чадвараа бодитоор үнэлээгүй, хэт

өөдрөг төсөөлөлтэй байсан зан төлөвийн хүчин зүйлс нь үүргийн гүйцэтгэл хангагдахгүй болох эрсдэлийг нэмэгдүүлж байгаа нь тогтоогдсон.

Н4 таамаглалын хүрээнд гэрээний нөхцөл тодорхойгүй, баримтжуулалт сул үед талуудын хооронд үүргийн агуулга, төлбөр тооцоо болон гэрээний хэлбэртэй холбоотой үл ойлголцол үүсч маргах нөхцөл бүрдэж байна. Гэрээний талууд ихэвчлэн танилын хүрээний итгэлцэлд тулгуурласан, байнгын шинжтэй харилцаанд оролцож байгаа нь гэрээний соёл сул байгааг харуулж байна. Харин гэрээний нөхцөл тодорхой, баримтжуулалт сайтай байх нь маргаан үүсэх нөхцөлийг бууруулах боломжтой болох нь судалгааны үр дүнгээр ажиглагдсан.

4.3 Шүүн хэлэлцэхүй

Судалгаанд хамрагдсан нийт 138 кейст хийсэн шинжилгээний үр дүнгээс үзэхэд 25 кейс буюу нийт маргааны 18.1 хувь нь зээлдэгчийн санхүүгийн боломжгүй байдалтай холбоотой байсан бол дийлэнх хувь нь зан төлөв, итгэлцэл болон баримтжуулалтын хүчин зүйлстэй холбоотой үр дүн гарсан. Тухайлбал нийт кейсийн 70%-д “би биш”, “мөнгө өөр хүнд өгсөн”, “зээл биш байсан” гэх байдлаар үүргээс зайлсхийх хандлага илэрсэн нь зан төлөвийн хүчин зүйлс маргаан үүсэхэд илүү нөлөөлж байгааг харуулж байна.

Энэхүү үр дүн нь судалгаа, зөвлөх үйлчилгээний Оптимал Эн Макс ХХК-ийн “Сэтгэл зүйн хүчин зүйлсийн зээлийн эрсдэлд үзүүлэх нөлөө: Монгол дахь микро зээлийн үйлчилгээний кейс судалгаа”-ны үр дүнтэй нийцэж байна. Тус судалгаанд гар утасны зээлийн аппликейшн ашигласан 1118 зээлдэгчийн мэдээлэлд үндэслэн зээлийн эрсдэлийг зөвхөн материаллаг хүчин зүйлээр бус хувь хүний зан төлөвийн хүчин зүйлээр тодорхойлох шаардлагатай гэж дүгнэсэн байдаг. Тухайлбал хувь хүний өөрийгөө хянах чадвар (Self-Control Ratio-SCR) болон үр дүнтэй санхүүгийн шийдвэр гаргах чадвар (Effective Decision Making-EDM) нь зээлийн эрсдэлийг илүү сайн таамаглаж байгааг дурдсан нь бидний судалгааны BLE2, BLE4 хувьсагчдын үр дүнтэй ижил хандлагатай байна.

Мөн судалгааны үр дүнд зээлдэгчид ирээдүйд үүсэх үр дагаврыг дутуу үнэлэх (BLE4), эсхүл “мөнгө аваагүй”, “зээл биш байсан” гэх байдлаар болсон үйл баримт болон гэрээний нөхцөлийг өөрт ашигтайгаар тайлбарлаж, үүрэг хариуцлагаас зайлсхийх (BLE2) хандлага түгээмэл ажиглагдсан. Энэ нь судлаач Э.Мандалмаагийн “Good Faith in Mongolia” судалгаанд дурдсан Монгол хүмүүс ойрын хугацааны зорилго, ашиг сонирхолд илүү төвлөрөх (Short-Term Orientation) зан төлөвтэй бөгөөд энэ нь зээл, төлбөрийн харилцаанд “маргаашийн соёл” буюу үүргийн үр дагаврыг хойш тавих хандлага бий болгодог гэсэн тайлбартай нийцэж байна. Өөрөөр хэлбэл зээл авах үедээ эргэн төлөх эрсдэлийг хангалттай тооцоолохгүй байх, харин маргаан үүссэний дараа нөхцөл байдлыг өөрт ашигтай байдлаар тайлбарлах хандлага иргэд хоорондын зээлийн маргаанд нийтлэг илэрч байна.

Түүнчлэн судалгаа, зөвлөх үйлчилгээний SICA компанийн “Монголчуудын соёл болон монгол хүний зан төлөвийг тодорхойлох” судалгаа болон хараат бус судалгааны хүрээлэн IRIM-ийн “Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-ны тайланд Монголчууд

хамт олонч соёлтой бөгөөд итгэлцэл нь өргөн нийгмийн хүрээнд бус, ойр дотно харилцаанд төвлөрсөн шинжтэй гэж дүгнэсэн байдаг. Энэхүү соёлын онцлог нь иргэд хоорондын зээлийн харилцаанд мөн адил илэрч байгаа бөгөөд “бид танил хүмүүс учраас гэрээ, баримтжуулалт шаардлагагүй” гэх хандлагаас шалтгаалан эрх зүйн баталгаажуулалтыг орхигдуулах нөхцөл болж байна. Үүний улмаас нийт кейсийн 74.6%-д илэрсэн гэрээний тодорхойгүй байдал болон үүргийг үгүйсгэх (ТТ1) нөхцөл нэмэгдэж байгаа нь судалгааны үр дүнгээр тогтоогдсон.

Бүлгийн дүгнэлт

Энэ бүлэгт 138 кейст үндэслэн тодорхойлогч статистик, хамаарлын, корреляцийн болон логистик регрессийн шинжилгээ хийсний үр дүнд иргэд хоорондын зээлийн маргаан нь нэг хүчин зүйлээс бус зан төлөвийн хандлага, итгэлцлийн хэлбэр, харилцааны бүтэц болон гэрээний нөхцөлийн нийлмэл нөлөөн дор үүсдэг болохыг тогтоосон бөгөөд маргааны бүтцийн хувьд гуравдагч этгээдтэй холбоотой маргаан (29.7%) болон үүргийг үгүйсгэх маргаан (27.5%) зонхилж, харин санхүүгийн чадваргүй байдал (18.1%) болон тооцооны маргаан (15.9%) дунд түвшинд, итгэлцэл, харилцааны маргаан (8.7%) бага хувийг эзэлж байгаа нь маргааны гол шалтгаан нь санхүүгийн хүчин зүйлээс илүү зан төлөв болон харилцааны бүтэцтэй холбоотой болохыг харуулж байна.

Дээр дурдагдсан шинжилгээний үр дүнгээс харахад зан төлөв болон бусад хүчин зүйлс нэг кейсэд давхар илэрч байгаагаас шалтгаалан дундажаар нэг кейсэд ойролцоогоор 3 орчим хүчин зүйл зэрэгцэн нөлөөлж байгаа бөгөөд үүнээс зээлийн маргаан нь нэг шалтгаант бус, харин хэд хэдэн хүчин зүйл давхцан илрэх үед үүсэж, улмаар маргааны хэлбэр болон үр дагаварыг тодорхойлж байна. Тодруулбал, зээлдэгчийн хариуцлагаас зайлсхийх “би биш” хандлага (70%, 96 кейс) болон эрсдэлийг буруу үнэлэх зан төлөв (23%, 32 кейс) маргаан үүсэхэд голлон нөлөөлж байгаа бол итгэлцлийн хүчин зүйлсээс итгэлцэл гуравдагч этгээдэд тархах (31%, 43 кейс) болон эрсдэлийн үнэлгээгүй итгэлцэл нь маргааны хэлбэрийг тодорхойлоход нөлөөлж байгааг харуулж байна.

Судалгааны хүрээнд дэвшүүлсэн таамаглалууд нь эмпирик шинжилгээний үр дүнгээр дэмжигдсэн ба иргэд хоорондын зээлийн маргаан нь зээлдэгчийн зан төлөвөөс голлон шалтгаалж, зээлдүүлэгчийн итгэлцэл болон эрх зүйн хамгаалалтын сул байдалтай давхцах үед илүү тод илэрч, улмаар маргааны хэлбэрийг тодорхойлж байна гэж дүгнэж байна.

Энэхүү судалгааны үр дүн нь өмнөх судлаачдын зан төлөв, итгэлцэл болон гэрээний соёл зээлийн эрсдэл, маргаанд нөлөөлдөг гэсэн дүгнэлтүүдтэй нийцэж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар иргэд хоорондын зээлийн гэрээний маргааны нийтлэг шинж чанар, эрх зүйн зохицуулалтын онцлог болон маргааныг бууруулах боломжит арга замыг шүүхийн статистик, кейсийн шинжилгээ, харьцуулсан эрх зүйн судалгаа болон эмпирик шинжилгээний үр дүнд тулгуурлан судаллаа.

Иргэд хоорондын зээлийн маргаан 2021–2025 оны хооронд 925-аас 11,584 хэрэг, маргаан болж 12.5 дахин өссөн нь нийт иргэний хэрэг, маргааны өсөлтөөс өндөр үзүүлэлттэй байгаа бөгөөд шүүхийн үндсэн ачаалалд нөлөөлөх хэмжээнд байна. Нийт шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн 138 кейст хийсэн эмпирик шинжилгээний үр дүнгээс харахад маргаан үүссэн шалтгааны ердөө 18.1 хувь нь зээлдэгчийн санхүүгийн чадваргүй байдалтай холбоотой байсан бол үлдсэн дийлэнх нь зээлдэгчийн зан төлөв, хандлага (BLE2 “би биш” хандлага 70%), гэрээний тодорхойгүй байдал (ТТ1 74.6%) болон баримтжуулалт сул зэрэг хүчин зүйлстэй холбоотой байна.

Судалгааны үр дүнгээр зан төлөв, итгэлцэл болон гэрээний соёл нь зээлийн эрсдэлд нөлөөлдөг талаар өмнөх судлаачдын дэвшүүлсэн дүгнэлтүүдтэй нийцэж байна. Бусад судлаачдын зээлийн эрсдэлийг тодорхойлоход зээлдэгчийн өөрийгөө хянах чадвар болон санхүүгийн шийдвэр гаргалт зэрэг хувь хүний зан төлөвийн хүчин зүйл чухал нөлөө үзүүлдэг гэсэн судалгааны дүгнэлт ба Монголчуудын итгэлцэл ойрын хүрээний харилцаанд төвлөрдөг гэсэн соёлын онцлогийн ялгаа нь иргэд хоорондын зээлийн харилцаанд “танил хүмүүсийн хооронд гэрээ шаардлагагүй” гэх хандлагыг бий болгож, улмаар гэрээний тодорхойгүй байдал болон үүргийг үгүйсгэх нөхцөлд хүргэж байгааг шүүхийн кейсийн түвшинд баталгаажуулсан.

Эрх зүйн зохицуулалтын түвшинд авч үзвэл иргэд хоорондын зээлийн харилцаа нь банк, эрх бүхий этгээдийн зээлээс ялгаатай нь тусгай хяналт, стандарт баримтжуулалт болон эрсдэлийн удирдлагын тогтолцоогүй хэрэгжиж байгаа нь зээлдэгчийн үүргээ зохих ёсоор гүйцэтгэхгүй байхад нөлөөлж байна. Япон болон ОХУ-ын эрх зүйн зохицуулалттай харьцуулан үзэхэд “good faith” зарчим, төлбөр барагдуулах дараалал, хүүгийн зохицуулалт болон гэрээг бичгээр байгуулах шаардлагыг илүү нарийвчлан зохицуулсан нь зээлдэгчийн санхүүгийн сахилга батыг дэмжих, үүргийн гүйцэтгэлийг хангах эрх зүйн хөшүүргийг бүрдүүлж байна. Харин Монгол Улсын Иргэний хуулийн 216.4-т заасан төлбөр барагдуулах дараалалд үндсэн зээлийг эхэлж төлөхөөр зохицуулсан нь хүүгийн өрийг нэмэгдүүлэх, улмаар өрийн дарамтыг өсгөх эрсдэлийг бий болгож байна. Мөн Иргэний хуулийн 282.4-т заасан мөнгө буюу эд хөрөнгийг шилжүүлснээр гэрээ байгуулагдсанд тооцох зохицуулалт нь практикт гуравдагч этгээд оролцсон нөхцөлд хариуцлагын субъект тодорхойгүй болох хүндрэл үүсгэж байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Түүнчлэн шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын тогтолцооны хэрэгжилт сул, шийдвэрийг албадан биелүүлэх эрх зүйн баталгаа хангалтгүй байгаа нь талуудыг заавал шүүхэд хандахаас өөр аргагүй нөхцөлд хүргэж, шүүхийн ачааллыг бууруулах боломжийг хязгаарлаж байна. Иймээс иргэд хоорондын зээлийн маргааныг бууруулахад Иргэний хуулийн 216.4 болон 453.1, 282.3 дахь зохицуулалтыг санхүүгийн сахилга бат,

